ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ • 2020 ОНЫ НЭГДҮГЭЭР САР

Лиахона

Мормоны Ном судлахаа сайжруулах

нь, 5, 34, 38-р хуудаснууд

"Нэгээс илүү арга замаар" тохинуулж болно 8-р хуудас

ЕРӨНХИЙЛӨГЧ БАЛЛАРД

Дэлхийг Сэргээлтэд бэлтгэх Их Эзэний мутар 12-р хуудас

Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн

Есөн асуултад өгсөн Сүмийн удирдлагуудын хариулт 20-р хуудас

Өсвөр үеийнхэнд зорилгодоо хүрэхэд нь туслах дөрвөн арга зам 26-р хуудас

СҮМ
ЭНД
БИЙ

Герман

Лейпциг

© GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

1519 онд Лейпцигт Мартин Лютер протестант шашны шинэчлэлийг бэхжүүлсэн мэтгэлцээнд оролцож, дэлхийг Сэргээлтэд бэлтгэхэд тусалжээ.

Өнөөдрийн Германы Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн талаарх зарим мэдээ баримтыг дурдвал:

Гадас (нэг гадас нь Лейпцигийн төвд байрладаг) — 14

3 — Номлол

Ариун сүм — 2

Сүмийн гишүүн — 39917

Цуглаан — 152

1843 он Анхны цуглаан Дармстадтад зохион байгуулагдсан.

1961 он Гурван гадас байгуулагдсан.

1985 он Фрайберг ариун сүм тухайн үеийн Зүүн Германд онцгойлон адислагдсан ба 2016 онд уг ариун сүмийг дахин онцгойлон адисалсан.

2019 он 10-р сард Франкфурт ариун сүмийг дахин онцгойлон адисалсан.

Тохинууллаар дамжуулан Израилыг цуглуулах нь
8



Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн: Хүчирхэг эхлэл
20

Их Эзэн Сэргээлтэд дэлхийг хэрхэн бэлдсэн бэ?
Ерөнхийлөгч М.Рассэлл Баллард
12

Өсөж буй үеийнхэнд сэдэл төрүүлэх нь
Вэнди Улрич
26

Өнгөрсөндөө өргөгдөж, **ирээдүй** өөд харах нь

Дэлхий дээрх ихэнх хүний хувьд шинэ он нь ирээдүйнхээ талаар бодох цаг үе байдаг. Энэ нь бас өнгөрснөөсөө суралцах цаг үе билээ. Бидний хаана байсан, хаашаа явж байгаа хоёрын огтлолцол дээр, яг тэр цаг мөчид бид өсөж хөгжих боломжтой.

Энэ санаанаас улбаалаад, энэ дугаарт ирээдүйд тохиох, сонирхолтой шинэ өөрчлөлтүүдийг оруулахаас гадна ирээдүйдээ оруулах өөрсдийн хувь нэмрийг ойлгохын тулд өнгөрсөн түүхээ бас судална.

Энэ жил бид Анхны үзэгдлийг харсны 200 жилийн ойг тэмдэглэнэ. Тэргүүн Зөвлөлийнхөн болон бусад хүн өнгөрснийг судалж, ирээдүйгээ төлөвшүүлэхэд бидэнд туслах цуврал нийтлэлүүдийг бэлтгэсэн. Энэ сард Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч М.Рассэлл Баллард Бурханы хаант улсыг сэргээх үйл явцад эзлэх бидний байр суурийг болон Хоёр дахь ирэлтэд биднийг бэлтгэхээр Их Эзэний гаргаж буй хүчин чармайлтыг ойлгоход бидэнд тусална (12-р хуудсыг үзнэ үү).

Ирээдүйг харахад, энэ дугаар нь бас хүүхэд, өсвөр үеийнхнийг дэмжих Сүмийн шинэ хүчин чармайлтад зориулсан эх сурвалжийг (20, 26-р хуудсыг үзнэ үү) өгч мөн хувь хүн, гэр бүлүүдэд зориулсан Мормоны Номыг судлах цуврал хичээлийг эхлүүлнэ (34, 38-р хуудсыг үзнэ үү). Манай өсвөр үеийнхэнд зориулсан хэсэг нь өсвөр үеийнхний шинэ уриаг танилцуулна (56, 60-р хуудсыг үзнэ үү).

Бид *Лиахона* сэтгүүлийг өнгөрсөн үеийн дэвшилтүүд дээрээ тулгуурлан бидэнтэй хамт урагшилснаар гэр оронд төвлөрсөн сайн мэдээг судлахад тань дэмжлэг үзүүлэх үнэ цэнтэй эх сурвалж болсоор байх болно гэдэгт найдаж байна.

Адам К.Өүлсон
Гүйцэтгэх редактор

Гарчиг

5 Мормоны Номын ойлголтууд
Есүс Христ бол... ⏱

6 Итгэлийн хөрөг
Рэйчил Лайтхоол, АНУ, Калифорни ⏱
Хүчтэй түймрийн үеэр итгэл нь түүнд Бурханы мутрыг олж харахад тусалжээ.

8 Тохинууллын зарчмууд
Тохинууллаар дамжуулан Израилыг цуглуулах нь
Тохинуулал Израилыг цуглуулах бошиглогчийн зөвлөгөөнд хэрхэн нийцэж байгааг харна уу.

12 Их Эзэн Сэргээлтэд дэлхийг хэрхэн бэлдсэн бэ?
Ерөнхийлөгч М.Рассэлл Баллард
Түүхэнд хийгдсэн олон шинэ нээлт Их Эзэний төлөвлөгөөний нэгэн хэсэг байсан.

20 Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн: Хүчирхэг эхлэл
Сүмийн удирдагчид таны асуултад хариулж байна.

26 Өсөж буй үеийнхэнд сэдэл төрүүлэх нь
Вэнди Улрич
Хүүхдүүдэд зорилго тавьж, зорилгодоо хүрэхэд нь туслахдаа дараах дөрвөн зааврыг бодож үзнэ үү.

30 Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой ⏱
Нэгэн охин гэрчлэлийнхээ ундаргыг олжээ; ариун сүмийн баптисмууд нэгэн гэр бүлийг ойртуулав; өгсөн зөвлөгөө нь өөрт нь эргээд амар амгаланг авчирсан; эмгэнэлт явдал шинэ боломж болж хувирдаг.

34 Мэддэг байх нь сайхан ч энэ нь хангалтгүй
Стивэн С.Харпэр
Мормоны Номын гэрчүүдтэй уулзаж байсан хүмүүстэй танилцана уу.

38 Ирээд, Намайг дага: Мормоны Ном ⏱
Та энэ жил Мормоны Номыг судлах явцаа сайжруулахын тулд долоо хоног тутмын эдгээр өгүүллийг ашиглаж болно.

⏱ Богино өгүүллүүд



Хавтсан дээр
Гэрэл зургийг
Кристина Смит

Хэсгүүд

Залуучуудад зориулав
42
Алдаа амьдралын салшгүй нэг хэсэг ч бидний хэн болохыг тодорхойлох ёсгүй. **Аврагч биднийг хайрладаг** бөгөөд биднийг өөрчлөгдөхөд тусална. **Наманчлал хэрхэн адислал** болдог талаар залуучуудын хуваалцсан түүхүүдээс уншина уу.



Өсвөр үеийнхэнд зориулав
50
Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн танд хэрэгтэй болохыг болон Залуу эмэгтэйчүүд, Залуу эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийнхөн **энэ жилийн өсвөр үеийнхний урианы** талаар хуваалцахыг мөн нэгэн номлогч **Мормоны Номын хүчийг** нээснийг олж мэднэ үү.

Хүүхдүүдэд зориулав
Найз
Эрхэм нандин Мормоны Номд талархацгаая. Монгол дахь Сүмийн гишүүдийн тухай уншина уу. **Та Есүстэй адил хэрхэн өсөж хөгжиж болох** талаар олж мэднэ үү.

Цахим Лиахона liahona.ChurchofJesusChrist.org facebook.com/liahona Gospel Library аппликэйшн

1-Р САРЫН ЗӨВХӨН ЦАХИМ ХУВИЛБАРААР ГАРАХ НИЙТЛЭЛҮҮД

Сүнсээр удирдуулж байснаа мэдсэн нь

Райсса Шрэйтэр

Бразилд амьдардаг нэгэн залуухан эмэгтэй Сүнс түүнийг Сүмд оруулахаар хөтлөн авчирсныг мэдэрснээ ухаарчээ.

Төлөвлөөгүй жирэмслэлтийн дараа зам дээрээ эргэн гарсан нь

Жори Рийд

АНУ, Делавэрт амьдардаг залуухан эмэгтэй Христэд эргэн ирсэн түүхээ хуваалцав.

Мөнх байдлыг сонгох нь

Эвита Алабоди

Бельгид амьдардаг залуухан эмэгтэй хэрхэн наманчилснаа болон өөрөө өөрийгөө уучилсан түүхээ хуваалцав.



Мормоны Ном надад тэнгэрийн үүдийг хэрхэн нээж өгсөн тухай

Жэссика Паттэрсон Төрнэр

Нэгэн залуухан эмэгтэй "Мормоны Ном: Есүс Христийн бас нэгэн гэрээ" нь түүнийг хэрхэн илүү сайн болгон өөрчилсөн талаар хуваалцав.

ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД

Та Gospel Library аппликэйшн болон liahona.ChurchofJesusChrist.org вэбсайтаас дараах зүйлсийг олж болно:

- Энэ дугаарыг ол.
- Зөвхөн цахим хувилбараар гарах агуулгыг унш.
- Өмнөх дугааруудыг хай.
- Өөрийнхөө түүх, санал хүсэлтийг илгээ.
- Сэтгүүл захиал эсвэл бусдад бэлэг болгон захиалж өг.
- Цахим хэрэгслийн тусламжтайгаар суралцах явцаа сайжруул.
- Таалагдсан нийтлэл, видео бичлэгээ хуваалц.
- Нийтлэлүүдийг татаж ав эсвэл хэвлэ.
- Дуртай нийтлэлүүдээ сонс.

БИДЭНТЭЙ ХОЛБОО БАРИХ

Асуулт, санал хүсэлтээ liahona@ChurchofJesusChrist.org хаяг руу э-мэйлээр илгээнэ үү.

Итгэлийг тань хүчирхэгжүүлсэн түүхийг liahona.ChurchofJesusChrist.org вэбсайт руу илгээх эсвэл доорх хаяг руу шуудангаар илгээнэ үү.
Liahona, floor 23
50 E. North Temple Street
Salt Lake City, UT, 84150-0023, USA

2019 ОНЫ 1-Р САРЫН ДУГААР
БОТЬ, 21, №1
Лиахона 16716 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Рассэлл М.Нэлсон, Даллин Х.Өүкс, Хэнри Б.Айринг

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга: М.Рассэлл Баллард, Жэффри Р.Холланд, Дийтр Ф.Угдорф, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Күк, Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн, Роналд А.Расбанд, Гари И.Стивэнсон, Дэйл Г.Рэнланд, Гэррит В.Гонг, Улиссэс Соарэс

Эрхлэгч: Рэнди Д.Фанк

Зөвлөхүүд: Бэкки Кравэн, Шэрон Эубанк, Кристина Б.Франко, Уолтэр Ф.Гонзалэз, Ларри С.Кэйчэр, Адриан Очао, Майкл Т.Ринвүүд, Верн П.Стэнфилл

Гүйцэтгэх захирал: Ричард И.Хийтон

Сүмийн сэтгүүлийн захирал: Аллан Р.Лойборг

Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Адам С.Олсон

Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр

Хэвлэлийн туслах: Камилла Кастрион

Редакцийн баг: Дэвид Диксон, Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Гаррэтт Х.Гарфф, Жон Райн Жэнсэн, Аарон Жонстон, Шарлотт Ларкэбэл, Майкл Р.Моррис, Эрик Б.Мөрдок, Жошуа Ж.Пэркий, Жан Пинбороү, Ричард М.Ромни, Минди Сэлү, Лори Фүллэр Соса, Чакэлл Вардлэй, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер: Ж.Скотт Кнудсэн

Зургийн дарга: Тадд Р.Пэтэрсон

Уран бүтээлийн ажилтнууд: Жинэтт Эндрьюс, Фэй П.Андрус, Мэндий Бэнтли, С.Кимбалл Ботт, Томас Чайлд, Жошуа Дэннис, Дэвид Грийн, Коллийн Хинкли, Эрик П.Жонсэн, Сюзан Лофгрэн, Скотт М.Моой, Эмили Чиэко Рэмингтон, Марк В.Робисон, К.Никол Вокэнорст

Оюуны өмчийн зохицуулагч: Коллэтт Нэбэкэр Аун

Хэвлэлийн менежер: Жэйн Анн Пэтэрс

Хэвлэх баг: Ира Глэн Адэйр, Жюли Бөрдэтт, Жосэ Чэвиз, Томас Ж.Кронин, Брайн В.Гайги, Жинни Ж.Нилсон, Мэррисса М.Смит

Хэвлэлийн эх бэлтгэгч: Жошуа Дэннис, Аммон Харрис

Хэвлэлийн захирал: Стивэн Т.Льюис

Хуваарилалт хариуцсан захирал: Трой Р.Баркэр

Нэгдсэн Улс, Канадаас бусад орон дахь захиалга болон үнийн талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт liahona.ChurchofJesusChrist.org руу; шуудангаар *Liahona,* Fl. 23,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0023, USA хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ChurchofJesusChrist.org хаягаар ирүүлнэ үү.

Лиахона (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин" буюу "залагч") нь албани, англи, армен, бислам, болгар, вьетнам, гайти, герман, грек, дани, индонез, ирланд, испани, итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл, монгол, нидерланд, норвеги, орос, польш, португал, румын, свахили, самоа, себү, словени, солонгос, сингал, тагалог, тай, тамил, тахити, телуг, тонга, украйн, унгар, урду, фижи, фин, франц, хинди, хорват, хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2019 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Зохиогчийн эрхийн талаарх мэдээлэл: Өөрөөр заагаагүй бол хувь хүмүүс арилжааны бус зорилгоор (Сүмийн дуудлага зэрэг) хувийн хэрэгцээндээ *Лиахона* гаас материал хувилан авч, ашиглаж болно. Энэ эрх ямар ч үед өөрчлөгдөхгүй. Хэрэв зураг чимэглэлийн тухайд ямар нэг хязгаарлалт тогтоосон бол үзүүлэнгийн материалыг хуулбарлаж болохгүй. Зохиогчийн эрхийн талаар асуух зүйл байвал дараах хаягаар хандана уу. Intellectual Property Office, 50 E. North Temple St., FL 13, Salt Lake City, UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн cor-intellectualproperty@ChurchofJesusChrist.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada: January 2020 Vol. 21, No. 1. LIAHONA (USPS 311-480) Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year (January, April, June, July, October, and December) by The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price is $5.00 per year; Canada, $6.50 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days' notice required for change of address. Include address label from a recent issue; old and new address must be included. Send USA and Canadian subscriptions to Salt Lake Distribution Center at address below. Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders (American Express, Discover, MasterCard, Visa) may be taken by phone or at store.ChurchofJesusChrist.org. (Canada Post Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 507.1.5.2). NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368, Salt Lake City, UT 84126-0368, USA.



ЕСҮС ХРИСТ БОЛ . . .

ИЗРАИЛЫН АРИУН НЭГЭН

БҮТЭЭГЧ

АВРАГЧ

БУРХАНЫ ХУРГА

БУРХАНЫ ХҮҮ

Бурханы Төрсөн Ганц Хүү

ГЭТЭЛГЭГЧ

МЕССИА

САЙН ХОНЬЧИН

“Болгоогтун, хүмүүнд зориулагдсан харгүй нарийн, гэвч энэ нь түүний өмнө шулуунаар зурайна, мөн **ИЗРАИЛЫН АРИУН НЭГЭН** бол их хаалганы сахиул; мөн тэрээр нэгээхэн зарцыг тэнд үл ажиллуулдаг” (2 Нифай 9:41).

“Мөн тэрээр Есүс Христ, Бурханы Хүү, тэнгэр ба газрын Эцэг, эхлэлээс бүх зүйлийг **БҮТЭЭГЧ** хэмээн нэрлэгдэх болно” (Мозая 3:8).

“Хэрэв та нар Христэд итгэн, мөн бидний **АВРАГЧИЙН** жишээг даган, тэрээр бидэнд зарлиг болгосны дагуу, эхлээд усаар, дараа нь галаар мөн Ариун Сүнсээр баптисм хүртэх аваас, шүүлтийн өдөр та нарын хувьд сайн байх болно” (Мормон 7:10).

“**БУРХАНЫ ХУРГА** бол Мөнхийн Эцэгийн Хүү хийгээд дэлхийн Аврагч; мөн бүх хүмүүн түүнд ирэх ёстой, эс бөгөөс тэд аврагдаж чадахгүй” (1 Нифай 13:40).

“Тэрээр маханбодид оршихын учир тэрээр **БУРХАНЫ ХҮҮ** гэж нэрлэгдэх болно” (Мозая 15:2).

“Тиймийн тул, наманчлах мөн зүрх сэтгэлээ эс хатууруулах хэн боловч, тэрээр нүглүүдийнхээ ангижралын төлөө, миний **ТӨРСӨН ГАНЦ ХҮҮГЭЭР** дамжуулан нигүүлслийг хүртэх эрхтэй болно” (Алма 12:34).

“Иймийн тул, **ГЭТЭЛГЭГЧИЙНХЭЭ** зөв шударгын учир чибээр гэтэлгэгдсэнийг би мэднэ; учир нь хүн төрөлхтөнд авралыг авчрахаар тэрээр цаг хугацааны бүрэн байдалд ирэхийг нь чи үзсэн билээ” (2 Нифай 2:3).

“[Лихай] . . . сонссон басхүү үзсэн зүйлүүд хийгээд түүнчлэн номноос уншсан зүйлүүд, **МЕССИАГИЙН** ирэх[ийг] . . . илэрхийгээр мэдүүлсэн гэдгийг тэрбээр гэрчилсэн болой” (1 Нифай 1:19).

“**САЙН ХОНЬЧИН** та нарыг дууддаг; тийм ээ, мөн Христийн нэр болох өөрийнхөө нэрээр та нарыг тэр дууддаг” (Алма 5:38).

САЙН ХОНЬЧИН, Ж.КӨРК РИЧАРДСЫН ЗУРГИЙН ХЭСГЭЭС
ХРИСТИЙН ДҮР ТӨРХ, ХЭЙНРИХ ХОФМАННЫ ЗУРГИЙН ХЭСГЭЭС

Рэйчил Лайтхоол

АНУ, Калифорни муж

Та Рэйчилийн амьдарч байсан газрын үнс, нурангийн ойр орчмоор явбал юу ч үлдээгүй болохыг анзаарна. Калифорнийн Парадайзыг гал түймэр сүйтгэсний дараа ч Бурханы мутар амьдралд нь оролцож байгааг хэрхэн харсан тухайгаа Рэйчилийг ярихад түүний итгэл анзаарагдаж байлаа.

РИЧАРД М.РОМНИ, ЗУРАГЧИН



Бурханд итгэдэг хүн бүр Түүний мутрыг түймрийн үеэр харсан. Ганцхан том гайхамшгаар та Бурхан байдгийг өөр хүнд нотолж чадахгүй байж болох ч Бурхан сая сая жижигхэн гайхамшгийг Парадайзад авчирсан юм. Хэрэв та Бурханд итгэдэг л бол Түүний мутрыг хаа сайгүй харж болохоор байлаа. Хэдийгээр энэ нь хэцүү ч гэлээ бас гайхамшигтай зүйл байв. Бурхан бидэнд яг сурах хэрэгтэй зүйлээ ойлгож мэдэхэд тусалсан.

Бурхан намайг энэ үйл явдалд бэлдэхийн тулд надтай олон жил ажилласан билээ. Миний амьдралд өөр “гамшгууд” тохиолдож байсан бөгөөд тэдгээр нь Бурхан миний амьдралыг гоё сайхан чиглүүлдгийг мэдэж авахад надад тусалсан юм.

Надад тохиолдсон бүх хүнд хэцүү зүйлийн дунд төгс, сайн сайхан зорилгогүй зүйл ганц ч байгаагүй. Бурханд заах сургах боломж олгосон үед саад бэрхшээлээсээ үргэлж суралцаж байгаагаа би анзаарсан. Бурхан бидэнд Өөрт нь найдаж, Өөрийг нь хайрлахыг заахын тулд ийм зовлон бэрхшээлийг амсуулдаг. Асуудал хүндрэхэд Тэрээр үргэлж бидэнтэй хамт байдгийг би мэднэ.

ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД

Рэйчилийн итгэлээ олж авсан аяллын талаар дэлгэрэнгүй мэдэж авч мөн өөр зургуудыг харахыг хүсвэл энэ нийтлэлийн онлайн буюу Gospel Library дээрх хувилбарыг **ChurchofJesusChrist.org/go/1206** дээрээс үзнэ үү. **ChurchofJesusChrist.org/go/1207** дээр ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон Парадайзад гарсан түймрийн хохирогчидтой уулзсан тухай ярьж, амьдралд юу хамгийн чухал болохыг хуваалцсан.

Тохинууллын зарчмууд

ТОХИНУУЛЛААР ДАМЖУУЛАН ИЗРАИЛЫГ ЦУГЛУУЛАХ НЬ

Тохинуулал бол Израилыг цуглуулах бошиглогчийн зөвлөгөөг дагах боломж юм.

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон биднийг "өнөөдөр дэлхий дээр болох хамгийн чухал зүйл"[1] буюу Израилыг цуглуулахад туслахыг уриалсан.

Энэхүү Израилыг цуглуулах ажилд оролцохыг хүсэж байгаа хүмүүст тохинуулал нь гайхалтай боломж юм. Их Эзэний авралын ажил том ажил тул тохинуулал нь хүмүүсийн амьдралыг өөрчлөх сүнсээр өдөөгдсөн арга зам юм. Бид идэвх сулгай гишүүдэд тохинуулах юм уу өөрсдөөсөө өөр итгэлтэй хүмүүст үйлчлэхдээ, биднээс тусламж хүсэх эсэхээс нь үл хамааран тохинуулснаар Израилыг цуглуулах боломжийг олгодог.

Нэг нэгнийхээ ачааг үүрэлцэх нь

"Бидний хоньд шаналж, төөрөлдөн, бүр зориуд замаасаа хазайдаг ч байж магадгүй. Бид хоньчид нь учраас тэдний хэрэгцээг хамгийн түрүүнд олж харах хүмүүсийн нэг байж болно. Бид шүүхгүйгээр сонсож, хайрлаж мөн итгэж найдахыг санал болгож, Ариун Сүнсний ялган таних удирдамжаар тусалж чадна." —Бонни Х.Кордон[2]

"Өглөөний 7 цагийн нислэгээр хажууд сууж байсан эмэгтэйг би чимээгүйхэн ажиглалаа. Тэр онгоц нисэхээс өмнө согтууруулах ундаа захиалсан байсан бөгөөд надаас гэрлэсэн эсэхийг минь асуухад түүний талаарх **сөрөг шүүмж** бүхий бодол надад ар араасаа орж ирэх болов.

"'Тийм ээ, би дөрвөн хүүхэд, дөрвөн ач зээтэй' гэж би бахархан хариуллаа.

Үүний дараа түүний хэлсэн зүйл бүхнийг өөрчилсөн юм. Түүний нөхөр тав хоног ухаангүй байж байгаад өчигдөрхөн нас барсан байлаа. Тэр өөрөө түргэн тусламжийн эмч байсан ч амралтын газарт байхдаа ухаан алдаж унасан нөхрийнхөө амийг аврах боломжгүй байсан аж.

Түүнийг шууд шүүмжилсэндээ би ичиж байлаа. Би түүнд юу гэж хэлэх вэ? Өөрийгөө тайвшруулсныхаа дараа би сайн мэдээний зарим нандин үнэнийг тэр эмэгтэйтэй хуваалцан тохинуулж болохын төлөө Тэнгэрлэг Эцэг **Өөрийн Сүнсийг юүлж** байгааг мэдэрсэн юм.

"Тэр эмэгтэй урьд нь ямар ч сүмд явж байгаагүй ч Есүс Христ болон Библид итгэдгийг нь би **олж мэдэв**. Би түүнээс Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн талаар мэдэх эсэхийг асуухад тэрээр тийм ч сайн мэдэхгүй гэж хэлсэн. Би түүнтэй ахлагч Ричард Г.Скоттын (1928–2015) Ерөнхий чуулган дээр хэлсэн 'Гэрлэлтийн мөнхийн адислалууд' нэртэй захиасыг хуваалцаад, дараа нь мөнхийн гэр бүлийн талаар мөн Тэнгэрлэг Эцэг хэрхэн бидний хүн нэг бүрийг мэддэг мөн хайрладаг талаар **гэрчилсэн** юм. Тэрээр өсөж торнисон АНУ-ын Хавай руугаа явж байгааг нь би мэдээд, Хавай дахь Лайе ариун сүм рүү очиж үзэхэд түүнийг **урив**.

"Бид Ютагийн Солт Лэйк хотын онгоцны буудалд салсан юм. Их Эзэн миний сул талыг үл анзааран, тэр эгчийг хайрлаж, тайтгаруулахаар намайг ашигласанд би маш их талархдаг.

Жон Типпэтс, АНУ, Юта

АНХААРЧ ҮЗЭХ ЗАРЧМУУД

"Сөрөг үзэл бодол"
Бусдыг шүүхдээ шуурхай байх нь тэнгэрлэг чадавхыг олж харахад бидэнд саад болдог (Матай 7:1-ийг үзнэ үү).

"Түүний Сүнсийг юүлж асга"
Юу хэлэх ёстой нь яг тухайн цагт бидэнд өгөгдөнө гэсэн Бурханы амлалтад итгэ (Сургаал ба Гэрээ 100:5–6-г үзнэ үү).

"Олж мэдсэн"
Бусдын юунд итгэдгийг асууж, үнэн сэтгэлээсээ сонсож, тэдний шүтлэг бишрэлд хүндэтгэлтэй ханд.

"Гэрчилсэн"
Их Эзэн таны амьдралд хэрхэн тусалсан талаар гэрчлэлээ хуваалцах боломжийг эрэлхийл (Мозая 24:14-ийг үзнэ үү).

"Урьсан"
Ариун Сүнс тэдэнд гэрчилж болохын тулд үнэнээр үйлдэхэд тэднийг урь (Иохан 7:17; Моронай 10:5-ыг үзнэ үү).

АНХААРЧ ҮЗЭХ ЗАРЧМУУД

"Тэр эгч нохойны харшилтай ч гэсэн сар болгон манайд ирдэг байв"

Та бусад зүйлд тавьдгаас илүү анхаарал халамжийг тохинуулж байгаа хүмүүстээ тавьдгаа хэрхэн харуулж болох вэ? (Сургаал ба Гэрээ 121:44-ийг үзнэ үү).

"Асуултууд"

Зөв асуулт тавих нь өөрөө өөртөө дүгнэлт хийхэд тэдэнд тусална. Бидний тохинуулал найзалж нөхөрлөхөөс илүү чухал зорилготой гэдгийг сана.[4]

"Намайг хүлээж байгаа"

Хүн бүрийг халуун дотно угтах ёстой (3 Нифай 18:32-ыг үзнэ үү).

"Эргэж ирэх замд миний хажууд байсан"

Аврагчид эргэн ирж, эдгэрэх замдаа бүдэрч унасан хүмүүст бидний дэмжлэг туслалцаа чухал хувь нэмэр болж болно (Еврей 12:12–13-ыг үзнэ үү).

Эргэн ирж байгаа гишүүдийг аврах

"Хайр байснаар л гайхамшигууд тохиолдож, бид "сүмдээ ирэхээ больсон" эгч, дүү нараа буцаан авчрах арга замуудыг олоход үүний учир шалтгаан оршино."[3] —Жийн Б.Бингам

"Нөхөр бид хоёрыг шинэ хот руу нүүж очих үед би дор хаяж 6 жил идэвхгүй болсон байсан юм. Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгч маань манайд айлчлаад, над руу нэг эгч явуулж болох уу гэж асуусан. Би бага зэрэг догдолсоор зөвшөөрлөө. Тэр эгч **нохойны харшилтай байсан ч гэсэн сар болгон манайд ирдэг байв.** Харин би нохойнуудаа эрхлүүлэх ямар дуртай гээч! Тэр хоёр жил тохинуулсан бөгөөд надад маш их нөлөөлсөн.

"Хэдийгээр тэр ихэнхдээ зүгээр нэг ярьж хөөрөлдөхөөр ирдэг байсан ч заримдаа сүнслэг сэдвээр яриа өрнүүлэх **асуултууд** тавьдаг байв. Ийн асуухад нь надад жаахан эвгүй байдаг байсан ч сайн мэдээний замаар цааш явах уу эсвэл энэ хэвээрээ байгаад байх уу гэдгээ шийдэхэд надад тусалсан юм. Энэ шийдвэрийг гаргахад надад хэцүү байсан ч би номлогч эгч нартай уулзахаар шийдсэн.

"Зургаан жилийн дараа анх удаа ариун ёслолд суухаар очихдоо би дотогш орохоосоо айж байлаа. Намайг сүмд явж ороход тохинуулагч эгч маань **намайг хүлээж байсан** бөгөөд цуглааны танхим руу надтай хамт явж орсон юм. Дараа нь тэр намайг машинд маань хүргэж өгөөд, Аврагчид илүү ойртоход хэрхэн надад тусалж болохыг асуулаа.

Тохинуулагч эгчийн маань надад зориулсан цаг зав, үзүүлсэн хайр намайг үйл ажиллагаанууд буцаж идэвхтэй оролцдог болоход тусалсан ба түүний хичээл зүтгэл надад өгсөн хамгийн агуу бэлгүүдийн нэг байсан гэж би үздэг. Аврагчийн Сүмд **эргэж ирэх замд маань миний хажууд** байсанд би тэр эгчид талархдаг."

Нэрийг нууцлав, Канад, Британийн Колумбиа

Тохинуулах мөн цуглуулах

“Өөрийнхөө хувьд хамгийн энгийн, эвтэйхэн байдлаар Есүс Христ болон Түүний Сүм яагаад таны хувьд чухал болохыг хүмүүстэй хуваалц. . . .

. . . Харин та зүрх сэтгэл доторхоо хуваалцаж, итгэл үнэмшилийнхээ дагуу амьдрах үүрэгтэй.”[5] *—Ахлагч Дийтр Ф.Угдорф*

Тохинуулах, сайн мэдээг хуваалцах хоёр нь хоорондоо холбоотой. Тохинуулж байхдаа найз нөхөд болон хөршийндөө цуглarах эсвэл найз нөхөд, хөршөө цуглуулахдаа тохинуулж болох зарим арга замыг өгье.

- ***Хамтдаа үйлчил.*** Тусламж хэрэгтэй байгаа хэн нэгэн рүү хамт явж тохинуулахад Сүмийн гишүүн биш найзаа эсвэл хөршөө урих боломжийг хай. Дөнгөж төрсөн эхэд хоол хийж өгч, ахимаг насны хөршийнхөө хашааг цэвэрлэхэд эсвэл өвчтэй хүний гэрийг нь цэвэрлэхэд туслахыг тэднээс хүс.
- ***Хамтдаа заа.*** Та номлогчтой уулзаж байгаа хүнийг хичээлээ гэртээ заалгуулахад мөн гэрт тань заах гэж байгаа номлогчийн хичээлд туслуулахад мөн өөр хүний гэрт заах гэж байгаа хичээлд хамт явах зэрэгт найз эсвэл хөршөө урьж болно.
- ***Холбоо барь.*** Та томилогдсон хүмүүстээ тохинуулахын зэрэгцээ тусламж хэрэгтэй байгаа бусад хүнд туслах хэрэгтэй. Тэднийг Сүмийн цуглаанд машинаараа хүргэж өгөхийг санал болго. Хүүхдүүдийг нь өсвөр үеийнхний эсвэл Хүүхдийн хэсгийн үйл ажиллагаанд урь. Та өөр ямар арга замаар тохинуулж мөн тэднийг цуглуулж болох вэ?
- ***Сүмийн эх сурвалжуудыг ашигла.*** Гишүүд сайн мэдээг хуваалцахад туслах Сүмийн олон эх сурвалж бий. Та Gospel Library аппликэйшны “Missionary” хэсэг рүү ороод, “Come and See” видео бичлэгүүдийг үзнэ үү (ChurchofJesusChrist.org/go/12011), мөн ComeUntoChrist.org руу орж, орон нутагтаа Израилыг хэрхэн цуглуулж болох талаар санаа ав. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Рассэлл М.Нэлсон, “Израилын итгэл найдвар” (Өсвөр үеийнхний дэлхий даяарх онцгой цугларалт, 2018 оны 6-р сарын 3), HopeofIsrael.ChurchofJesusChrist.org.
2. Бонни Х.Кордон, “Хоньчин болох нь,” *2018 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 66.
3. Жийн Б.Бингам, “Аврагчийн адил тохинуулах нь,” *2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 132.
4. “Тохинууллын зарчмууд: Тохинуулллыг өөрчлөх бидний зорилго,” *Лиахона,* 2019 оны 1-р сар, 8–11-ийг үзнэ үү.
5. Дийтр Ф.Угдорф, “Номлолын ажил бол зүрх сэтгэл доторхоо хуваалцах явдал юм,” *2019 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 17.

ГЭРЭЛ БА ХАРАНХУЙН ХҮЧИН, ВОРРЭН ЛЬЮК, СҮМИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ.
АРИУН ОЙН ЦООРХОЙН ЗУРГИЙГ ТРОЙ КОРБЭТТ

Ерөнхийлөгч М.Рассэлл Баллард
Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч

Их Эзэн Сэргээлтэд *дэлхийг* хэрхэн бэлдсэн бэ?



Их Эзэн хувь хүн, гэр бүл, олон нийт, улс орон, дэлхийг адислахын тулд Өөрийн сайн мэдээний Сэргээлтэд тоолж баршгүй олон арга замаар дэлхийг бэлтгэсэн.

Их Эзэн 1820 онд Эцэг, Хүү хоёрыг Иосеф Смитэд үзэгдэхээс олон жилийн өмнө дэлхийг Есүс Христийн сайн мэдээний Сэргээлтэд бэлтгэж байсан. Үнэндээ хожмын өдрүүдэд Өөрийн сайн мэдээний бүрэн байдлыг сэргээх бэлтгэлийг Их Эзэн дэлхийг бүтээхээс өмнө эхлүүлсэн.

1918 оны 10-р сард ерөнхийлөгч Иосеф Ф.Смитийн (1838–1918) хүлээн авсан Сургаал ба Гэрээний 138-р хэсэг дэх илчлэлтээс бид Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн анхны бошиглогчид болон өөр олон "*бусад сонгомол сүнснүүд* . . . хожмын үеийн агуу их ажлын суурийг тавихад оролцохоор цаг хугацааны бүрэн байдалд урагш гарч ирэхээр хадгалагдсан" болохыг олж мэддэг (Сургаал ба Гэрээ 138:53: онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Ерөнхийлөгч Смит "эхлэлд сонгогдсон, ёс суртахуунаар өв тэгш хийгээд агуу хүмүүсийн дунд тэд тэрчлэн байсныг" харжээ (Сургаал ба Гэрээ 138:55). Тэр мөн "тэд . . .*бусад олны хамт,* сүнсний дэлхийд анхныхаа хичээлүүдийг хүлээн авч, мөн Их Эзэний тогтоосон цагт хүмүүний бодгалиудын авралын төлөө түүний талбайд хөдөлмөрлөхийн тулд урагш гарч ирэхээр бэлтгэгдсэн" болохыг нэмж хэлсэн (Сургаал ба Гэрээ 138:56; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Дэлхий бүтээгдсэний дараа эртний "эш үзүүлэгчид . . . эрт цагаас" ирээдүйн "бүхнийг сэргээх үе"-ийн талаар ярьж, дуулж, мөрөөдөж, бошиглож байлаа (Үйлс 3:21-ийг мөн Лук 1:67–75-ыг үзнэ үү).

Их Эзэн дэлхийг Сэргээлтэд бэлдсэн хамгийн чухал арга замуудын нэг бол гар бичмэлийн хувьсгал байсан ба үүний үр дүнд папирусыг болон илгэн цаасыг бүтээжээ. Доод талд: Хамгийн эртний Шинэ Гэрээний бичвэрийн папирус хуудас.



Ерөнхийлөгч Бригам Янг (1801–1877) Есүс Христийн Сүмийн Сэргээлтийн анхны бошиглогчийн талаар онцлон ярихдаа, "Их Эзэн [Иосеф Смитийг], аавыг нь, аавынх нь аавыг, мөн Абрахам хүртэлх, Абрахамаас үер, үерээс Енох, Енохоос Адам хүртэлх түүний өвөг дээдсийг ажиглан харж байсан билээ. Тэрбээр уг гэр бүлийг мөн тэр хүний төрөх эх ундарга болсон цусыг ажиглан харж байсан юм. [Иосеф Смит] энэхүү эцсийн эрин үеийг тэргүүлэхээр үүрд мөнхөд урьдчилан томилогджээ"[1] хэмээн хэлсэн.

Бид энэ жил Анхны үзэгдлийг харсны 200 жилийн ойг тэмдэглэхдээ, 1820 онд өршөөл, удирдамж заавар эрэлхийлж байсан бяцхан хүү Иосеф Смитэд Эцэг, Хүү хоёр үзэгдсэнээр эхэлсэн Сэргээлтэд дэлхийг бэлтгэх явцад Их Эзэнээр хэдэн зуун жилийн туршид удирдуулж байсан олон олон эмэгтэй, эрэгтэй хүнийг дурсах нь зүйтэй болов уу.

Түүхийг эргэн харахад, Их Эзэний Сүмийг хожмын өдрүүдэд сэргээхэд хүмүүсийг бэлдсэн олон хувьсгал дэлхий даяар болж байсныг мэдэж болно.[2]

Гар бичмэлийн хувьсгал

Их Эзэн сайн мэдээнийхээ Сэргээлтэд дэлхийг бэлдсэн хамгийн чухал арга замуудын нэг бол папирус, илгэн цаасыг бүтээж, хэрэглэх болсноор эхэлсэн гар бичмэлийн хувьсгал байсан юм.[3]

Амьтны арьсаар хийдэг илгэн цаасыг эрт дээр үед болон орчин цагийн эхэн үед дээр нь бичих гадаргуу болгон ашиглаж байжээ.[4] Еврей Библийн (Хуучин Гэрээ) хамгийн эртний гэгдэх хуулбар болон Библийн хожим хийгдсэн олон чухал хуулбарууд илгэн цаасан дээр хадгалагдан үлдсэн байдаг.[5]

Папирус нь папирус ургамлын голоор хийдэг, эрт дээр үед бичих гадаргуу болж байсан өөр нэгэн материал юм. Шинэ Гэрээний хамгийн эртний хуулбарууд папирус дээр хадгалагдан үлдсэн байдаг.

Эдгээр бичих материал нь чулуу эсвэл шавар хавтан дээр бичихтэй харьцуулах юм бол сүнсээр өдөөгдсөн бошиглогч, төлөөлөгчдийн хүлээн авсан Бурханы үгсийг хялбархан тэмдэглэж авах боломжийг бичээчдэд олгосон. Эдгээр бичих материалыг ашиглан тоолж баршгүй олон, нэр нь үл мэдэгдэх бичээчид итгэлийн галыг бөхөөхгүйн тулд ариун нандин бичээсийг эцэлт цуцалтгүй хуулбарлаж, дамжуулж, хадгалан үлдээсэн билээ.

Жишээлбэл, "грек хэл дээр бичсэн Матайн сайн мэдээний 100 гаруй гар бичмэлээс" гадна дундад зууны үед илгэн цаасан дээр бичсэн библийн өөр олон гар бичмэл байгааг би саяхан олж мэдсэн юм.[6]

Хэвлэлийн хувьсгал

Миний олон удаа зааж байсанчлан, 1439 юм уу 1440 онд германы алтны дархан Иоханнес Гутенберг анх Хятадад танилцуулагдсан хэвлэх технологийг хэвлэлийн үйлдвэрт нэвтрүүлснээр Их Эзэн Өөрийн

ПАУЛЫН ТЕРТУСТ ХЭЛЖ БИЧҮҮЛСЭН, РОМЧУУДАД ХАНДАН БИЧСЭН МОДОН ДЭЭР СИЙЛСЭН ЗАХИДАЛ, GETTY IMAGES-ЭЭС АВАВ.

Иоханнес Гутенберг бол дэлхий дэх мэдлэг, ойлголт, шашны итгэлийг өсгөн нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулсан Бурханы мутар дахь зэмсэг байсан юм. Баруун талын захад: Гутенбергийн Библийн сийлбэрлэсэн хуудас.



Incipit epistola sancti iheronimi ad
paulinum presbiterum de omnibus
divine historie libris-capitulū pmū.
Frater ambrosius
tua michi munus-
cula perferens detulit
sil et suavissimas
lrās-q a principio
amiciciaȝ-fidē pba-
te iam fidei et veteris amicicie nova:
preferebant. Vera enī illa necessitudo ē-
et xpi glutino copulata-qm non vtili-
tas rei familiaris-nō pńcia tantum
corporū-nō subdola et palpās adulacō-
sed dei timor-et divinarū scripturarū
studia conciliant. Legimus in veteribȝ
historijs-quosdā lustrasse pvincias-
novos adisse pplos-maria transisse-
ut eos quos ex libris noverant: corā
q videret. Sicut pitagoras memphi-
ticos vates-sic plato egiptū-et architā
tarentinū-eandemq oram ytalie-que
quondā magna grecia dicebat:labo-
riosissime peragravit-et ut qui athenis
mgr erat-et potens-cuiusq doctrinas

авралын сайн мэдээний Сэргээлтэд дэлхийг бэлтгэх явцад бас нэгэн чухал алхам хийжээ.[7]

Гутенберг нь мэдлэг, ойлголт, шашны итгэлийг дэлхийд өсгөн нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулсан Бурханы мутар дахь зэмсэг байсан юм.[8] Түүний бүтээл “өөрчлөлтийн хүчин зүйл” болсон үзэл бодол, мэдээ мэдээллийг өргөнөөр харилцан солилцоход түлхэц өгч, дэлхийг орвонгоор нь өөрчилсөн хэвлэлийн хувьсгалын очийг бадраасан билээ.”[9]

Гутенбергийг хэвлэлийн машин дээрээ Библийг хэвлэх үед Европт нийтдээ 30000 ном байсан гэж эрдэмтэд тооцоолдог. Түүнийг хэвлэлийн машин бүтээснээс хойш 50 жилийн дотор Европт 12 сая гаруй ном байжээ.

Протестант шашны шинэчлэлтээр, өмнөх үеийнхний хэний ч төсөөлж байгаагүй арга замаар үзэл бодлоо түгээн дэлгэрүүлж, Библийг энгийн ардад хүргэхэд Гутенбергийн бүтээлийг ашигласан юм.

Бичиг үсгийн хувьсгал ба Библийн орчуулга

Хэвлэлийн хувьсгал нь судрын ариун үгсийг өөрсдийн хэл дээр унших гэсэн Европын энгийн ардын өсөн нэмэгдэж буй хүслийг гүйцэлдүүлж байв.

Грек, еврей хэлнээс МЭ 5-р зуунд латин хэлнээ орчуулагдсан Библи нь 1000 жилийн туршид барууны Католик сүмийн албан ёсны Библи болж байв.[10] Олон зууны турш европчууд Библийн талаар гол төлөв пристүүдийн өгсөн сургаалаар дамжуулан мэддэг байжээ.

Гэвч 15, 16-р зуунд шашны шинэчлэгчид герман, итали, англи, испани, франц гэх мэт Европын нийтлэг хэлүүд дээр Библийг шинээр орчуулан гаргав. Эдгээр орчуулгыг ихэвчлэн латин Библи дээр биш, харин еврей болон грек эх бичвэр дээр үндэслэн орчуулсан байлаа. Энэ нь олон мянган уншигчид Библийн түүх, сургаалыг эх хэл дээрээ унших боломжийг олгосон юм.

1483 онд төрсөн Мартин Лютер тухайн цаг үедээ өөрийн хэл дээр Библийг хэвлүүлсэн манлайлагчдын нэг байв. Герман хэл дээрх

16-Р ЗУУНЫ ХЭВЛЭХ ҮЙЛДВЭР, GETTY IMAGES-ЭЭС АВАВ.
БИБЛИЙН ХУУДАС, GETTY IMAGES-ЭЭС АВАВ

орчуулга нь 1534 онд хэвлэгдэн гарсан ба энэ нь барууны Христийн шашны түүхэнд чухал жил байлаа.[11] Судрын хүчинд итгэх Лютерийн итгэл Шинэчлэлтэд түлхэц өгч тусалсан. Бусад шинэчлэгчид судраас унших боломжийг хүн бүрд олгохын төлөө бүх нийтийн боловсролыг сурталчилж байлаа.

Зарим шашны удирдагч Библийг өргөнөөр унших юм бол тэрсэлдэх, сүмийн эрх мэдлийг унагаах, бүр нийгмийг тогтворгүй байдалд хүргэж болзошгүй гэж санаа зовж байв. Тэд Библийг тухайн үеийн нийтлэг хэл рүү орчуулж байгааг мэдсэн юм уу нийтлэг хэл дээр орчуулагдсан судартай олон хүнийг шоронд хорьж, яргалан тарчлааж, тэр бүү хэл амийг нь хороож байлаа.

Уиллиам Тиндал 1494 онд төрсөн бөгөөд Мартин Лютерийг зориг гарган, Библийг герман хэлээр орчуулах үед гарч ирсэн юм.[12] Залуухан байхдаа Тиндал еврей болон грек эх хэлүүд дээр үндэслэн Библийг англи хэл дээр шинээр, илүү сайн орчуулах санаа сэджээ.

1523 оны орчим тэрээр ийм хувилбарыг гаргахаар Лондоны католик шашны бишопоос тусламж эрэлхийлэн, урам зориг авах гэсэн боловч эрс татгалзсан хариу авав. 1408 онд Оксфордод болсон хуралдаанаар Библийг орчуулахыг хориглосон заалт гарсан тул Тиндалд хөндлөнгийн оролцоогүй орчуулга хийх албан ёсны зөвшөөрөл хэрэгтэй байлаа.

Тиндал Библийг англи хэлнээ орчуулах санаагаа орхилгүй, орчуулах ажлаа нууцаар эхлүүлэн, 1525 онд Шинэ Гэрээг орчуулж дуусгажээ. Германы Кёльн хотод хэвлэгдсэн Тиндалын орчуулгыг 1526 оны эхээр Англи руу нууцаар оруулж ирэн, зарах болсон байна.

Эцэст нь, 1536 оны 10-р сарын эхээр өөрсдийн хэл дээр судраас унших боломжийг энгийн ардад олгохыг хүссэн бусад олон эмэгтэй, эрэгтэй хүний адилаар Тиндалыг


THE GENERALL
Epistle of Iames.

CHAP. I.

o reioyce vnder the Crosse, 5 To
tience of God: 13 And in our tri-
to impute our weakenesse, or sinnes
vnto him, 19 but rather to hearken to the
word, to meditate in it, and to doe thereaf-
ter. 26 Otherwise men may seeme, but
neuer be truely religious.

Iames a seruant of God, and of the Lord Iesus Christ, to the twelue tribes which are scattered abroad, greeting.
2 My brethren, count it all ioy when yee fall into diuers temptations,
3 Knowing this, that the trying of your faith worketh patience.
4 But let patience haue her perfect worke, that yee may be perfect, and entire, wanting nothing.
5 If any of you lacke wisedome, let him aske of God, that giueth to all men liberally, and vpbraydeth not: and it shall be giuen him.
6 But let him aske in faith, nothing wauering: for he that wauereth is like a waue of the sea, driuen with the

11 For the Sunne is no sooner risen with a burning heat, but it withereth the grasse, and the floure thereof falleth, and the grace of the fashion of it perisheth: so also shall the rich man fade away in his wayes.
12 Blessed is the man that endureth temptation: for when he is tryed, hee shall receiue the crowne of life, which the Lord hath promised to them that loue him.
13 Let no man say when he is tempted, I am tempted of God: for God cannot be tempted with ||euill, neither tempteth he any man. ||Or, euils.
14 But euery man is tempted, when hee is drawen away of his owne lust, and entised.
15 Then when lust hath conceiued, it bringeth foorth sinne: and sinne, when it is finished, bringeth foorth death.
16 Doe not erre, my beloued brethren.
17 Euery good gift, and euery perfect gift is from aboue, and commeth downe from the Father of lights, with whom is no variablenesse, neither shadow of turning.
18 Of his owne will begate hee vs, with the word of Trueth, that wee should be a kind of first fruits of his creatures.

Эцэст нь, өөрсдийн хэл дээр судраас унших боломжийг энгийн ардад олгохыг хүссэн өөр эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн адил Уиллиам Тиндалыг шонд дүүжлэн цаазалсан юм. Баруун талд: Хаан Жеймсийн Библийн эх хувийн хуудас

УИЛЛИАМ ТИНДАЛЫГ ЦААЗАЛЖ БАЙГАА ЗУРАГ, GETTY IMAGES-ЭЭС АВАВ. СУДРААС УНШИЖ БАЙГАА ЭРЭГТЭЙН ЗУРГИЙГ ДЭВИД ВИНТЭРС АВАВ



МЕТОДИСТУУДЫН ЗУСЛАНГИЙН УУЛЗАЛТЫН ЗУРАГЛАЛ (1873), GETTY IMAGES-ЭЭС АВАВ.

Их Эзэн Өөрийн бошиглогчийг гаргаж ирэхдээ, дэлхийд сайн мэдээг урагшлуулах зорилгоор техник технологийг нээн бүтээх эрэгтэй, эмэгтэй хүмүүст сүнслэгээр нөлөөлсөн.

шонд хүлэн дүүжилжээ.[13] Гэсэн хэдий ч түүний англи орчуулга үлдэж, орчуулсан үг, хэллэг болон бүтэн хэсгүүд нь Хаан Жеймсийн хувилбарт орсон байдаг.[14]

1611 онд хэвлэгдэн гарсан Хаан Жеймсийн хувилбар нь Английн Сүмд албан ёсоор хэрэглэгдэх болж, сүүлд нь Есүс Христийн сайн мэдээний Сэргээлтэд хэд хэдэн чухал арга замаар нөлөөлсөн билээ.[15] 1805 онд Иосеф Смитийг төрөх үед энэ нь хамгийн өргөн тархсан англи Библи байв. Тэр үед Иосеф, Люси Мак Смит хоёрынх шиг ихэнх айл өрх Библитэй байсан бөгөөд түүнийгээ тогтмол уншдаг байсан юм. Үнэндээ олон хүн уг номыг гэртээ уншихыг сонсох мөн өөрсдөө судлах замаар уншиж сурдаг байжээ.

Улс төрийн болон харилцаа холбооны хувьсгал

Хэвлэл, орчуулга, бичиг үсгийн хувьсгалууд 17-оос 19-р зууны хооронд Европ, Америк тивд өрнөсөн улс төр, техник технологийн хувьсгалын өрнөх замыг бэлтгэсэн юм. Европ, Америкийн улс төрийн уур амьсгалд гарсан өөрчлөлт хүмүүст өөрийн шашны замналыг сонгох агуу эрх чөлөөг олгосон. Шашин шүтэх эрх чөлөө бол тухайн үед болж өрнөсөн улс төрийн хувьсгалын олон үр дагаврын нэг юм.

Мөн Их Эзэн Түүний Сэргээлтийг огцом урагшлуулж чадах, шинэ тээвэр, холбооны хэрэгслийн талаар мөрөөдөхөөр бэлтгэгдсэн хүмүүсийн дээр “Сүнсээ бүх махбод дээр цутга[ж]” (Иоел 2:28; Иосеф Смит—Түүх 1:41) эхэлжээ.

Их Эзэн Өөрийн бошиглогчийг гаргаж ирэхдээ усан хоолой, цахилгаан холбоо, галт тэрэгний зам, уурын хөдөлгүүр гэх мэт техник технологийг бүтээлгэхээр эрэгтэй, эмэгтэй хүмүүст сүнсээр нөлөөлсөн.

Их Эзэн олон арга замаар хувь хүн, гэр бүл, олон нийт, улс орон, дэлхийг Өөрийн сайн мэдээний Сэргээлтээр адислахад бэлтгэсэн.

Смитийн гэр бүлийг удирдан чиглүүлсэн нь

Их Эзэн дэлхийг Сэргээлтэд хэрхэн бэлтгэсэн талаар бид эргэцүүлэн бодохдоо, Тэрээр асар их зүйлийг хувь хүнээр буюу ердийн эрэгтэй, эмэгтэй хүмүүсээр дамжуулан зарим ер бусын гайхамшгийг бүтээсэн гэдгийг үргэлж санаж байх ёстой.

Дэлхий даяарх улс орнуудад олон хувь хүн, гэр бүл Сэргээлтийн захиасыг хүлээн авахад бэлтгэгдсэн байв. Тэдний дунд бошиглогчийн эцэг Иосеф, эх Люси Мак Смит нар байсан бөгөөд тэр хоёр Есүс Христийг хайрлаж, Библиэс суралцахыг заасан орчинд өсөж торнижээ.

Олон жилийн турш Иосеф, Люси хоёр Нэгдсэн Улсын зүүн хойд хэсэгт орших Нью Англандад санхүүгийн болоод эрүүл мэндийн мөн өөр бусад бэрхшээлийг туулж байжээ. 1816 онд Индонезийн Тамбора галт уулын дэлбэрэлтээс болж дэлхийн цаг уурын байдалд өөрчлөлт орж, тэд ургацаа алдсан тул Иосеф, Люси хоёр гэр бүл, найз нөхөд, нийгмийн хүрээллээ орхин Шинэ Англиас явах зоригтой шийдвэрийг гаргасан юм.

Сүмийн түүхийн 1-р ботид “Ахмад Иосеф эхнэр, хүүхдүүдээ тун их хайрладаг байсан ч амьдралаа тогтвортой авч явж чадахгүй байлаа. Азгүй явдал, амжилтгүй хөрөнгө оруулалтууд гэр бүлийг нь ядуу, тарчиг амьдрахад хүргэсээр байв. Нью-Йоркт байдал өөрөөр эргэж ч магадгүй”[16] хэмээн бичигдсэн байдаг.

Ямартай ч Смитийн гэр бүлийн Нью Ингландын бүтэлгүйтэл тэднийг баруун Нью-Йорк руу явахад хүргэсэн бөгөөд тэнд өрнөж байсан шашны хөдөлгөөн Бага Иосеф Смитийн өршөөл, удирдамж эрэлхийлэх хүсэл эрмэлзлийг өдөөсөн юм. Энэ нь мөн алтан ялтаснуудыг булсан газар байсан бөгөөд түүнийг олж, орчуулж, хэвлэн гаргахыг хүлээж байв.





Их Эзэн биднийг хүчирхэгжүүлэн, шинэ зүйлсийг зааж, бүтэлгүйтэл, саад бэрхшээлээр дамжуулан төсөөлж байснаас маань тэс өөр ирээдүйд бэлтгэх чадвартай.

Бидний амьдралд оролцох Их Эзэн мутрыг таних нь

Их Эзэн Смитийн гэр бүлийг хүчирхэгжүүлсэн шиг биднийг ч мөн адил хүчирхэгжүүлэн, шинэ зүйлийг зааж, бүтэлгүйтэл, саад бэрхшээлээр дамжуулан төсөөлж байснаас маань тэс өөр ирээдүйд бэлтгэх болно.

Бид Смитийн гэр бүлийн амьдралд Их Эзэний мутар хэрхэн нөлөөлсөн талаар бодохдоо Түүний мутар бидний хүн нэг бүрийн амьдралд ч гэсэн нөлөөлдгийг ухааран ойлгох ёстой. Өөрсдийн амьдралаас Их Эзэний мутрыг олж харахад сүнслэг байдлын хувьд мэдрэг байх ёстой бөгөөд ихэнх тохиолдолд цаг хугацаа, алсын хараа шаардагддаг. Аз болоход патриархын адислал, хувийн тэмдэглэл, хувь хүний амьдралын түүх зэрэг нь Их Эзэний мутар бидний амьдралд хэрхэн нөлөөлдөг болохыг харах томруулдаг шил болж өгдөг.

1831 онд өгсөн илчлэлтэд Их Эзэн "Мөн бүх зүйл дээр түүний гарыг хүлээн зөвшөөрдөггүй, мөн түүний зарлигуудыг дуулгавартайгаар үл дагадаг тэднээс бусад хүмүүн ямар ч зүйлээр Бурханд гэм бурууг үйлддэггүй, эсвээс хэний ч эсрэг түүний уур хилэн дүрэлздэггүй" (Сургаал ба Гэрээ 59:21) хэмээн дэлхийнхэнд анхааруулсан.

Бидний амьдралд оролцдог Их Эзэний мутрыг мөн Есүс Христийн Сүмийн Сэргээлтэд дэлхийг бэлтгэж буй Түүний мутрыг олж харан, хүлээн зөвшөөрөх юм бол Их Эзэн Есүс Христийн зарлигуудыг, ялангуяа Бурханыг болон хөршөө өөрийн адил хайрла хэмээх хоёр зарлигийг дагах бидний хүсэл өсөн нэмэгдэх болно. Энэ бол "гайхамшигт ажил ба гайхамшиг"(2 Нифай 25:17) юм.

Их Эзэн Өөрийн мөнхийн сайн мэдээний Сэргээлтэд дэлхийг бэлтгэсэнтэй адил эдүгээ Өөрийн Хоёр дахь Ирэлтэд дэлхийг бэлтгэж байна. Дахин хэлэхэд, Түүний мутрыг түүхэн өөрчлөлтийн үйл явдлуудаас гадна хувь хүний амьдралаас олж хардаг.

Иосеф Смит өнөө үед бидний ариун хэмээн нэрлэдэг ой руу очихдоо амьдралдаа өршөөл,

ХҮҮХЭДТЭЙГЭЭ ХАМТ БАЙГАА ЭХИЙН ЗУРГИЙГ ЖИМ ЛИЛЛИВАЙТ АВАВ




THE

BOOK OF MORMON:

AN ACCOUNT WRITTEN BY THE HAND OF MORMON, UPON PLATES TAKEN FROM THE PLATES OF NEPHI.

BY JOSEPH SMITH, JUNIOR,

AUTHOR AND PROPRIETOR.

PALMYRA:

PRINTED BY E. B. GRANDIN, FOR THE AUTHOR.

1830.

Их Эзэн Өврийн үүрдийн сайн мэдээний Сэргээлтэд дэлхийг бэлтгэсэнтэй адил одоо Өврийн Хоёр дахь ирэлтэд дэлхийг бэлтгэж байна. Зүүн талд: 1830 оны Мормоны Номын нүүр хуудас

удирдамж эрэлхийлж байсан.[17] Нэг талаараа, тэр Матайн номд цэдэглэгдсэн Их Эзэний сүнсээр өдөөгдсөн дараах урилгад хариулсан юм.

"Зүдэж зүтгэгсэд хийгээд хүнд ачаа үүрсэн бүгд ээ, Над дээр ир. Би та нарыг амраая.

Буулгыг минь өөрсөд дээрээ ав. Надаас сур. Би дөлгөөн, зүрхэндээ даруу. Та нар сэтгэлдээ амралтыг олох болно.

Буулга минь аятай, ачаа минь хөнгөн" (Матай 11:28–30) хэмээн гуйдаг.

Их Эзэний мутар эхлэлээс эхлэн Бурханы бүх хүүхэд ашиглах боломжтой "Христийн авралын сургаал"-ын болон Есүс Христийн "үнэн, цэвэр хийгээд энгийн сайн мэдээний" Сэргээлтэд дэлхийг бэлтгэсэн гэдгийг би гэрчилж байна.[18] Их Эзэний мутар бидний хүн нэг бүрийн амьдралд байдаг бөгөөд Түүнийг дагаж, бусдад үйлчилж, Түүний агуу Хоёр дахь ирэлтэд дэлхийг бэлтгэх үеэр Түүнийг хайрлахад биднийг урьж байдгийг би бас гэрчилж байна. ■

ГЭР БҮЛИЙН ЗУРГИЙГ ВЭНДИ ГИББС КИЙЛЭР АВАВ

ЭШЛЭЛҮҮД

1. Бригам Янг, *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 616; мөн Brigham Young, "Remarks," *Deseret News,* Oct. 26, 1859, 266-г үзнэ үү.
2. Тээвэр, харилцаа холбоо, машин техник, эрүүл мэндийн хөгжил дэвшил нь Их Эзэний сайн мэдээний болон Сүмийн Сэргээлтэд бэлтгэх ажлын чухал хэсэг юм.
3. L. D. Reynolds and N. G. Wilson, *Scribes and Scholars: A Guide to the Transmission of Greek and Latin Literature,* 4th ed. (2013)-ыг үзнэ үү.
4. Жишээ нь: АНУ-ын Эрх чөлөөний тунхаг, Их Британийн парламентын албан ёсны акт, еврей синагогуудад ашигладаг Тора хуудас, зарим их сургуулийн дипломууд.
5. Timothy H. Lim and John J. Collins, *The Oxford Handbook of the Dead Sea Scrolls* (2010) and Bruce M. Metzger and Bart D. Ehrman, *The Text of the New Testament: Its Transmission, Corruption, and Restoration,* 4th ed. (2005)-ыг үзнэ үү.
6. Thomas A. Wayment, *The New Testament: A Translation for Latter-day Saints, A Study Bible* (2019), 2.
7. Diana Childress, *Johannes Gutenberg and the Printing Press* (2008)-ыг үзнэ үү.
8. Жишээлбэл, M. Russell Ballard, "The Miracle of the Holy Bible," *Liahona,* May 2007, 80–82-ыг үзнэ үү.
9. Elizabeth L. Eisenstein, *The Printing Press as an Agent of Change* (1980), 703-ыг үзнэ үү.
10. James Carleton Paget and Joachim Schaper, eds., *The New Cambridge History of the Bible, Vol. 1, From the Beginnings to 600* (2013); see also vols. 2–4-ийг үзнэ үү.
11. 4-р зууны энэхүү латин хэл дээрх орчуулгыг католик сүмд албан ёсоор хэрэглэх болсон юм; *Martin Luther: The Christian between God and Death* (1999) Richard Marius-ийг үзнэ үү.
12. David Daniell, *William Tyndale: A Biography* (1994)-ыг үзнэ үү.
13. Дараа нь Тиндалын цогцсыг шонд хүлээтэй чигээр нь шатаажээ.
14. Уиллиам Тиндалын англи хэл дээрх орчуулга хүлээн зөвшөөрөгдөөгүй ч, 1611 онд Библийн Хаан Жеймсийн хувилбарт хадгалагдан үлджээ.
15. David Norton, *The King James Bible: A Short History from Tyndale to Today* (2011)-ийг үзнэ үү.
16. *Гэгээнтнүүд: Хожмын үеийн Есүс Христийн Сүмийн түүх, 1-р боть: Үнэний жишиг, 1815–1846,* (2018), 6-г үзнэ үү.
17. "First Vision Accounts," Gospel Topics, topics.ChurchofJesusChrist.org-ийг үзнэ үү.
18. M.Рассэлл Баллардын "Есүс Христийн үнэн, цэвэр хийгээд энгийн сайн мэдээ" гэх *2019 оны 4-р сарын Ерөнхий чуулган* дээр хэлсэн үгэнд орсон Жозеф Ф.Смитийн тухай хэсгийг үзнэ үү.



ХҮҮХДҮҮД БА ӨСВӨР ҮЕИЙНХЭН: Хүчирхэг эхлэл

Сүмийн удирдагчид хүүхэд, өсвөр үеийнхнийг Аврагчтай илүү адилхан болоход нь эцэг эхчүүд болон тойргууд хэрхэн тусалж болох талаар хуваалцав.



Бонни Х.Кордон
Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч

Стивэн В.Өуэн
Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч



Жой Д.Жонс
Хүүхдийн хэсгийн ерөнхий ерөнхийлөгчэгдүгээр зөвлөх

"Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн" хэмээх Сүмийн шинэ хөтөлбөрт та баярлаж эсвэл бага зэрэг сэтгэл түгшиж байж болох ч энэ талаар танд "Энэ хөтөлбөр манай хүүхдэд хэрхэн туслах вэ?" "Бид үүнийг хэрхэн хэрэгжүүлэх вэ?" "Үүнд би ямар үүрэг гүйцэтгэх вэ?" гэх мэт асуулт төрж болох юм.

Сүмийн удирдагчид зарим асуултад хариулт өглөө.

Яагаад Сүм энэ өөрчлөлтийг хийж байгаа вэ?

Бонни Х.Кордон эгч: Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон бидэнд бүгдээрээ илчлэлт хүлээн авах чадвараа хөгжүүлэх хэрэгтэй[1] хэмээн заасан. "Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн" хөтөлбөр нь гэрээний замаар явснаар хэрхэн баяр баясгаланг олж, өсөж хөгжих талаар Сүнслэг удирдамж эрэлхийлэхэд хувь хүн, гэр бүлүүдийг урихад зориулагдсан. Энэ нь бидний хүн нэг бүрийн төлөө бошиглогчийн төсөөлөн харж байгаа зүйлтэй гайхалтай зохицож байгаа юм.

Стивэн В.Өуэн ах: Түүнчлэн ерөнхийлөгч Нэлсон ямар гэр орontой байсан ч манай Сүм гэр оронд төвлөрсөн гэдгийг бидэнд зааж байна.[2] Бид бол хөтөлбөрт төвлөрсөн Сүм биш. Сүмийн удирдагч, багш нар манай хүүхдүүдэд сургаалаас суралцаж, үүний дагуу амьдрахад тусалж чадна. Харин энэ нь гэр орноос эхэлдэг бөгөөд өдөр тутам үүрэх ёстой үүрэг хариуцлага юм.

Бошиглогчийн зааснаар, бид илчлэлт эрэлхийлж, Сүнсийг дагах хэрэгтэй бөгөөд "Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн" хөтөлбөр зарим талаараа илүү хялбаршуулсан хувилбар тул үүнийг үйлдэхэд бидэнд туслах болно. Урьд нь өсвөр насны хүүхдүүдийнхээ өсөж хөгжих явцад нь хянаж шалгах, ойлгож мэдэх гэсэн эцэг эхчүүдийн хэдэн зуун шаардлага Хувийн хөгжил дэвшил, Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх

нь, Бурханд итгэх итгэл болон Сүмийн бусад хөтөлбөрт байсан. Энэхүү шинэ арга зам нь өөрсдийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн зорилго тавихдаа сүнслэг өдөөлтийг эрэлхийлэхэд хүүхдэд, өсвөр үеийнхнийг урих болно.

Жой Д.Жонс эгч: Энэ бол өсөж буй үеийнхэн болох хүүхэд, өсвөр үеийнхний Есүс Христэд итгэх итгэлийг гүнзгийрүүлэхэд зориулсан сэтгэл хөдлөм боломж юм. Тэд Ариун Сүнсний удирдамжийг эрэлхийлж, дагахад суралцахдаа мөнхийн мөн чанар, зорилгоо мөн хэрхэн өсөж хөгжиж, Тэнгэрлэг Эцэгийн өөрсдийг нь гэх хайрыг мэдрэхээ илүү сайн ойлгох болно. "Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн" хөтөлбөрт төвлөрөх нь өсвөр үеийнхнийг болон тэдний гэр бүлүүдийг гэр орондоо төдийгүй сүм дээр мөн Тэнгэрлэг Эцэгтэйгээ харилцаа холбоо тогтоож, хөгжүүлэхэд нь адисалж, хүчирхэгжүүлж чадна.

"Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн" хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэхийн тулд гэр бүлүүдийн хийвэл зохих эхний алхмууд юу вэ?

Жонс эгч: Сүнсний удирдамж авахын төлөө хамтдаа залбир. Эцэг эхчүүд "Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн" хөтөлбөрийг гурван хүрээнд хэрэгжүүлэх талаар гэр бүлтэйгээ ярилцсанаар эхэлж болно. Үүнд: сайн мэдээнээс суралцах, үйлчлэл ба үйл ажиллагаанууд, хувийн хөгжил дэвшил орно. Тэд одоо юу хийж байгаа вэ? Тэд эдгээр гурван хүрээнд хувь хүний болон гэр бүлийн хувьд хэрхэн өсөж хөгжиж болох вэ? Лук 2:52-т анхаарлаа төвлөрүүлэх нь Аврагчийг санаж, дагахад чиглэгдсэн төлөвлөгөө, зорилгыг тавихад хэрхэн удирдан залж туслах вэ? Энэ нь өсвөр үеийнхнийг төдийгүй гэр орон, гэр бүлийг маш энгийн бөгөөд тогтмол, утга учир бүхий арга замаар хүчирхэгжүүлэх гайхалтай сайн боломж юм.

Кордон эгч: Бид бага багаар эхэлнэ. Гэрээт замаар алхах гэдэг нь үнэндээ ганц ганц алхмаар урагшлах гэсэн үг юм. Нэг зорилго тавь. Энгийнээр эхэл. Өсвөр үеийнхэнд болон хүүхдүүдэд зориулсан удирдамж нь гайхалтай дагах загварыг бидэнд өгөх болно.

Өүэн ах: Бид үүнийг хэт төвөгтэй болгох хэрэггүй. Энэ бол маш энгийн зүйл юм. Лук

УСНЫ ХАЖУУХАНД, САЙМОН ДЬЮГИЙН ЗУРГИЙН ХЭСГЭЭС

2:52-ыг уншаарай. Тэндээс эхэл. Эцэг эхчүүд хүүхэд, өсвөр үеийнхэнтэйгээ гэртээ суугаад, энэ тухай ярилцаж болно. Тухайлбал: "Бид чамайг мэргэн ухаан, бие хаагаараа өсөж хөгжин, Бурханы хийгээд хүмүүсийн таалалд нийцэхэд хэрхэн туслах вэ?" "Бид хамтдаа юунд суралцаж эсвэл юу хийж болох вэ?" "Чи ямар ямар зорилго тавьж болох вэ?" Зүгээр л энгийн хялбар болго.

Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэхэд нэг л зүйлийг хүүхэд, өсвөр үеийнхэнд зааж сургах хэрэгтэй бол тэр нь юу байх вэ?

Кордон эгч: Энэ бол Аврагчийн адил өсөж хөгжих гайхалтай боломж юм! Хэрэв бид "Би юунд анхаарлаа төвлөрүүлэх вэ?" гэж бодож байвал Түүнтэй адилхан болохын тулд олон зүйлийг аль эртнээс хийж байгаагаа санаарай. Олон гэр оронд, бас сүм дээр хүмүүс сайн мэдээнээс суралцаж байгаа. Бид мөн үйлчилж, үйл ажиллагаануудад оролцож байгаа. Энэхүү шинэ хөтөлбөр нь суралцаж байгаа зүйлийнхээ дагуу үйлдэх, үүндээ хариуцлагатай хандах мөн сүнслэг байдал, нийгэм, бие махбод, оюун санааны гэх Аврагчийн өсөж хөгжсөн дөрвөн тал дээр төвлөрөхөд бидэнд туслах энгийн арга зам юм. (Лук 2:52-ыг үзнэ үү). Энэ нь Аврагчийг дагах үед бид бүгдэд баяр баясгалан, амар амгалан, мөнхийн аз жаргалыг авчрах болно!

Жонс эгч: Хөгжил дэвшил нь Аврагч руу чиглэсэн, гэр бүлд төвлөрсөн, Сүмээр дэмжигдсэн байдаг. Энэ нь хуучин хөтөлбөрүүдийг хэрэглэхээ больж хялбарчлан, хувь хүн рүү чиглэсэн болгож байгаа юм. Хувь хүн бүр өсөж хөгжинө. Хүүхэд, өсвөр үеийнхэн болон удирдагчид мөн тэдний гэр бүлүүд энэ хөтөлбөрийг дэлхий даяарх Тэнгэрлэг Эцэгийн бүх хүүхдэд гэрээний зам дээр хамтдаа хөгжиж, мөнхийн баяр хөөрийг мэдрэхэд зориулагдсан боломжийн, уян хатан арга зам гэдгийг ойлгоно гэдэгт би итгэж байна. Энэ нь том өөрчлөлт биш, суралцах арга барилыг хүндрүүлж байгаа хэрэг ч биш юм. Харин энэ нь Сүнсээр удирдуулж байхдаа аль хэдийн хийж байгаагаасаа илүү ихийг хийснээр Аврагчийг илүү их хайрлаж, үр дүнтэй дагах чадвараа өсгөн нэмэгдүүлэхийн тулд чин сэтгэлээсээ хүчин чармайлт гаргахыг хэлж байгаа юм.

Аврагчийн адил хөгжиж дэвших нь өсвөр үеийнхний болон хүүхдүүдийн хувьд яагаад чухал вэ?

Жонс эгч: Хамгийн эхний бөгөөд илүү чухал зүйл бол тэд Түүнийг байнга дагах гэрээг байгуулсан. Тэд "ямар ч цагт мөн бүх зүйлд мөн өөрийн байж болох хаана ч гэсэн Бурханы гэрчлэгч" (Мозая 18:9) байх гэрээг байгуулсан. Тиймээс тэд сүнслэг байдал, нийгэм, бие махбод, оюун санааны хувьд Аврагчтай адил өсөж хөгжих хэрэгтэй. Тэдний байгуулсан гэрээнүүд зөвхөн дээрх зүйлүүдийг хийж гүйцэтгэх *учир шалтгаан* биш бөгөөд зорилгодоо хүрэхэд нь дэмжлэг үзүүлэх *чадварыг* тэдэнд суулгах зорилготой.

Өүэн ах: Бидний амьдралын цорын ганц зорилго бол Тэнгэрлэг Эцэг, Түүний Хүү Есүс Христ хоёрыг дагаж, тэдэнтэй адилхан болох явдал юм. Бид Тэдэнтэй адилхан байхыг хүсдэг. Бид бага наснаасаа үүнийг хийж эхэлснээр үлдсэн амьдралынхаа турш дагах загвартай болдог. Бид Аврагчийн хийсэн зүйлсийг хийснээр Түүнийг үнэхээр дагаж байгаа хэрэг юм.

Кордон эгч: Аврагч бүх зүйл дээр бидэнд үлгэр жишээ болдог. Бид Түүний амьдрал, үйл хэрэг, сургаалыг судалдаг. Учир нь Тэр бол бидний тэмүүлдэг бүх зүйл билээ. Гэвч бидний хүн нэг бүр өвөрмөц, онцгой тул бидэнд Түүнтэй адилхан болохын тулд хөгжүүлэх ёстой зан чанар, ур чадварууд бий. Энэхүү шинэ арга зам нь хүүхэд, өсвөр үеийнхэнд өөртөө тохирсон арга замаар өсөж хөгжин, өөр өөрсдийн бэлгийг хөгжүүлж, Түүнтэй адилхан болохын тулд хийвэл зохих сүнсээр өдөөгдсөн зүйлсээ тодорхойлох боломжийг олгодог. Энэ нь үүнийг хувь хүн рүү чиглэсэн болгож байгаа юм. Үүнд заавал дагах заавар гэж байхгүй. Хүн бүрийн гэрээний замаар урагш явахаар тавьсан зорилго өөр өөр байж болох ч бид хамтдаа Аврагчид илүү ойртож, суралцаж, өсөж хөгжих болно.

Хүүхэд, өсвөр үеийнхэн үүнд оролцсоноор юу мэдэрнэ гэж та найдаж байна вэ?

Кордон эгч: Тэд мөнхийн мөн чанарынхаа талаар илүү гүнзгий ойлгодог болж, салшгүй нэгэн хэсэг гэдгээ мэдрэх байх гэж би найдаж байна. Бид хэн гэдгээ, Хэнийх гэдгээ мэдэх юм бол үйлдэл маань өөрчлөгддөг. Тэд цахим сүлжээн дэх зарим зүйл худал гэдгийг ухааран ойлгодог. Учир нь тэд Сүнс тэдэнтэй хэрхэн ярьдгийг өөрийн туршлагаар мэдрэх болно. Тэд Бурханы охид, хөвгүүдийн хувьд өөрсдөдөө болон бурханлаг чадавхдаа итгэх итгэлийг олж авна.

Жонс эгч: Бид тэднийг Есүс Христэд итгэх итгэл, найдвар, зарлигуудыг дагаснаар хүлээн авдаг амар амгаланг мэдэрч, эрүүл харилцаа гэж юу болохыг мэдэж авч, тэсвэр тэвчээртэй байхад суралцаж мөн бусдад үйлчлэхийн баяр баясгаланг мэдэрч, авралын ажилд оролцсоноор ирэх аз жаргал, сэтгэл хангалуун байдлыг мэдрээсэй хэмээн хүсэж байна.

Өүэн ах: Хүүхдүүд сайн мэдээг оюун ухаанаасаа зүрх сэтгэл рүүгээ хүргэх замаар ойлгоно байх гэж би найдаж байна. Энэ нь хийсэн зүйлээ чагтлаад орхих зүйл биш юм. Харин энэ нь суралцах, Аврагчтай

илүү адилхан болох үйл явц юм. Манай хүүхдүүд болон бидний тохинуулдаг хүмүүс сайн мэдээний талаарх өөрсдийн ойлголтод хангалттай итгэлтэй болж, бусдад энэ талаар заана байх гэдэгт би найдаж байна. Жишээлбэл, биднийг хүүхдүүдээсээ сайн мэдээний талаар асуух үед тэд энэ талаар суралцсан мөн энэ нь тэдний салшгүй нэгэн хэсэг болсон учраас гүн гүнзгий хариулт өгдөг болохыг нь сонсдог болно хэмээн найдаж байна.

Эцэг эхчүүд "Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн" хөтөлбөр гэр оронд нь амжилттай хэрэгжиж байгааг хэрхэн мэдэж болох вэ?

Өүэн ах: Би гэр орон илүү амар тайван байх гэх мэт Галат 5-д цэдэглэгдсэн Сүнсний үр жимсийг олж харахыг хичээнэ. Би тэдний хүүхдүүдийг илүү эелдэг, хайраар дүүрэн байх болно гэж бодож байна. Тэд гэр бүлийнхэнтэйгээ хамт байхыг хүсэж, хариултаа авахын тулд илүү их залбирч, эрэлхийлдэг болсон байна. Тэд зөвхөн сүнслэг байдлын хувьд биш, харин нийгмийн болоод бие махбод, оюун санааны тал дээр өсөж хөгжсөн байхыг харах болно.

Жонс эгч: Энэ хөтөлбөр амжилттай хэрэгжиж байгааг хоорондын харилцаа нь хүчирхэгжиж, гэр бүлийн гишүүд саад бэрхшээл тулгарсан ч бодит өөрчлөлтийг мэдэрч, бууж өгөхгүйг хичээн мөн нэг нэгнээ дэмжиж, хайр халамжаа үзүүлэн, Ариун Сүнсний нөлөөг идэвхтэй эрэлхийлж, түүнчлэн Ариун Сүнс гэр оронд нь оршиж байгаагаар мэдэх болно. Гэр бүлийн гишүүд өөрсдийн өдөр бүр хийдэг зүйлсийг Христийн амьдралтай холбоотой болохыг харж болох юм. Магадгүй сонгох эрх, наманчлал зэрэгт илүү их талархах болж, аливаад хандах хандлага нь сайжирч, өөртөө итгэх итгэл нь нэмэгдэн, алдаа дутагдлаа гаднаас биш, дотроосоо олж харахыг хичээж; Аврагч, Түүний амьдрал, сургаал, үлгэр жишээ, Цагаатгалд болон Амилалтад илүү их талархдаг болж болох юм.

Сүмийн хуучин хөтөлбөрийг мөрдөхөө больж байгаад сэтгэл нь бага зэрэг зовниж байж болох эцэг эхчүүдэд та ямар зөвлөгөө өгөх вэ?

Кордон эгч: Мэдээж, бидний хүн нэг бүр хуучин хөтөлбөрийн ачаар хөгжиж мөн бусдын хөгжиж байгааг харж байсан тул уг хөтөлбөрүүдэд хайртай байх нь ойлгомжтой. Тэдгээр нь тухайн цаг үедээ тохирсон, сүнсээр өдөөгдсөн хөтөлбөр байсан. Гэхдээ бид илчлэлт үргэлжлүүлэн хүлээн авч байгаадаа талархахгүй гэж үү? Их Эзэн биднийг цааш өсөж хөгжин, өөрчлөгдөөсэй гэж хүсдэг бөгөөд хөтөлбөрөө дэлхий даяарх гишүүдийнхээ хэрэгцээ шаардлагыг хангахын тулд хөгжүүлж, өөрчлөх хэрэгтэй гэж үздэг. Бид үргэлж Тэнгэрлэг Эцэгийнхээ мэддэг мөн Түүний хүсдэг хүмүүс, Сүм нь болж өсөж хөгжин, өөрчлөгдөхийг хичээдэг.

Жонс эгч: Хуучин хөтөлбөрүүд биднийг асар их адисалсан бөгөөд бид сурч мэдэж, үзэж харсан бүх зүйлдээ талархдаг. Энэ бол гайхалтай шинэ үеийн эхлэл бөгөөд шинэлэг, сүнсээр өдөөгдсөн арга замаар сурч, өсөж хөгжихийн тулд Их Эзэний удирдамжийг эрэлхийлэх гайхалтай боломж юм.

Удирдагчид хүүхэд, өсвөр үеийнхэнд хувиараа өсөж хөгжихөд нь хэрхэн тусалж чадах вэ?

Өүэн ах: Юуны түрүүнд, насанд хүрсэн удирдагч тухайн хүүхэд, залуу эрэгтэй эсвэл залуу эмэгтэйг Бурханы мэлмийгээр харах буюу одоо байгаагаар нь биш, харин ирээдүйд хэн болж чадахаар нь харах хэрэгтэй гэж би боддог. Эцэст нь хэн болохыг бодож эхлэлээ тавих хэрэгтэй. Алсын хараатай бай. Үүнийг хийхэд цаг хугацаа шаардлагатай. Хүүхэд, өсвөр үеийнхнийг хэн болж чадахаар нь хар. Таныг өсвөр үеийнхэнд хандан ярих үед тэд үгийг тань сонсох хэмжээнд хүндэлдэг байхаар сайн харилцаатай бай.

Мөн тэдний эцэг эхтэй танилц. Хүүхдүүдэд нь хэрхэн тусалж болохыг тэднээс мэдэж ав. Эцэг эхийнх нь үүргийг хүндэл.

Жонс эгч: Хүүхдийн хэсэгт залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдтэй адилхан чуулгын болон ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн зохион байгуулалт байдаггүй. Хүүхдийн хэсгийн удирдагч, багш нар болон тохинуулагч ах, эгч нар гэр оронд нь сайн мэдээний дэмжлэг туслалцаа байдаггүй хүүхдүүдэд тусалдаг. Гэхдээ гэр орных нь нөхцөл байдал ямар ч бай, бид хүүхэд, өсвөр үеийнхний болон тэдний эцэг эхийн хоорондын харилцааг үргэлж хүндлэх хэрэгтэй. "Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн" хөтөлбөр нь гэр бүлийн бүх гишүүнийг ирж, харж мөн туслахад урих арга замыг өгнө. Энэ нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн мөн эсэхээс үл хамааран гэр бүлийнхнийг бүгдийг нь хүчирхэгжүүлэх арга зам байж болох юм.

Кордон эгч: Ням гарагт сүмд хамт ирдэггүй ч өөрсдийг нь хайрладаг аав, ээжтэй олон хүүхэд, өсвөр үеийнхэн бий. Эцэг эхчүүдтэй нь танилцаж, хүүхдүүдийнхээ төлөө юу мөрөөдөж, хүсэж эрмэлздэгийг нь мэдэж аваарай хэмээн би удирдагчдад уриалж байна. Бид тэдэнд тусалж чадна. Бид эцэг эхчүүдтэй хамтран ажилласнаар, хувь хүн *болон* гэр орныг хүчирхэгжүүлэхийн зэрэгцээ хүүхэд, өсвөр үеийнхнийг нэг нэгнийхээ гэр орныг хүчирхэгжүүлэхэд урамшуулан дэмжих болно.

Та "Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн" хөтөлбөрт оролцоход нь хүүхдүүддээ тусалж чадахгүй байх хэмээн эмээж, сэтгэл нь зовж буй эцэг эхчүүдэд хандан юу гэж хэлэх вэ?

Кордон эгч: Хамгийн гайхамшигтай зүйл бол бид аль хэдийн ихэнх зүйлийг хийгээд явж байгаа. Гэр бүлүүд аль хэдийн сайн мэдээнээс хамтдаа суралцаж байгаа. Бид бас эртнээс эхлэн үйлчлэл хийж, үйл ажиллагаанууд явуулж байгаа. Бид үргэлж хувийн хөгжил дэвжилд анхааран ажилласаар ирсэн. Гагцхүү одоо бид Христийн өсөж хөгжсөн арга зам дээр л анхаарлаа хандуулж байгаа юм.

Хүүхдүүдтэйгээ хамт суух нь бидэнд маш их сэтгэлийн таашаал өгнө гэж би боддог. Та хүүхдүүдийнхээ чин хүсэл зорилгыг энгэл жирийн арга замаар сонсоно. Бидний Тэнгэрлэг Эцэг таны хүүхдийг өсөж хөгжин, баяр баясгалантай болж, Өөртэй нь хамт амьдрахаар эргэн ирээсэй гэж хүсдэг. Та нар *хамтдаа* сайн мэдээг болон бидний Аврагч Есүс Христийг амьдралынхаа бүхий л тал дээр салшгүй нэгэн хэсэг болгохыг хичээснээр Ариун Сүнс удирдан чиглүүлж байгааг мэдрэх болно.

Жонс эгч: Гэр бүлийн тань хувьд болж бүтэж байгаа арга замаас эхэл. Тэнгэрийн тусламж авна гэдэгтээ итгэ. Сүнсний удирдамжийг эрэлхийл. "Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн" хөтөлбөр нь эцэг эхийн үнэ цэнтэй зэмсэг байх болно. Өнөө үед гэр бүлээ удирдан чиглүүлж, хайрлан халамжлахад эцэг эхчүүдэд олон шаардлага тавигдаж байна. Заримдаа хэт их ачаа үүрч байна гэж бодогдох үе бий. "Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн" хөтөлбөр нь хүүхдүүддээ наад захын хэрэгцээ, чухал зүйл хоёрыг хэрхэн ялгаж салгах талаар зааж сургахад нь эцэг эхчүүдэд тусална. Ариун Сүнсний өдөөлтөөр дамжуулан Аврагчийг хэрхэн дагах талаар суралцахад нь гэр бүлүүддээ туслах нь бидний хувьд амин чухал бөгөөд энэ нь Их Эзэний хайр, адислалыг авчрах болно.

Өүэн ах: Та нар хүүхэд, өсвөр үеийнхэндээ үнэхээр туслах боломжтой байх болно гэж би бодож байна. Та агуу зүйл хийх шаардлагагүй. Хамгийн гол зүйл бол итгэлтэй байж, залбирч, гэр бүлдээ ариун нандин, зөв шударга дадал хэвшлийг суулгах явдал юм. Энгийн, хялбар, зөв шударга дадал хэвшлээс эхэл. Тэгэх юм бол хүүхдүүдийн тань амьдралд гайхамшиг тохиохыг та харах болно. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Рассэлл М.Нэлсон, "Сүмд болон бидний амьдралд зориулсан илчлэлт," *2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 115–120-ийг үзнэ үү.
2. Рассэлл М.Нэлсон, "Нээлтийн үг," *2018 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 3–4-ийг үзнэ үү.

ТУСЛАХ ЭХ СУРВАЛЖУУД

Лиахона дээр:

- Вэнди Улрич, "Өсөж буй үеийнхнийг зоригжуулах нь," *Лиахона,* 2020 оны 1-р сар, 26.
- Хэтэр Бөргэсон ба Аманда Данн, "Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн: Өдөр бүрийн амьдралдаа анхаарлаа төвлөрүүлэх нь," *Лиахона,* 2020 оны 1-р сар, 52.
- Жой Д.Жонс, "Өдөр бүр өмнөхөөсөө арай илүү бай," Найз, 2020 оны 1-р сар, Н8.
- Бритни Бийтти, "Хүүхэд, өсвөр үеийнхэнд тохинуулах," *Лиахона,* 2019 оны 12-р сар, 36.

Онлайн: **childrenandyouth.ChurchofJesusChrist.org**

Өсөж буй үеийнхэнд сэдэл төрүүлэх нь

Хүүхдүүддээ Аврагчийн адил өсөж хөгжихийн тулд утга учиртай зорилго тавьж, түүндээ хүрэхэд нь туслах дөрвөн арга замыг энд танилцуулъя.

Доктор Вэнди Улрич

Бид эцэг эх, удирдагчдын хувьд хүүхэд, өсвөр үеийнхнийг Их Эзэнд үйлчилж, тус тусын үүргээ биелүүлэхдээ өөрөө өөрсдөдөө сэдэл өгдөг байхад мөн насан туршдаа Есүс Христийн шавь байхад нь туслахыг хүсдэг.

Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн хөтөлбөр нь энгийн боловч хүүхэд, өсвөр үеийнхэнд сүнслэг байдал, нийгэм, бие махбод, оюун санааны хувьд Аврагчийн адил өсөж хөгжихөд нь туслах хүчирхэг эх сурвалж юм (Лук 2:52-ыг үзнэ үү). Энэ нь тэднийг Есүс Христийн сайн мэдээнээс суралцан, үүний дагуу амьдарч, утга учир бүхий, сэтгэл хөдлөм үйлчлэл, үйл ажиллагаануудад оролцож, өөрсдөө зорилгоо тавьж, түүндээ хүрэх үед болох юм. Доорх түүхэнд өгүүлсэн эцэг эхийн адил бидэнд өөрсдийн хийх зүйлийн жагсаалтад өөр хүний зорилгыг нэмээгүй байсан ч аль хэдийн хэт хүнд ачаа үүрч буй мэт санагддаг байж болно. Эсвэл бид хүүхдүүдээ шахаж шаардахаас наашгүй өсөж хөгжихгүй хэмээн санаа зовдог байж болно.

Зорилго тавих тухай ярилцлагын 1 дэх жишээ:

15 настай Алана ээж Рэйчилтэйгээ хамт гаргасан, ажиллаж болох зорилгуудынхаа жагсаалтыг харж байв. Аланагийн аав Жэфф дэргэдүүр нь өнгөрөв. "Би эдгээрээс алийг нь хийх вэ, Аав аа?" гэж Алана асуулаа.

Жэфф цаг руугаа харан ярвайснаа, жагсаалтыг гүйлгэн харлаа. "Хмм, энэ амархан харагдаж байна. 'Нэг дуулал цээжлэх' гэж оруулбал яаж байна? Чи үүнийг дажгүй хурдан хийж чадна шүү дээ. Өөр бас юу амархан харагдаж байна?" гэлээ.

Рэйчэл хажуунаас нь орж ирээд, Аланаг сургуулийнхаа гүйлтийн багт багтах шалгаруулалтад орох дургүй байсныг санан, "Үнэндээ, чи хэцүү юм хийж үзэх хэрэгтэй байх аа! Дасгал хөдөлгөөнтэй юм байвал яаж байна?" хэмээн санал болгов.

"Аан" хэмээн Алана амандаа бувтнан, утсаа аваад, "Би ч болчихлоо" гэлээ.

Эцэг эх, удирдагчид хэрхэн тусалж чадах вэ?

Хүүхэд, өсвөр үеийнхэнд үнэт зүйлсийг хүлээн авч өөрсдийгөө сэдэлжүүлэх, зөв сонголт хийн, өсөлт хөгжил, амжилтынхаа аль алинд баясдаг болоход эцэг эх, удирдагчид маш их тусалж чадна.

Зорилгынхоо төлөө ажиллах хүчтэй сэдэл төрж байсан үеэ бод. Юу танд сэдэл төрүүлж байсан бэ? Та туйлын их хүсэж байсан боломж, чадвараа эсвэл шийдвэрлэх хэрэгтэй асуудлаа олж харсан нь гарцаагүй. Эсвэл бусдын үлгэр жишээ, дэмжлэг, оролдоод үзэх хэрэгтэй гэсэн сэдлийг танд төрүүлсэн байж болох юм.

Үүний адил хүүхэд, өсвөр үеийнхэн (1) юу хийхийг хүсэж байгаагаа залбирч шийдэн (зөвхөн бусдын тэднээс хүсэж байгааг биш), (2) түүндээ хүрэх төлөвлөгөө гаргаж, (3) шагнал эсвэл шийтгэлийн нөлөөнд хэт автахгүй байж, (4) эцэг эх, удирдагчид нь тэдний талд байгааг мэдэрснээр өөрөө өөрсдийгөө сэдэлжүүлэх болно.

1. Юуг хамгийн их хүсэж байгаагаа олж мэдэхэд нь өсвөр үеийнхэнд туслах

Хүн бүр ямар нэгэн зүйлийг хүсэж байдаг. Тухайлбал: багт орох, нойроо сайн авах, ганцаардахгүй байх, Бурхантай илүү ойртох гэх мэт. Их Эзэн болон Түүний элчүүд ихэвчлэн хүмүүсээс "Та юу хүсэж байна вэ?" (Марк 11:24; 1 Нифай 11:1–2; Алма 18:15; 3 Нифай 27:1–2; Ифер 2:23–25-ыг үзнэ үү) хэмээн асуудаг. Гэвч яг одоо юу хүсэж байгаагаа биш, хамгийн их хүсэж байгаа зүйлээ мэдэхэд туршлага, өөрийнхөө үйлдлийн талаар эргэцүүлэн бодох чадвар шаардагддаг.

Та туслахыг хүсэж байгаа хүүхэд эсвэл өсвөр насны хүүхдийнхээ талаар бодон, өөртөө дараах асуултуудыг тавь. Үүнд:

- Би эерэг харилцаа бүхий хөгжилтэй орчинд тэдэнд шинэ туршлага, үнэт зүйлс, санаануудыг хэрхэн танилцуулж болох вэ?
- Тэдэнд илүү сайн сонголт хийхийг заахын тулд хийсэн буруу сонголтынх нь үр дагаврыг амсуулах уу?
- Тэдний юунд итгэж, юуг үнэлдэг болохыг хэзээ асууж болох вэ? ("Олж мэдэхэд тустай асуултууд" гэсэн гарчигтай дагалдах жагсаалтыг үзнэ үү.)
- Би тэдний хүчтэй талыг хэрхэн онцлох вэ? (Ингэж хэлээд үз. "Чамайг ______________-дээ үнэхээр сайн гэж би хардаг. Чи үүнийгээ Их Эзэнд үйлчлэхэд хэрхэн ашиглаж болох вэ?")

2. Өсвөр үеийнхэнд төлөвлөгөө гаргахад нь туслах

Зорилгоо тодорхойлчихвол өсвөр үеийнхэн ихэвчлэн дажгүй сайн төлөвлөгөө гаргачихдаг. Бага насны хүүхдүүдэд нэмэлт санаа өгөх хэрэгтэй байж болно. Гэхдээ тэдэнд санаа орж ирэхгүй үед нь л санаа өгч болно. Тэдэнд таны санаанаас илүү өөрсдийнх нь санаа таалагдвал өөрийнхөө санааг хамгаалахын оронд баярла.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ДЭВИД ГРИЙН

Та бусдад төлөвлөгөө гаргахад нь туслахдаа дараах асуултыг тавьж болох юм. Үүнд:

- Чиний зорилго юу вэ? ("Эелдэг бай" гэх мэт ерөнхий зорилго тавихын оронд "Өдөр бүр хэн нэгэнд магтаалын үг хэлнэ" эсвэл "Уурласан үедээ уучлалт гуйна" гэсэн тодорхой үйлдэл оруулбал зохино.)
- Энэ зорилго чиний хувьд яагаад чухал вэ? (Энэ нь үнэт зүйлсийнхээ дагуу амьдарч, Аврагчтай илүү адилхан болоход тэдэнд хэрхэн туслах вэ?)
- Одоо энэ зорилго дээрээ ажиллахад зохимжтой цаг мөн үү? (Яагаад тийм эсвэл яагаад үгүй гэж?)
- Эхлэхийн тулд чиний хийж болох амархан, жижиг алхмууд юу вэ? (Үйлдэл нь сэдэл төрүүлдгийг сануул. Тэдэнд ямар нэгэн жижиг, энгийн юмнаас эхлэхэд мөн дахин эхлэхэд тусал.)
- Чи аливаа зүйлсийг төлөвлөгөөгөө дэмждэг байхаар хэрхэн зохицуулж болох вэ? (Сануулга хийх, урмын үгс бичиж тавих, өсөлт хөгжлөө хянах хүснэгт юм уу хуваарь гаргах, уруу таталтуудаас зайлсхийх, зөв хэрэгслүүдийг олох эсвэл тусламж хүсэх талаар бод.)
- Чамд ямар саад бэрхшээл тулгарч болох вэ? Тэдгээрийг хэрхэн зохицуулах вэ? (Тэдэнд төлөвлөгөөгөө санаж, юу нь буруу болсныг бодох, хэцүү хэсгүүд дээр илүү сайн ажиллах, шинэ аргаар оролдож үзэх эсвэл зорилгоо тааруулан өөрчлөхөд тусал.)

Бусдад саад бэрхшээлээ даван гарахад нь туслахын тулд та өөрийн эсвэл гэр бүлийнхээ туршлагаас сорилт бэрхшээлтэйгээ нүүр тулан, гуйвшгүй байсан хүмүүсийн тухай түүхийг хуваалцаж болно. Түүнчлэн дараах асуултуудыг тавьж болно.

- Чи юу хийж үзсэн бэ? Чи өөр юу хийж болох вэ?
- Хэн тусалж чадах вэ? Би хэрхэн тусалж болох вэ?
- Энэ талаар залбирах үед чамд ямар санаа орж ирж байна вэ?

3. Шагнаж эсвэл шийтгэхдээ болгоомжтой хандах

Багахан шагнал хүмүүст шинэ зүйлийг туршиж үзэх, хэцүү даалгаврыг илүү зугаатай болгох эсвэл амжилтаа тэмдэглэхэд тусалж болно. Харин хэтрүүлсэн үед шагнал үнэндээ урам зоригийг мохоодог. Үүрэг даалгавраа дуртай хийдэг байсан хүмүүс ихэвчлэн бага ажиллах болж, илүү хийх хэрэгтэй бол мөнгө төгрөг хардаг болдог. Өөрөөр хэлбэл, шагналын төлөө хийх нь ашиггүй гэж үзэж эхэлдэг. Хүүхдүүд муу сонголтынхоо үр дагаврыг амсах хэрэгтэй ч сайн үнэт зүйлсийг өөрийн болгож сурахын оронд шийтгэдэг хүмүүсээс айж, хэрхэн зайлсхийх аргад суралцдаг.

Хүмүүс хийсэн ажлынхаа төлөө төлбөр авах нь зүйтэй ч бонус өгөх эсвэл хийсэн ажлыг нь магтаж сайшаах нь эргээд тэдэнд сайнаар тусдаг. Гэхдээ сайн мэдээний дагуу амьдрах болон хувийн зорилгодоо хүрэх тухайд гэвэл, дотоод сэтгэлийн шагнал урт хугацааны үр өгөөжтэй байдаг. Дотоод сэтгэлийн шагналд дараах зүйлс багтана. Үүнд:

- Сүнсийг мэдрэх
- Эцэг эх, удирдагчидтайгаа болон найзуудтайгаа илүү дотно харилцаатай болох
- Үнэт зүйлсийнхээ дагуу амьдрах
- Суралцах, шинэ зүйлсийг оролдож үзэх, асуудал шийдвэрлэх
- Цагийг сайхан өнгөрүүлэх
- Сайнаар нөлөөлөх

Залуу хүмүүст эдгээр дотоод сэтгэлийн шагналыг таньж мэдэн, үнэлдэг болоход нь тусал. Хааяа үүргээ сайн гүйцэтгэснийх нь төлөө жижиг зүйлээр шагнаж бай.

4. Өсвөр үеийнхэнд хайрыг тань мэдрэхэд туслах

Хайраар дүүрэн харилцаа нь бусдын үнэт зүйлс, зорилго, сэдэлд нөлөөлөх хамгийн чухал арга замуудын нэг юм. Хүмүүс чин сэтгэлээсээ таныг хайрлаж, хүндэлдгээ танд хэрхэн ойлгуулж байсан бэ? Хэнд та алдаа дутагдал, хүнд хэцүү асуудлынхаа талаар санаа зоволтгүй, илэн далангүй хэлж ярихыг зөвшөөрдөг вэ? Хэрэв та гэр орондоо жинхэнэ хайрыг амсаагүй бол, танд байгаагүй юуг авах хэрэгтэй гэж боддог вэ?

Таны хариултууд залуу хүмүүст тантай харилцахдаа айж эмээх хэрэггүй бөгөөд та тэднийг хайрлаж, хүндэлдэг гэдгийг хэрхэн ойлгуулахыг олж мэдэхэд тань тусална.

Дадлага болон тэнгэрийн тусламжтайгаар бид өсөж буй үеийнхнийг урамшуулан зоригжуулж, нөлөөлж чадна.

Зорилго тавих тухай ярилцлагын 2 дахь жишээ:

15 настай Алана ээж Рэйчилтэйгээ хамт гаргасан, өөрийн ажиллаж болох зорилгуудын жагсаалтыг харж байх үед түүний аав Жэфф дэргэдүүр нь өнгөрөв. "Би эдгээрээс алийг нь хийсэн нь дээр вэ, аав аа?" гэж Алана асуулаа.

Жэфф цаг руугаа хяламхийснээ, жагсаалтыг гүйлгэн харав. "Хмм, энэ амархан харагдаж байна. 'Нэг дуулал цээжлэх' гэж оруулбал яаж байна? Чи үүнийг дажгүй хурдан хийж чадна шүү дээ. Өөр юу амархан харагдаж байна?" гэлээ.

Жэфф түр азнав. Нэг л буруу юм шиг санагдахад тэр юу нь буруу болох талаар цаг гарган бодлоо.

Би хоцрох нь байна *хэмээн тэр бодов.* Үүнийг бушуухан шиг дуусгая. Би угаасаа л сайн аав байх тал дээр тийм ч сайн биш. Хммм. *Тэрээр охин руугаа хараад, өөр зүйл мэдэрч байгаагаа анзаарав. Найдвар. Баяр баясал. Энд зөвхөн хийсэн ажлаа жагсаалтан дээрээ чагтлах талаар биш, харин охиных нь өсөлт хөгжлийн тухай яригдаж байлаа. Харин энэ нь түүнтэй харилцаагаа бэхжүүлэх боломж байв. Жэффийн царайд инээмсэглэл тодорлоо.*

Түүнийг "Түр азнаад, энэ талаар бодож үзье. Бүгдээрээ сүүлийн үед хийе, сайжруулъя хэмээн хүлээн авсан өдөөлтөө бичвэл яасан юм бэ?" гэхэд,

Алана "Аан, за. Тэгье" гэв. Рэйчил цаас, харандаанууд авчран, тэд хамтдаа хэдэн минут бодож, бичив.

Рэйчил "За, одоо яах вэ?" гэхэд

Алана яах ёстойг санан, "Бид энэ талаар залбирч, зорилгоо сонгоод, төлөвлөгөө гаргах хэрэгтэй байх. Гэхдээ аав аа, Тэнгэрлэг Эцэг миний ямар зорилго сонгож тавихад үнэхээр санаа тавьдаг гэж та бодож байна уу? хэмээн асуулаа.

Жэфф бодлогошров. "Чамд маш олон сайхан санаа байна. Тиймээс Тэнгэрлэг Эцэг эхлээд нэгийг нь сонгоосой гэж хүсэж байгаа ч юм бил үү? Гэхдээ би нэг юманд огтхон ч эргэлзэхгүй байна. Тэнгэрлэг Эцэг чамд санаа тавьдаг" гэж тэр хэллээ.

Рэйчи "Чамайг бэлгүүдээ ашиглан өөрчлөлт хийхийг хүсэж байгааг би мэдэж байна. Эдгээрийн аль нэг нь бусдаасаа илүү чухал бол Тэнгэрлэг Эцэг чамд үүнийг мэдрэхэд тусална гэдэгт би итгэлтэй байна" хэмээн нэмж хэлэв.

Алана инээмсэглэн, нэг зүйлийг санаж, "Ерөнхийлөгч Нэлсон өсвөр үеийнхнээс амьдралаа сайтар дүгнэж үзэхийг хүссэн. Би яваад, бичсэн зүйлээ аваад ирэх үү?" гэв.

"Тэгэлгүй яахав!" хэмээн Жэфф инээмсэглэснээ, цаг руугаа дахин харлаа. "Өө, би явахгүй бол болохгүй нь. Чи бичсэн зүйлсээ олчих, тэгээд оройн хоолны үеэр ярилцъя, болох уу? Тус болж болох хэдэн асуулт надад байгаа" гэлээ.

"Болж байна" хэмээн Алана инээмсэглээд, "Аав аа? ээж ээ, баярлалаа!" гэв. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ОЛЖ МЭДЭХЭД ТУСТАЙ АСУУЛТУУД

Хүүхэд, өсвөр үеийнхэнд хамгийн их хүсэж байгаа зүйлээ олоход нь туслахын тулд дараах асуултуудыг тэдэнтэй ярилц.

Чи хэнийг хүндэлдэг вэ? Яагаад?

Бусад хүн чамд хэрхэн хандаасай гэж чи хүсдэг вэ? Чи бусдад хэрхэн хандахыг хүсдэг вэ?

Судрууд болон бошиглогчдын сургаал эсвэл патриархын адислал дээрх таны ямар ямар адислал бусад зүйлээс илүү ирээдүйд чухал санагдаж байна вэ?

Таны амьдралд юу илүү их эсвэл арай бага байгаасай гэж чи хүсдэг вэ?

Та хэзээ аз жаргалтай, амьдралдаа илүү идэвхтэй оролцоотой байдаг вэ? Тийм үедээ юу хийж байсан бэ?

Та алдаа гаргахаас айдаггүй байсан бол амьдралдаа юу хийх байсан бэ?

Одоо таныг ямар асуудал зовоож байна вэ?

Их Эзэн таны төлөө эсвэл танаас юу хүсдэг гэж та боддог вэ?

Та энэ жил юуг турших үзэн, суралцъя гэж хүсэж байна вэ? Яагаад?

Таны энэ долоо хоногийн зорилго юу вэ? Тэдгээр нь яагаад Их Эзэнд чухал байж болох вэ?

Биднийг ярилцаж байхад чамайг __________ хүсэж байгаагаа хэлэхийг би сонссон. Зөв үү? Өөр хэлэх зүйл байна уу?

Гэрчлэлийн нөөц

Намайг ахлах сургуулийн 10-р ангид байхад аав, ээж хоёр маань салсан юм. Олон жилийн турш би аавыгаа ариун ёслолоос хүртэхгүй байгааг харж байсан. Тэр зарлигуудыг дагах тал дээр асуудалтай байсныг би мэдэж байсан ч тэдгээр нь ямар ноцтой, хүнд байсныг ойлгодоггүй байв. Сүмийн гишүүнчлэлээс хассан тухай эцэг эхийгээ хэлэх үед л би охин дүүтэйгээ хамт нарийн учрыг нь эцэст нь мэдэж авч билээ.

"Би таныг үзэн ядаж байна!" гэж ахин дахин хэлж, уйлж байснаа би санадаг. Би багтартлаа уурлаж байсан. *Тэр яаж манай гэр бүлд ийм муухай хандаж чадаж байна аа?* гэж би бодож байлаа. *Тэр яаж бидэнд ийм удаан худлаа ярьж чадав аа?*

Анхны цочрол, уур тийм ч удаан үргэлжилсэнгүй. Хоёр долоо хоногийн дотор уур хилэн маань сарниж, би дүйнгэ байдалд орсон юм. Эхэндээ дүйнгэ байдал маань мэдэрч байсан уур хилэн, зовиураас чөлөөлсөн ч эцэстээ сэтгэлийн гутрал болон хувирав. Амьдрал маань нуран унаж байгаа мэт надад санагдсан. Хэзээ хэзээнээс илүү би тэнгэртэй холбоотой байгаагаа мэдрэх хэрэгтэй байлаа. Би Бурханы хайр, удирдамж, амар амгалан болон эдгэрлийг мэдрэх хэрэгтэй байв.

Удалгүй Ерөнхий чуулган болж билээ. Нэг хуралдааны үеэр би Бурханы тайвшралыг мэдрэхээр сонсож, хүлээж байлаа. Гэвч тайвширсангүй. Сүмийн харанхуй өрөөнд байхад *Би Ариун Сүнсийг мэдрэхгүй байна, гэхдээ Түүний энд байгааг мэдэж байна* гэсэн бодол төрж билээ. *Тэр энд байж л таараа.* Ийн бодож байх зуур би судрууд үнэн, Иосеф Смит бол бошиглогч, Тэнгэрлэг Эцэг гэр бүлийг маань адисалсан, зарлигуудыг дагах нь амар амгаланг авчирсан талаар хүлээж авсан олон жижигхэн гэрчээ саналаа. Энэ нь гэрчлэлийн нөөц надад байдаг мэт санагдуулж байв.

Яг тэрхэн мөчид Сүнсийг мэдрэхгүй байсан маань надад огт хамаагүй байв. Гэрчлэлийн далд, тогтвортой нөөц надад аль хэдийн байсан.

Өмнөх сүнслэг гэрчүүдээ эргэцүүлэн бодох тусам, хэдийгээр Сүнсийг мэдрэхийг маш ихээр хүсэж байсан ч яг тэр мөчид Түүний нөлөөг мэдрэх эсэх нь хамаагүй юм байна гэдгийг би ойлгосон. Сайн мэдээ үнэн гэсэн гэрчлэлийн далд, тогтвортой нөөц надад аль хэдийн байсан юм.

Тэр мэдлэг намайг тэтгэж, үр ашгаас нь тэр даруй хүртэхгүй байгаа мэт санагдсан ч зарлигуудыг үргэлжлүүлэн сахих хүслийг надад төрүүлсэн. Яваандаа, би Тэнгэрлэг Эцэгийн болон Аврагчийн хайрыг амьдралдаа илүү ихээр мэдэрсэн юм. Тэдний ойр байгааг үргэлж мэдрэхгүй байсан ч гэлээ, Тэдэнд ойрхон байсан маань надад үгүйсгэхийн аргагүй амар амгаланг мөн Аврагчийн сайн мэдээний талаарх илүү хүчтэй гэрчлэлийг авчирсан билээ. Энэ нь одоо ч гэсэн эргэлзэхэд юм уу зовлон шаналалтай тулгарах үед надад нөлөөлдөг. Тэнгэрлэг Эцэг, Аврагч хоёрт найдаж болно мөн Тэд намайг болон бидний хүн нэг бүрийг эдгээж, өргөн дэмжиж, хүчирхэгжүүлж чадна гэдгийг би мэднэ. ■

Нэрийг нууцлав, АНУ, Юта

ЗУРГИЙГ ФИЛ, I2IART.COM

Тэр ойлгох болов уу?

2005 онд би Милэна, Матэо, Нэлсон хэмээх гурван ихэр хүүхдээ дутуу төрүүлсэн юм. Милэна эрүүл байсан бол хоёр хүү маань янз бүрийн асуудалтай байв. Матэо төрснөөсөө хойш гурван сарын дараа тэрхүү хүндрэлээсээ болж нас барсан.

Матэог нас барснаас хойш нэг сарын дараа Нэлсон дүлий, бас тархи нугасны саажилттай гэж оношлогдов. Бид ч сэтгэлээр унаж билээ. Эмч нар түүнийг хэзээ ч хөлд орохгүй гэж хэлсэн юм. Тэр мөчид Есүс Христийн сайн мэдээний талаарх мэдлэгтээ бид талархаж билээ. Яагаад бид энэ амьдралдаа саад бэрхшээлтэй тулгардгийг ойлгоход энэ нь тусалсан.

Итгэл, шаргуу хөдөлмөрийн үр дүнд Нэлсон хөлд орж, дохионы хэлээр ярьдаг болсон юм. Тэр эмч нарын тооцоолж байснаас хамаагүй сайн болсон. Тэр манай гэр бүл дотор болон сайн мэдээнд аз жаргалтай нэгэн болж өссөн.

Хэдийгээр Нэлсоны хөдөлгөөн хязгаарлагдмал байсан ч бид баптисм хүртэхээс нь өмнө түүнд баптисмын утга учрыг ойлгуулах, 12 нас хүрэхэд нь Аароны санваарт томилох, ариун сүмд нас барагсдын төлөө баптисм хүртээлгэх гэсэн хэд хэдэн зорилгыг түүний өмнө тавьсан юм.

2017 онд Нэлсон 12 нас хүрэв. Бид түүнд нас барагсдын төлөө баптисм хүртэхэд бэлтгэхэд нь туслав. Баптисм хүртэлгүй нас барсан хүмүүст бидний тусламж хэрэгтэй гэдгийг түүнд ойлгуулахад хэцүү байсан. Нэлсоны төрсөн өдрийн дараахан, тэр Милэнатай болон өөрийн ах Франко, эгч Брэнда мөн тойргийн бусад өсвөр үеийнхэнтэй хамт Аргентины Кордоба дахь ариун сүм рүү явав. Ариун сүмийн ерөнхийлөгч тэднийг хүлээн авч, төлөөлөн хийх баптисмын ач холбогдлын талаар ярьж өгсөн юм. Би Нэлсоны хажууд суугаад, түүнд дохионы хэлээр орчуулж өгч байв. Удалгүй, түүний баптисм хүртэх ээлж боллоо. Түүнийг баптисмын усан санд ороход, тэр үнэхээр ойлгосон болов уу? гэж бид бодож байв.

Усанд орох үед Нэлсоны сэтгэл их хөдөлсөн. Яг тэр мөчид тэрээр өөрийн нас барсан өвөг дээдсийн төлөө тэдний хийж чадахгүй зүйлийг хийж байгаагаа үнэхээр ойлгож байгааг нь бид Ариун Сүнсээр дамжуулан мэдэрсэн юм. Хөшигний нөгөө талд байгаа гэр бүлийн гишүүд маань өөрсдөд нь тусалж байгаад түүнд баярлаж байгааг ойлгож байсныг нь бид мэдсэн. Сүнс бас бидэнд Матэог ах, эгч хоёртойгоо хамт тэнд байсныг мэдрүүлсэн билээ. Нэлсон уснаас гарч ирэхдээ маш их аз жаргалтай болсон байв.

Түүнээс хойш Нэлсон гэр бүлийнхээ олон гишүүний өмнөөс, түүний дотор 2016 онд насан өөд болсон аавын маань өмнөөс баптисм хүртэж, гишүүнээр батлуулсан юм. Бид ариун сүмд хайртай. Тэнд үйлчлэх нь манай гэр бүлийн уламжлалуудын нэг болсон. Бид явах бүрдээ тэр онцгой өдрийг эргэж санадаг. ■

Мириам Розана Галэано, Аргентин, Кордоба

Ариун сүмд үйлчлэх нь гэр бүлийн маань уламжлалуудын нэг болсон. Бид явах тоолондоо Нэлсоны онцгой өдрийг эргэн санадаг.

ЗУРГИЙГ АЛЛЭН ГАРНС

“Бүх зүйл бүхнийг мэдэгч Түүний мэргэн ухаанаар”

Би бүрэн цагийн номлогч болж номлогчийг бэлтгэх төвд ороход, сурах зүйл их байгааг олж мэдсэн юм. Би суралцаж, гэрчлэлээ хүчирхэгжүүлэн, одоогийн суурин дээрээ суурилан өсөж хөгжихийн тулд чадах бүхнээ хийсэн. Би залбирч, Тэнгэрлэг Эцэгээс асууж, улмаар хариултыг нь эрэлхийлдэг байв. Энэ дадал хэвшил миний амьдралыг өөрчилсөн юм.

Нэгэн өдөр намайг Перуд номлогчоор үйлчилж байхад хамт үйлчилж байсан нэг ахлагч маань сайн найзынх нь аав зуурдаар нас барсан тухай захиа хүлээн авав. Тэр нулимс дуслуулан, “Тэнгэрлэг Эцэг яагаад ийм зүйл болохыг зөвшөөрч байгаа юм бэ?” гээд уйллаа.

Тэр асуулт миний сэтгэлд их хүнд тусаж билээ. Тэр орой би өвдөг сөгдөн, Тэнгэр дэх Эцэгтээ яг тэр асуултыг тавьсан юм. Тэгээд Мормоны Номоос хариултаа хайж байхад харц минь 2 Нифай 2:24 дээр туссан ба энд “Гэвч болгоогтун, бүх зүйл, бүхнийг мэдэгч түүний мэргэн ухаанд хийгдсэн билээ” гэсэн байв.

Тэр судрын хэсэг зүрхэнд шингэж, сэтгэлээс минь гарсангүй. Би тэр ахлагчид захиа бичиж, гэрчлэлийнхээ хэсэг болгон уг судрыг хуваалцлаа. Тэнгэрлэг Эцэг аливаа зүйлийг мэргэн ухаанаар хийдэг тул бүх зүйл зүгээр болно гэж би түүнд батлан хэлсэн юм. Тэр бидэнд хайртай мөн бүх зүйлийг мэддэг учраас бид Түүнд найдаж болно.

Жил хагас орчмын дараа Перугийн уулаар үйлчилж байхад номлолын ерөнхийлөгч маань над руу гэнэт утасдав. Тэр надад аавыг маань цус харвасныг мөн бие нь хүнд байгааг дуулгав. Удалгүй аав маань нас барсан. Би сэтгэлээр унаж, “Би үүнийг хэрхэн давж гарах билээ?” гэх мэт асуулт санаанаас гарахгүй байв.

Би Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч, хариулт авахыг хүссэн. Хамгийн гол нь баяртай ч гэж хэлэх боломж олголгүйгээр яагаад аавыг маань энэ дэлхийгээс авсныг мэдэхийг би хүсэж байв. Би Мормоны Номоо авч нээгээд, хэдэн сарын өмнө нөгөө ахлагчтай хуваалцсан яг тэр үгсийг уншлаа. “Гэвч болгоогтун, бүх зүйл, бүхнийг мэдэгч түүний мэргэн ухаанд хийгдсэн билээ.” Тэр үгсийг уншихад намайг хөнжлөөр хучих мэт амар амгалан нөмрөн авч, төөрөлдсөн үед минь ач ивээлээ мэдрүүлсэн юм.

Дэлхий дээр аав маань байхгүй болсон ч Тэнгэрлэг Эцэг минь үргэлж миний дэргэд байх болно. Тэнгэрлэг Эцэг бүх зүйлийг мэргэн ухаанд хийдэг бөгөөд бид эрэлхийлж, өөрсдийгөө бэлтгэхийн тулд чадах бүхнээ хийвэл үнэ цэнтэй хариултаа олох болно. ■

Кристофэр Дийвэр, АНУ, Калифорни

Перугийн уулаар үйлчилж байхад номлолын ерөнхийлөгч маань гэнэт утасдав.

ЗУРГИЙГ КРИСТОФЭР ВОРМЭЛЛ

Ариун сүмд үйлчлэхээр дуудагдсан явдал маань намайг зөв цагт зөв газартаа байгааг баталж өгсөн.

Гайхамшигт, шинэ хуудас

Би 2010 оны 10-р сард бэлэвсрэхдээ амьдралынхаа нэгэн хуудсыг хааж билээ. Тэр үед би өмнөд Францад сургагч багшаар ажиллаж байв. Ажил дээр гарсан ослоос болж миний хөдлөх чадвар хязгаарлагдаж, эрүүл мэнд, тамир тэнхээгээ хурдан сэлбэж чадахгүй байгаадаа би гутарч байлаа. Би 11 жилийн турш ажил мэргэжилдээ сэтгэл хангалуун байсан. Би ажилдаа дуртай байсан. Мөн олон ч найзтай байлаа. Гэвч би ажлынхаа шаардлагыг хангаж чадахааргүй болсон юм.

33 гаруй жилийн турш би мэргэн ухааны үгийг сахичхаад, яагаад "гүйж мөн ядрахгүй" байж чадахгүй байгаа юм бол гэсэн бодол надад төрж байсныг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй байх (Сургаал ба Гэрээ 89:20-ийг үзнэ үү). Эцэст нь би тооцоолж байснаасаа өмнө тэтгэвэртээ гарах болж, амьдралынхаа бас нэгэн хуудсыг хааж билээ.

Би тэр үед охинтойгоо амьдарч байсан бөгөөд охин минь ажлын шаардлагаар Парис хавьд шилжих боллоо гэсэн мэдэгдлийг хүлээж авав. Би охинтойгоо хамт нүүж, шинэ газарт амьдралынхаа шинэ хуудсыг нээхээр шийдсэн.

Тэнд очсоны дараахан бид хоёрыг хоёуланг Францын Парис ариун сүмд ажиллуулахаар дуудав. Ариун сүмд үйлчлэхээр дуудагдсан явдал Их Эзэн намайг энд авчирсан учраас зөв цагт зөв газар байгааг надад баталж өгсөн билээ. Би Их Эзэний өргөөнд тогтмол үйлчилснээр асар их баяр хөөрийг олж авсан бөгөөд ариун сүмд охинтойгоо гайхалтай сайхан цаг мөчийг хуваалцахад үнэхээр сайхан байдаг. Энэ нь зүрх сэтгэлийг маань баяр хөөрөөр дүүргэдэг!

Өнөөдөр би зовлон зүдгүүрийн маань ард нуугдсан байсан агуу адислалуудыг эхлэж олж хардаг. Хөдөлгөөн хязгаарлагдаж, мэргэжлээрээ ажиллаж чадахаа больж, тэтгэвэрт эрт гарахад надад хэцүү байсан. Гэхдээ Их Эзэн Есүс Христ намайг нуруун дээрээ үүрээд явж байсныг би мэднэ. Тэр намайг удаашруулж мөн амьдралынхаа томоохон хэсэг болсон амралт, найдвар, амар амгаланг олоход минь тусалсан.

Би ариун сүмийн хаалгаар орох бүрдээ Ариун Сүнсийг мэдэрдэг. Дэлхийн дарамтан доор байгаа энэ хүнд хэцүү үед Их Эзэн бидэнд бүх юм нь эмх цэгцтэй, бас үзэсгэлэнтэй ариун газруудыг өгсөн гэдгийг мэдэх гайхамшигтай. Ариун сүмд үйлчлэх амьдралынхаа энэ шинэ хуудсыг нээсэндээ би маш их талархдаг. Үнэхээр гайхамшигтай! ■

Силви Корнэ, Франц, Эль-дэ-Франц

ЗУРГИЙГ КЭРОЛИН ВИББЭРТ

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ДАН БӨРР

Мэддэг байх нь сайхан ч энэ нь хангалтгүй

Мормоны Номын гэрчүүдийн гэрчлэлийг сонссон Сүмийн эхэн үеийн гишүүдийн зарим түүхийг өгүүлэв.

Стивэн С.Харпэр
Бригам Янгийн Их Сургуулийн Сүмийн түүх болон сургаалын профессор

Мормоны Номын гэрчийн гэрчлэлийг сонсох нь алтан ялтаснууд юм уу тэнгэр элчүүдийг олж харахын дараа орох гайхалтай зүйл байж болох юм. Сүмийн эхэн үеийн олон гишүүнд ийм боломж байсан.

Мормоны Номын гэрчүүдтэй ярилцаж байсан хэдэн гишүүний түүхийг оруулав. Гэхдээ ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоны зааснаар, Мормоны Номын талаар гэрчлэлтэй болох нь “сайхан ч, хангалтгүй!”[1] гэдгийг олж харах болно.

Рэбэка Виллиамс: “Тэдний үгс итгэл төрүүлж байв”

Рэбэка Виллиамс 1830 оны эхэн үеэс эхлэн Огайод Мормоны Номын хэд хэдэн гэрчийн ярихыг сонсжээ. Тэр аав, ах дүү нартаа “Би [Смитийн] гэр бүлийн хэдэн гишүүнээс мөн гурван гэрчээс яг адилхан түүхийг сонссон. Тэд тэнгэрээс Ариун Тэнгэр элч бууж ирэн, ялтаснуудыг авчирч, тэдний нүдний өмнө авчирсныг харсан тухайгаа нийтийн цуглаан дээр зарлахыг нь би сонссон” хэмээн гэрчлэлээ хуваалцжээ.

Гэр бүлийн гишүүд нь түүний гэрчлэлийг эсэргүүцэхэд Рэбэка няцсангүй. Тэр үргэлжлүүлэн тэднийг хайрлаж, тэднийхээ төлөө залбирч байсан ба эцгийнхээ сайн зөвлөгөөг сонсохоо болиогүй юм. Тэр бас аавдаа Мормоны Номын гэрчүүд үнэнийг хэлсэн талаар гэрчилсээр байв. “Тэд зан чанарын хувьд сайн хүмүүс бөгөөд тэдний үгс итгэл төрүүлж байсан. . . . Тэд Бурханы тэнгэр элчийг харсан бөгөөд түүнтэй ярилцсан”[2] гэж тэр гэрчилж байв.

1830-аад оны сүүлээр, Сүм даяар хагарал газар авах үед Рэбэка үнэнч хэвээр үлдэж, Мормоны Номын үгсийг дагахаар сонгосон юм.[3]

Виллиам Маклеллин: “Үнэний мэдлэгт . . . хүлэгдсэн”

1831 оны нэгэн өглөө сургуулийн залуухан багш Виллиам Маклеллин Миссури руу явах замдаа, хэдэн хүн “Бурханаас ирсэн илчлэлт” хэмээх нэгэн шинэ номын тухай номлох гэж байгааг сонсжээ. Тэр тэднийг сонсохоор яаран очив. Тэр Давид Витмерийг “энэхүү цэдгийг үнэн гэдгийг өөрт нь гэрчилсэн Ариун Тэнгэр элчийг харсан” хэмээн гэрчлэхийг сонсжээ. Тэдний гэрчлэл үнэн

эсэхийг мэдэхийг тэрээр сэтгэлийнхээ гүнээс хүсэж байв. Тэр тэднийг Миссурийн Индепенденс рүү 644 км дагасан бөгөөд тэнд Мартин Харрис, Хайрум Смит зэрэг өөр бусад гэрчтэй уулзаж, ярилцсан байна.[4]

Виллиам Хайрумтай олон цагийн турш ярилцжээ. Виллиам: "Би уг цэдэг хэрхэн гарч ирсэн талаар нарийвчлан асуув. Маргааш өглөө нь үнэн рүү хөтлөхийг хүсэн залбирсныхаа дараа "шударга хүний хувьд тэр Мормоны Номын үнэн болон бодит байдлыг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй"[5] болсноо ойлгосон байна.

Дараагийн он жилүүдэд Виллиамын итгэл өөрийнх нь хийсэн сонголт, хожмын үеийн гэгээнтнүүдийн туулсан хавчлагаар соригдож, хүчирхэгжсэн юм. Миссури мужийн Жаксон гүнлэгт байсан гэгээнтнүүд рүү довтлох үед Виллиамын найз, Найман гэрчийн нэг болох Хайрам Пейжийг хэсэг эр зодож, ташуурдан, хэрвээ Мормоны Номыг үгүйсгэх юм бол чөлөөлж явуулна гэжээ. "Би үнэн гэж мэддэг зүйлээ хэрхэн үгүйсгэх билээ?" гэж Хайрамыг хэлэхэд тэд түүнийг ахин зоджээ.

Виллиам зодуулахаас айж байсан ч Хайрамын гэрчлэл түүнийг хүчирхэгжүүлэв. Ойр хавийнх нь эрчүүд Оливер Каудери тэр хоёрыг барьж өгсөн хүнд шагнал өгнө гэж ярьж байсныг сонсоод, тэд хотоос гарч, Давид Витмертэй хамт ойд нуугдсан байна. Тэнд Виллиам гурван гэрчийн хоёроос нь ярилцлага авчээ. Тэрээр "би амьдралдаа хэзээ ч үзэгдэл үзэж байгаагүй" ч та нар үзсэн гэж байгаа тул баттай мэднэ. Одоо дээрэмчид биднийг барих юм бол амь нас маань аюулд орно гэдгийг та хоёр мэдэж байгаа. Бурханы нэрээр андгайлж, Мормоны Ном үнэн эсэхийг хэлж өгөөч?" гэжээ.

Оливер "Виллиам ах аа, Бурхан өөрийн ариун тэнгэр элчийг илгээн, энэ номын орчуулга үнэн гэдгийг тунхагласан тул бид мэднэ. Мөн дээрэмчид биднийг алах байсан ч бид энэ үнэнийг тунхагласаар үхнэ" гэж хэлжээ.

Давид цааш нь, "Оливер чамд баттай үнэнийг хэлсэн, учир нь биднийг хуурч чадахгүй. Би энэ нь үнэн болохыг чамд чин сэтгэлээсээ тунхаглаж байна!"[6] гэжээ.

Давид, Мартин, Хайрам, Оливер, Виллиам нар бүгд өөрсдөө Иосеф Смит Мормоны Номыг Бурханы хүчээр орчуулсан гэдгийг олж мэдсэн байв. Алтан ялтаснууд дээр бичигдсэн сайн мэдээ үнэн гэдгийг тэд мэдэж байлаа. Гэхдээ хожим нь тэд Иосефт уурлан, Мормоны Номын сургаалын дагуу амьдрахаа больсон байна.

Тэдний сонголтыг хараад, бошиглогч Иосеф Смит Мормоны Ном үнэн төдийгүй "энэ дэлхий дээрх бусад бүх номоос хамгийн зөв нь, мөн манай шашны тулгуурын чулуу" бөгөөд бид "бусад ямар ч номоос илүүтэйгээр, түүний зааврыг мөрдсөнөөр л Бурханд илүү ойртох болой"[7] хэмээн гэрчилжээ.

Салли Паркэр: "Итгэлдээ хүчтэй"

Салли Паркэр Огайо мужийн Көртланддад, Люси Мак Смитийн хөрш байв. Салли: "Тэр надад уг түүхийг бүтнээр нь ярьсан. Тэр Люсигээс ялтаснуудыг харсан эсэхийг асуухад "[Люси] үгүй ээ, энэ нь түүний харах ёстой зүйл биш байсан ч тэр гартаа барьж, өргөж, байснаа хэлсэн бөгөөд би түүний хэлсэн бүхэнд итгэсэн. Учир нь би түүний дэргэд 8 сар амьдарсан бөгөөд тэр бол хамгийн сайн эмэгтэйчүүдийн нэг байсан" гэж бичжээ.

1838 онд Салли Хайрум Смитийн гэрчлэхийг сонссон талаараа "Тэр өөрийн нүдээр уг ялтаснуудыг харж, өөрийн гараар хүрсэн гэж хэлсэн"[8] хэмээн бичсэн байна.

1830-аад оны сүүлээр олон хүн Сүмийг орхих үед Салли Паркэр тэднийг Сүмээс гарч байгаад нь гашуудаж, Мормоны Номын зарчмуудын дагуу амьдрахаар бат шийджээ. Салли ийн бичсэн байдаг.

"Гичийн үрийн адил тэрхүү итгэлээс би чанга зууран барихыг хүсэж байна. Би одоо зүрх сэтгэлдээ үүний хүчийг мэдэрч байна. Миний итгэл баптисм хүртэх үед байсан шигээ хүчтэй байгаа бөгөөд оюун ухаан маань ч өөрчлөгдөөгүй. Би үхэх хүртлээ сайн мэдээнээс зууран барих болно."[9]

Рода Грийн: “Түүнд Бурханы Сүнс байв”

1845 онд Мормоны Номыг гэрчлэгч, гэр бүлийнх нь бүх гэрч алуулсан, өвчнөөр нас барсны дараа Люси Мак Смит Ерөнхий чуулган дээр үг хэлжээ. Тэр хүү Самуелын анхны номлолын нэгэн түүхийг ярив.

Найман гэрчийн нэг байсан Самуел нөхөр нь өөр сүмийн номлолд үйлчилж байсан Рода Грийн гэгчийн гэрт айлчилжээ. Самуел Родагаас ном авах уу гэж асуусан байв. Тэрээр “Энэ бол миний ах Иосефын газраас гаргаж авсан ялтаснуудаас орчуулсан ном” гэж тайлбарлажээ.

Рода уг номын нэг хувийг өөрөө уншина, бас нөхөртөө үзүүлнэ гэж авч үлдэв. Дараа нь Самуелыг эргэж ирэхэд, нөхрийнхөө сонирхохгүй байгааг мөн уг номыг худалдаж авахгүй гэдгээ Рода хэлжээ. Сэтгэлээр унасан Самуел номоо аваад, явах гэлээ. Хожим нь Рода Люсид Самуел хэсэг зогтуссанаа түүн рүү харсан талаар ярьсан байна. Люси Ерөнхий чуулган дээр хэлсэн үгэндээ “Рода руу ямар ч хүн тийм харцаар харж байсангүй. Түүнд Бурханы Сүнс байгааг тэр мэдэж байлаа” гэв.

Самуел Родад хандан “Сүнс намайг энэ номыг буцааж авахыг хориглож байна” гэхэд Рода Самуелыг өвдөг сөгдөн, хамт залбирахыг гуйжээ. Тэр номыг авч үлдээд, улмаар уншиж, гэрчлэлтэй болжээ. Яваандаа, нөхөр нь ч гэрчлэлтэй болсон юм. Тэд амьдралынхаа турш энэ номын зарчмын дагуу амьдрах сонголтыг хийсэн.

“Мөн ажил ийн эхэлсэн бөгөөд гичийн үр мэт тархсан билээ” хэмээн Люси гэрчилжээ.[10]

Рода Грийн бол миний эмэг эх. Мормоны Номын талаарх түүний гэрчлэлийг болон гэрчүүдийн ярихыг сонссон хүмүүсийн тухай бичиж үлдээсэн тэдний гэрчлэл намайг гэгээрүүлдэг. Мормоны Номд заадаг зүйлсийг дагах сонголт хийсэн маань намайг хүчирхэгжүүлдэг.

Ариун Сүнс бидэнд уг номын үнэнийг батлах үед бидний хүн нэг бүр Мормоны Номын орчин үеийн гэрч байж чадна. Номлолд явахаас өмнөхөн би Мормоны Номыг уншиж дуусгасныхаа дараа чин хүсэлтэйгээр, үнэн сэтгэлээсээ мөн Есүс Христэд итгэх итгэлтэйгээр өвдөг сөгдөн, энгийн залбирал үйлдэв (Моронай 10:3–4-ийг үзнэ үү). “Чи үнэнийг аль хэдийн мэднэ” гэсэн хүчтэй мэдрэмж төрөхийг би мэдэрсэн. Энэ нь надад хэзээ ч үгүйсгэж зүрхлэхгүй амар амгаланг даган ирсэн юм. Тэр үеэс хойш би Мормоны Ном үнэн гэдгийг мэддэг болсон.

Гэхдээ мэдэх нь хангалтгүй. Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон “Би ‘Мормоны Ном үнэн’ хэмээн бусдын бас өөрийн хэлэхийг сонсох бүрдээ ‘Сайхан хэрэг байна. Гэхдээ хангалтгүй’ гэж дуу алдмаар санагддаг. Бид Мормоны Ном *бол* Бурханы үг эргэлзээгүй мөн гэдгийг зүрхнийхээ ‘угаас’ гүн гүнзгий мэдрэх хэрэгтэй. Бид үүнгүйгээр нэг ч өдөр амьдрахыг хүсэхгүй болтлоо тийм гүн гүнзгий мэдрэх ёстой”[11] хэмээн заасан. Ерөнхийлөгч Нэлсоны заасан зүйлс үнэн. Мормоны Номын сургаалын дагуу амьдрахын тулд байнга хичээл зүтгэл гаргаж байсан маань юу юунаас ч илүү намайг Бурханд ойртуулсан. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Рассэлл М.Нэлсон, “Мормоны Ном: Үүнгүйгээр таны амьдрал ямар байх байсан бэ?” *2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган,*, 58.
2. Rebecca Swain Williams to Isaac Swain, Youngstown, New York, June 12, 1834, зөв бичгийн дүрмээр стандарчилсан. Janiece Johnson, “Give Up All and Follow Your Lord,” *BYU Studies,* vol. 41, no. 1 (2002), 97–102 дээрх бичвэр, захидлуудын зургийг үзнэ үү.
3. Мөн Janiece Lyn Johnson, “Rebecca Swain Williams: Steadfast and Immovable,” *Ensign,* Apr. 2011, 38–41-ийг үзнэ үү.
4. *The Journals of William E. McLellin: 1831–1836,* ed. Jan Shipps and John W. Welch, (1994), 29–33-ыг үзнэ үү.
5. *The Journals of William E. McLellin,* 33, том үсгийг стандарчлав.
6. *William E. McLellin's Lost Manuscript,* ed. Mitchell K. Schaefer (2012), 165–67.
7. Иосеф Смит, Мормоны Номын оршил. Энэ сургаалын нарийвчилсан судлгаар харах бол Scott C. Esplin, “Getting ‘Nearer to God’: A History of Joseph Smith's Statement,” in *Living the Book of Mormon: Abiding by Its Precepts,* ed. Gaye Strathearn and Charles Swift (2007), 40–54-ийг үзнэ үү.
8. Janiece L. Johnson, “‘The Scriptures Is a Fulfilling’: Sally Parker's Weave,” *BYU Studies,* vol. 44, no. 2 (2005), 116, 115.
9. Johnson, “‘The Scriptures Is a Fulfilling,’” 117.
10. Lucy Mack Smith, “This Gospel of Glad Tidings to All People,” in Jennifer Reeder and Kate Holbrook, eds., *At the Pulpit: 185 Years of Discourses by Latter-day Saint Women* (2017), 24.
11. Рассэлл М.Нэлсон, “Мормоны Ном: Үүнгүйгээр таны амьдрал ямар байх байсан бэ?,” 58.

Ирээд, Намайг дага:
МОРМОНЫ НОМ

12-Р САРЫН 30-ААС 1-Р САРЫН 5

Оршил хуудаснууд

Өөр өөр төмөр ялтсан ном дээр өөр өөрсдийн үгийг цэдэглэсэн эртний бошиглогчид Мормоны Номыг бичсэн. Тэрхүү цэдгүүдийг Иосеф Смитийн орчуулсан, Мормоны буюу алтан ялтаснуудыг бүтээхийн тулд хожим нь эмхэтгэжээ.

Ярилцлага

Алтан ялтаснууд дээр цэдэглэгдэж болох байсан зүйлстэй харьцуулбал, Мормон болон бусад бошиглогч Мормоны Номд зориулан зөвхөн багахан хэсгийг сүнсний удирдамжийн дагуу сонгожээ (Мормоны үгс 1:5 болон 3 Нифай 26:6). Үүнийг мэдэх нь өнөөгийн бидэнд байгаа бүлгүүдийн талаарх таны бодолд хэрхэн нөлөөлөх вэ? ■

Мормоны Номыг аль ялтаснуудыг нийлүүлж бүтээсэн бэ?



* Онууд нь ялтас бүрийн хамарсан ойролцоо цаг хугацаагаар зааж байгаа.

ИОСЕФ СМИТИЙН БОЛОН ТЭНГЭР ЭЛЧ МОРОНАЙН ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БРАЙАН БИЙЧ

1 дэх долоо хоног

1-Р САРЫН 6–12

1 Нифай 1–7

Лихайн амьдарч байсан цаг үед Иерусалим ямархуу байсан бэ?

Иудейн хаант улсын нийслэл нь улс төрийн хуйвалдаан, ёсон бусаар дүүрэн байсан. Ялангуяа сүүлийн арван жилийн турш үймээн самуун ихтэй байжээ. Иудейн хаад алагдсан эсвэл баригдсан; еврейчүүд Вавилон руу дайрсан; Иеремиа зэрэг бошиглогчдыг сүрдүүлэн мөн шоронд хорьсон. Их Эзэн Лихайд зугт хэмээн хэлсэнд гайхах зүйлгүй (1 Нифай 2:1–2-ыг үзнэ үү).

- ХҮН АМЫН ТОО: **25000** (эртний жишгээр бол олонд тооцогдоно)
- ГАЗАР НУТАГ: цөл, үржил шимт хөндий, налуу толгод
- МӨНГӨНИЙ НЭГЖ: **мөнгийг жингээр тооцдог.** (мөнгө, зэс, алт; зоос байгаагүй)
- ХЭЛ: **еврей**
- АЖИЛЛАХ ХҮЧИН: дархан, худалдаачин, боолууд (гэр бүлийн гишүүн гэж үздэг байсан); **түүнчлэн ихэнх нь хөдөө аж ахуй эрхэлдэг байжээ**
- ХООЛ ХҮНС: жимс, талх, чидун, инжир, шөл
- ХУВЦАС: **ширүүн ноос, углааш;** пристүүд цагаан нөмрөг өмсдөг байв

- ШАШИН: **бусармаг, хиймэл шүтээн шүтэгч;** хуурамч бошиглогчид амар амгаланг тунхаглаж, хуцны эвэр үлээж, өдөр тутмын залбирлыг зарладаг байжээ.
- НИЙГМИЙН БҮТЭЦ: **эцгийн эрхт,** тухайлбал хотын *ахлагчид*, гэр бүлийн *ахмадууд* болон *онцгой сайн* буюу “сайн гаралтай хүмүүс” бүгд эрэгтэй хүн байв.
- ГЭР БҮЛҮҮД: гэр бүлүүд **талбайг тойрсон олон өрх гэрээс** бүрддэг байсан бөгөөд эцэг нь удирддаг байжээ. Гэр бүлд хөвгүүдийнх нь гэр бүл, гэрлээгүй охид, авга эгч, нас өндөр хамаатнууд нь багтдаг байв.
- ЦЭРГИЙН ХҮЧ: **тэр үед байгаагүй.** Цэргүүд нь вавилончууд байсан бөгөөд Иуда тэдэнд татвар гувчуур төлдөг байжээ. ■

ИЕРУСАЛИМЫН БОЛОН ХУРГА, ЖИМСНИЙ ЗУРГИЙГ GETTY IMAGES-ЭЭС АВАВ

2 ДАХЬ ДОЛОО ХОНОГ

1-Р САРЫН 13–19

1 Нифай 8–10

Лихайн үзэгдэл дэх жимс юуг бэлгэддэг вэ?

Лихайн үзэгдэл дэх "бүхнээс илүү, хамгийн ихээр хүслийг татагч" жимс юуг бэлгэддэг вэ? (1 Нифай 11:22).

"Уг модны жимс нь [Есүс Христийн] Цагаатгалын адислалуудын бэлгэдэл юм. Амьдралын модны жимснээс хүртэх нь бидний амьдралд Цагаатгал үр өгөөжөө бүрэн өгөхийн бэлгэдэл болох ёслолууд, гэрээнүүдийг хүлээн авахыг төлөөлдөг" (Дэвид А.Бэднар, "Лихайн зүүд: Төмөр бариулаас зууран барь," *Лиахона,* 2011 оны 10-р сар, 34).

Эдгээр ёслолд баптисм, гишүүний баталгаа, ариун сүмийн ёслолууд, эрэгтэйчүүдийн хувьд санваарын томилгоо орно.

Жимсийг олох

Төмөр бариул буюу Бурханы үг нь Есүс Христ рүү хөтөлдөг. Учир нь судрууд болон орчин үеийн бошиглогчид ёслол, гэрээнүүдэд оролцоход биднийг урьж, Есүс Христийн сургаал, зорилго, золиосыг ойлгоход тусалдаг юм.

- Судрын эсвэл өнөө үеийн бошиглогчдын ямар үгс таныг Есүс Христ рүү хөтөлсөн бэ?

Жимстэйгээ үлдэх

Лихайн үзэгдэл дээрх зарим хүн бусдын доог тохуу, доромжлолоос болж жимсээ орхин явдаг. Жимстэйгээ үлдэхийн тулд гэрээнүүддээ үнэнч байж, гэрээ байгуулсан газартаа ойр ойрхон очих хэрэгтэй.

Жимснээс хуваалцах

Лихай жимснээс хүртсэнийхээ дараа, гэр бүлийнхэндээ өөрийн мэдэрсэн "үлэмж агуу баярыг" мэдрүүлэхийн тулд жимсээ тэдэнтэй хуваалцахыг хүссэн (1 Нифай 8:12).

- Та хэрхэн Есүс Христийг хайрлах хайраа хуваалцаж, бусдад ёслолуудад оролцоход нь тусалж болох вэ? ■

АМЬДРАЛЫН МОД, МАРКУС ВИНСЭНТ, СҮМИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ
АМЬДРАЛЫН МОД, КАЗУТО УОТА, © 2015 BY INTELLECTUAL RESERVE, INC. БҮХ ЭРХ ХАМГААЛАГДСАН.

3
ДАХЬ ДОЛОО ХОНОГ

1 Нифай 11–15

Ямар тодорхой хийгээд эрхэм үнэнүүд Мормоны Номоор дамжин сэргээгдсэн бэ?

Нифай Библийн олон сургаал он жил өнгөрөхөд өөрчлөгдөх боловч Бурхан тэдгээр үнэнийг сэргээх арга замыг бэлтгэх болно гэдгийг үзэгдлээр харав (1 Нифай 13:26–40-ийг үзнэ үү).

1 Адам, Ева хоёрын уналт Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний нэг хэсэг байсан (2 Нифай 2:22–25-ыг үзнэ үү).

2 Бид энэ амьдралаас өмнө сүнсэн хэлбэрээр оршиж, мөнх бус амьдралын талаар сурч мэдэн, бэлтгэгдэж байсан (Алма 13:3-ыг үзнэ үү).

3 Христ эртний Америк тив дэх хүмүүс дээр айлчлан очиж, Өөрийн Сүмийг тэнд байгуулсан (3 Нифай 11–26-г үзнэ үү).



4 Нялх хүүхдүүд хариуцлага хүлээх хараахан болоогүй байгаа тул баптисм хүртэх шаардлагагүй (Моронай 8:10-ыг үзнэ үү). ■

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БРАЙН БИЙЧ

4 дэх долоо хоног

Залуучуудад зориулав

Энэ хэсэгт

44 **Байсан газар маань биш, очих газар маань чухал**
Ричард Монсон

Зөвхөн цахим хувилбараар

Мөнх байдлыг сонгох нь
Эвита Алабоди

Наманчлалыг яаруулж болохгүй
Лиа Бартон

Төлөвлөөгүй жирэмслэлтийн дараа зам дээрээ эргэн гарсан нь
Жори Рийд

Эдгээр болон өөр бусад нийтлэлийг доорх эх сурвалжаас олно уу. Үүнд:

- **liahona.ChurchofJesusChrist.org**
- **YA Weekly** (Gospel Library аппликэйшн дээрх “the Young Adults” хэсэгт буй)
- **facebook.com/liahona**

Түүхээ хуваалц

Танд хуваалцах гайхалтай сайхан түүх байна уу? Эсвэл та аль нэгэн сэдвээр бичсэн нийтлэл уншмаар байна уу? Хэрэв тийм бол бид таны үгийг сонсохыг хүсэж байна! Та өөрийн нийтлэл болон санал, сэтгэгдлийг **liahona.ChurchofJesusChrist.org** руу илгээнэ үү.

Наманчлал бол бэлэг

Заримдаа залуучууд наманчлал бол аймшигт зүйл гэдэгт шууд итгэдэг гэж би боддог. Хайрлаж халамжилдаг хүмүүсийнхээ эсвэл Тэнгэрлэг Эцэгийнхээ хайр халамжийг алдана гэдгээс айж байвал хийсэн зүйлээ хэлэхэд аймшигтай байх нь гарцаагүй. Наманчлалын тухай ийм бодолтой байвал дараагийн түвшин рүү ахиж дэвшин орохын тулд шалгалтад тэнцэхүйц “яг таарсан” хэмжээнд гэм нүглээ хүлээх уруу таталтад орж магадгүй. Гэвч туршлагаас харахад, энэ нь **жинхэнэ наманчлал** биш гэдгийг би мэдсэн. Наманчлахад үргэлж таатай байдаггүй ч **Их Эзэн бидэнд ямар их хайртай, туслахыг ямар их хүсдэгийг** ойлгох юм бол мөн Түүний биднийг цэвэр ариун болгох чадварт итгэх итгэлээ хөгжүүлэх юм бол айдас арилан алга болдог. Би наманчлалаар дамжуулан Христэд итгэх итгэлээ хөгжүүлснээр **өмнөх алдаанууд маань бидний одоо эсвэл ирээдүйг тодорхойлох шаардлагагүй** гэдгийг ойлгож мэдсэн (44-р хуудсанд байгаа нийтлэлээс илүү дэлгэрэнгүй уншаарай).

Зөвхөн цахим хувилбараар гарах нийтлэлүүдэд, **жинхэнэ наманчлал бидэнд Аврагчид мөн Түүний Цагаатгалд талархах талархлыг авчирдаг** бөгөөд ирээдүйд уруу таталтыг эсэргүүцэх хүч чадлыг өгдөг болохыг Эвита онцолсон. Бид ням гарагт болдог ариун ёслолыг хүлээх шаардлагагүй бөгөөд өдөр бүр наманчлалаар дамжуулан Их Эзэнд хандах нь биднийг Түүнээс холдуулдаг өчүүхэн дадал зуршлаа хүртэл эвдэх хүчийг бидэнд өгдөг хэмээн Лиа нэмж хэлэв. Хэрэв бид ноцтой алдаа гаргавал, наманчлал нь бидний хүн нэг бүрийг гэх **Аврагчийн хайрын талаар бидэнд заах болно** гэдгийг Жори хуваалцсан.

Наманчлал бол амьдралдаа байгаа зүйлд талархдаг бэлэг юм. Бурхан биднийг хүн гэдгийг мөн заримдаа тэнэг сонголт хийдгийг мэддэг. Хэдийгээр бид төгс биш ч гэлээ, бидэнд **найдвар бий**. Хэрэв бид Аврагчид итгэж найдвал Тэрээр Тэнгэрлэг Эцэг рүүгээ эргэн очих зам дээр хэчнээн их хугацаа шаардагдсан ч бидэнтэй хамт алхах болно.

Сайн сайхныг хүсье,
Ричард Монсон

© GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

Байсан газар маань биш, **очих газар маань чухал**

Ричард Монсон

Амьдрал минь бодож байснаар минь болсонгүй.

18 насандаа би бүрэн цагийн номлолд үйлчилнэ, дараа нь удалгүй гэрлэж, 25-тайдаа хүүхэдтэй болно гэж боддог байв. Одоо би 32 настай. Би номлолд үйлчлээгүй бөгөөд насанд хүрснээсээ хойших ихэнх цаг хугацаанд Сүмд идэвхгүй байсан. Би гэрлээд, салаад, дахин гэрлэсэн.

Би шулуун бөгөөд нарийн замаас гажиж, өөр замаар олон удаа явсан учраас өөрийгөө сүмд тохирохгүй гэж боддог байв. Гэвч тэнд намайг багтаах орон зай байгааг би ойлгосон. Аврагч болон Түүний Цагаатгалын хүч бодит бөгөөд байсан газар маань биш, харин очих газар маань илүү чухал гэдгийг миний туршлага надад ухааруулсан юм.

Миний гэрчлэл номлолд явахуйц хүчирхэг гэдэгт би итгэлгүй байсан тул эхэндээ итгэдэг зүйлсийнхээ талаар эргэлздэг байлаа. Ахлах сургуулиа төгсөх үедээ би *"Гэрчлэл маань яг минийх биш байвал яана? Би бусад хүний гэрчлэлд хэтэрхий тулгуурлаж байгаа бол яах вэ?" гэх мэт боддог байснаа санаж байна.*

Тэр асуудал намайг зовоодог байлаа. Би номлолд явахыг хүсэж байсан хэрнээ тухайн үед надад тохиолдсон сүнслэг туршлагууд намайг миний бодож байсан шиг амжилттай буюу сүнслэг байдлын хувьд хангалттай хүчтэй, бусдад зааж чадахуйц хэмжээнд сайн мэдээг мэддэг номлогч болгож чадах болов уу гэж боддог байв.

Эргээд харахад, би Сургаал ба Гэрээ 124:97 дээрх "Тэрээр

Би шулуун бөгөөд нарийн замаас гажиж, өөр замаар олон удаа явсан бөгөөд эцэст нь Аврагч болон Түүний Цагаатгалын хүч бодит болохыг мэдсэн юм.

Би өөрийн **сүнслэг байдлыг** бусдынхтай харьцуулсаар төөрч будилсан.

миний өмнө даруу байг, мөн заль мэхгүй байг, мөн тэрээр миний Сүнсийг, бүр мөн бүх зүйлийн үнэнийг түүнд үзүүлэх мөн юу хэлэхийг нь яг цагт нь түүнд өгөх Тайтгаруулагчийг тэрээр хүлээн авах болно" гэсэн зөвлөгөөг ойлгоход туслахыг Бурханаас гуйх хэрэгтэй байсан юм.

Гэвч би Бурханаас асуухын оронд өөрийн сүнслэг байдлыг бусдынхтай харьцуулсаар, хангалтгүй байдал маань хүмүүст сайн мэдээг хүлээн авахад саад болох вий хэмээн эмээх болсон.

Би залуу хүний хувьд тусдаа гарч, юунд итгэдгээ олж мэдэх эрлээ зогсоогоогүй. Хувь хүний хувьд хэн болохыг минь тодорхойлохгүй гэж бодож гаргасан шийдвэрүүдийн хор хөнөөлийг би харахгүй байсан. Миний хийж буй сонголтуудад сэтгэл нь гонсойно гэж бодсон учраас би хайртай хүмүүсээсээ хөндийрч эхэллээ. Оронд нь би миний хийж буй зүйл ямар байх нь огтхон ч хамаагүй хүмүүсээр өөрийгөө хүрээлүүлсэн юм. Нэг өдөр би сониуч зандаа хөтлөгдөн согтууруулах ундаа хэрэглэж үзэв. Архи уух нь миний амьдралын нэг хэсэг болж, яваандаа цагийг зугаатай өнгөрүүлэхдээ хэрэглэдэг биш, харин хүнд хэцүү явдлаа дарахын тулд ашигладаг зүйл болж хувирав.

Тухайн үед амьдралд минь гарсан сөрөг өөрчлөлтүүд ганц сонголтоос болоогүй. Тэдгээр нь аажим аажмаар явагдсан юм. Олон жилийн туршид хийсэн жижиг сонголтууд маань намайг байхыг хүсээгүй газарт маань аваачсаныг ойлгоход би хоёр жилийг зарцуулсан.

Энэ нь сайн мэдээ үнэн гэдгийг мэдэхийн тулд сөрөг зүйлсийг өөрийн биеэр амсах ёстой гэж хэлж байгаа юм биш. Миний үйлдэл надад төдийгүй хайртай хүмүүст маань өөр үед бол учрахгүй байсан зовлонг учруулсан. Би (1) өөрийгөө аз жаргалгүй байгааг, (2) Бурханы зарлигуудын дагуу амьдарч байхдаа хамгийн аз жаргалтай байснаа ухааран ойлгох хэмжээний даруу байсандаа талархдаг. Энэ нь миний сайн мэддэг, бусадтай хуваалцсан ч болох зүйл байв.

Би алдаагаа засахаар бишоптойгоо уулзсан бөгөөд тэр намайг номлолын үйлчлэлд бэлтгэхээр тогтмол уулздаг боллоо. Номлолын өргөдлөө бөглөж бараг дуусах гэж байхдаа би бишопоосоо миний хийсэн зарим сонголтыг ойлгож байгаа эсэхийг нь лавлан асуусан юм. Тэр ярилцлага амар байгаагүй. Гэвч би номлолд явахаас илүү Бурханы өмнө зөв байхыг хүссэн. Би Түүний өмнө цэвэр байхын тулд хийсэн бүх буруу үйлдлээ тоочиж, хариуцлага үүрэхэд бэлэн байлаа.

Удалгүй би сахилгын хурлаар оров. Олон жил удирдагч, зөвлөгч маань байсан хүмүүсийн өмнө, хийсэн буруу зүйлсээ хэлэх нь зарим талаараа аймаар байсан ч өрөөг тойруулан хараад, би амар амгаланг мэдэрсэн юм. Тэд намайг ойлгож, надад туслахын тулд тэнд байгаа нь надад харагдаж байлаа. Би хурлаас гарахдаа ямар ч шийдвэр гарсан бай, хийх ёстой зүйлээ хийсэн мөн бүх зүйл болж бүтнэ гэж Сүнс тайтгаруулахыг мэдрэв. Намайг хайрладаг Бурхан болон удирдагчид надтай ажиллаж, байх ёстой газарт маань хүргэнэ гэдгийг би мэдсэн. Харин би замдаа Аврагчийн хайрыг мэдэрч, Түүний ивээл доор гэтэлгэгдэнэ гэдгээ мэдэрч билээ.

Төгс бус хүмүүст зориулсан газар

Амар амгаланг мэдэрсэн ч яагаад номлолд яваагүй талаар хүмүүсийн шалгаах асуулт надад үнэхээр хүнд байв. Бишопынхоо тусламжтайгаар наманчлах үйл явцаа үргэлжлүүлэх хооронд ирээдүйд номлолд үйлчлэх магадлал маань улам бүр багассаар, би цаашдаа хэрхэн амьдрахаа шийдэх хэрэгтэй болов. 21 насандаа миний хувьд номлолд гарахын өмнөх үедээ байгаа залуучууд болон эргэж ирсэн номлогчид эсвэл гэрлэсэн залуучуудын алиных нь ч тоонд орохгүй байсан тул багтах газар байхгүй мэт санагдах болсон юм.

Болзоход ч бас хүнд байв. Заримдаа номлолд үйлчлээгүйгээ эсвэл хэсэг хугацаанд идэвхгүй байснаа хэлэхэд охид надтай өөрөөр харьцдаг байлаа. Ямар нэгэн шалтгаанаар ихэнх харилцаа анхны болзооноос цааш хэтэрдэггүй байв.

Би эцэст нь ариун сүмд гэрлэсэндээ баяртай байсан ч заримдаа таарч тохирохгүй байгаагаа мэдэрдэг байлаа. Надад гэрчлэл байсан ч би яаж хуваалцахаа мэддэггүй байсан бөгөөд сүмийн анги танхимд байгаа үеийнхэн маань шалгалтдаа унахыг минь харах гэж байгаа мэт санагддаг байв. Тэдний ихэнх нь миний хүссэн амьдралаар амьдардаг бөгөөд над шиг олон бүдрээгүй тул би тэгж боддог байлаа.

Нэгэн өдөр бишоп намайг дуудаад, ахлагчдын чуулгад заах дуудлага өгөв. Өнгөрсөн жил ахлагчдын чуулгад хоёрхон удаа суусан тул би гайхаж, сандарсан ч гэсэн дуудлагыг нь хүлээн авлаа. Хичээл заасан эхний ням гарагт би өөрийгөө тэдний урьд өмнө сонсож байгаагүй хамгийн хачирхалтай байдлаар танилцуулсан байх.

"Сайн байна уу, ах нар аа. Намайг Ричард Монсон гэдэг. Би номлолд үйлчлээгүй бөгөөд насанд хүрснээсээ хойш ихэнхдээ л идэвхгүй байсан. Надад таарч, тохирохгүй мэт санагддаг байсан тул би ахлагчдын чуулгад сууж байгаагүй гэж хэлбэл буруудахгүй байх. Би та нарын бүх асуултад хариулж чадахгүй ч та нарыг хичээлд оролцож, хамтдаа суралцана байх гэж найдаж байна. Та бүхэн миний хэлэх гэсэн санааг ойлгосон бол хичээлээ эхэлье" гэсэн юм.

Би тэр өдөр өөрийгөө "сум шиг шулуун" (номлолд үйлчилсэн, бүх насаараа идэвхтэй

Би өөрийгөө "сум шиг шулуун" гэж боддоггүй ч **тэдэнтэй нэг зүг рүү явж байгаагаа** ойлгосон минь юу юунаас илүү чухал байлаа.

байсан, ноцтой алдаа гаргаж байгаагүй хүн) гэж тооцоогүй ч тэдэнтэй нэг зүг рүү явж байгаагаа мөн энэ нь юу юунаас илүү чухал гэдгийг өөр-төө болон бусдад хэлж чадах юм байна гэдгээ ойлгосон. Гайхалтай нь төгс амьдралтай гэж боддог байсан тэр эрсийн ихэнх нь алдаа гар-гаж байжээ. Энэ нь төгс байдал бол ангид юм уу Сүмд үнэ цэнтэй хувь нэмэр оруулахад тавигддаг шаардлага биш юм гэдгийг бид бүгдэд бататгаж өгсөн билээ.

Хүнд хэцүү цаг үе ба гаргасан шийдвэр

Харамсалтай нь, би Сүмд удаан идэвхтэй байсангүй. Гэрлэлт маань асуудалтай байсан тул би зовлон шаналлаасаа ангижрахын тулд муу дадал зуршилдаа эргэж оров. Сүмд явахын оронд дуртай зүйлсдээ цагаа зарцуулдаг боллоо.

Гурван жил өнгөрч, би тартагтаа тулж, сонголт хийх хэрэгтэй болов. Амьдралд юу ч тохиолд-сон бай би өөрийнхөө төлөө сайн мэдээний дагуу амьдарч чадах болов уу? Эсвэл би зүгээр л харанхуйд буугаад өгчих үү? Нарийн бөгөөд шулуун зам дээр явахыг хүсвэл амьдралд буй сөрөг нөлөөнүүдээсээ ангижрах хэрэгтэй гэдгийг би мэдэж байв. Мөн сүмдээ буцаж очих хүсэл маань эхнэр бид хоёрыг өөр өөр замаар явж байгааг ойлгуулсан юм. Тухайн үед гэрлэлтийн байдлаасаа болоод бид аль хэдийн салах тийшээ хандаж байгаа нь харагдаж байв.

Би айж байлаа. Хичээл зүтгэл гаргасан ч хүссэн сайн сайхан зүйлээ энэ амьдралаас авна гэсэн ямар ч баталгаа байхгүй байв. Гэвч миний гаргасан шийдвэр олон жилийн өмнө мэдсэн тэр л зүйлийг буюу сайн мэдээний дагуу амь-дарч байхдаа л аз жаргалтай байсан гэдгийг дахин сануулсан юм. Юу ч болж байсан би Бур-ханы мутарт өөрийгөө бүрэн дүүрэн даатгахаар

шийдлээ. Түүнээс хойш бүх зүйл зөвхөн бид хоёрын дунд байх болов.

Би дахиад сүмдээ явах болж, амьдралаа голдиролд нь эргүүлэн оруулж эхэллээ. Амьдралын минь хамгийн аз жаргалтай өдрүүдийн нэг бол ариун сүмийн эрхийн бичгээ дахин хүлээн авсан өдөр байв. Гэр бүлийн асуудал маань даамжирсаар, эцэст нь салах үед би ариун сүмд очин, тайтгарч байж билээ.

Өөрийн үнэ цэнийн эх сурвалжийг олсон нь

Тийм шийдвэр гаргахад сүрдмээр байсан ч тэр үйл явдлын ачаар би өөрийн амьдралд байх Бурханы мутарт талархаж сурсан. Би бүдэрч унасан ч уралдаанд ялагдаагүй. Би өөр хэн нэгэнтэй өрсөлдөөгүй. Би өөрийн үнэ цэнийг олохоор Аврагчид итгэж найддаг болсноор өөрийнхөө тухай бусдын бодлыг өөрчлөх гэж хичээхээ больсон.

Бид Сүм дээр ганцаараа эсвэл амьдралынхаа өөр өөр үе шатанд байгаа гишүүдийн дунд суухаасаа санаа зовохоо болив. Би бусдаас нуугдахаа больж, тойргийнхоо хүмүүстэй ярилцахыг хичээдэг болов. Би мөн хурал цуглаануудаа зорилгынх нь дагуу суух дуртай болсон юм.

Амар амгаланг олсон явдал маань болзож эхлэхэд тусалсан. Би хоёр дахь болзоондоо олон яваагүй ч өмнө нь алдаж оноож байсан ч жишгээ бууруулах хэрэггүй гэдгийг одоо мэддэг болсон. Би чадлынхаа хэрээр сайн мэдээний дагуу амьдарч байсан бөгөөд сайн мэдээний дагуу амьдрахыг чадлаараа хичээж байгаа хүмүүстэй болзож болохоор сайн байгаа гэдгээ мэдэх болсон юм.

Эцэст нь би Бурханы зохистой охиныг олж, түүнтэй ариун сүмд гэрлэв. Түүний зам минийхээс өөр байсан ч Аврагчийг хайрлах хайрын тухай болон Түүний Цагаатгалын талаар бид ижил ойлголттой байлаа.

Он жил өнгөрсөөр би өөрийн одоогийн үнэ цэнийг өнгөрсөн амьдралаараа эсвэл бусад хүнээр хүлээн зөвшөөрүүлэх шаардлагагүй гэдгийг мэдэж авсан. Ингэж амьдарсан хүнийг л амжилттай хүн гэж хэлж болно гэж боддог байснаа би одоо больсон. Одоо байгаа газартаа хэрхэн ирснийг минь хүн бүр ойлгодоггүй ч энэ нь асуудал биш юм. Би тэднийг ятгаж үнэмшүүлэх албагүй. Цаашид наманчилж, Аврагчид илүү ойртох явдал миний зорилго байна. Наманчилсныхаа дараа Залуу Алмагийн хэлсэнчлэн, би Түүний ачаар "нүглүүдийнхээ санамжинд цаашид тарчлагдахгүй" байж чадна (Алма 36:19). Би хаашаа явж байгаагаа буюу Аврагч руу очиж яваагаа мэдэж байгаа тул сэтгэл амар явж байгаа. ■

Ричард Монсон *АНУ-ын Юта мужид амьдардаг ба программ боловсруулан гаргах төслийн менежерээр ажилладаг. Тэр эхнэрийнхээ хамт мотоцикл унаж, аялж, чөлөөт цагаараа хоол хийх дуртай.*

Би бүдэрч унасан ч уралдаанд ялагдаагүй. **Би өөр хэн нэгэнтэй өрсөлдөөгүй.**

"Хүүхэд ба өсвөр үеийнхэн" хөтөлбөрт хамрагдаж байгаадаа би үнэхээр баяртай байгаа. Яагаад гэвэл, би өөрийнхөө зорилгыг өөрөө тавих боломжтой.

Би гэр бүлийнхээ нэрсийг олж, тэдний өмнөөс нас барагсдын төлөөх баптисм хүртэхийг нэг зорилгоо болгон сонгосон. Гэр бүлийн түүхийн ажлыг хийж сурахад их хичээл зүтгэл шаардагдсан ч ариун сүм рүү авч явах шинэ нэр олох бүрдээ би маш их баярладаг байсан юм.

Би уг ажлыг гартаа оруулсныхаа дараа үнэхээр зугаатай байсан тул үргэлжлүүлэн хийсээр байв. Удалгүй би өөрөө хийж амжихааргүй олон нэртэй болсон тул хайж олсон нэрээ аваад, үеэлүүдтэйгээ хамт ариун сүм явж, хамтдаа 172 хүний баптисм, гишүүнээр батлах ёслолыг хийж гүйцэтгэсэн юм.

Үлдсэн хүмүүсийн ариун сүмийн бусад ёслолыг эцэг эх маань хийж дуусгахаар ажиллаж байгаа нь сайхан төдийгүй манайхан гэр бүлээрээ нэг баг мэт санагдаж байсан. Бидний зорилго бол аль болох олон өвөг дээдэстээ чадах чинээгээрээ туслах явдал юм.

Гэр бүлийн түүхийн ажлыг хийх нь амьд буй гэр бүлийнхэн болон өвөг дээдсийнхээ аль алинтай илүү ойртоход надад тусалсан. Би зорилгодоо хүрсэндээ баяртай байгаа. Цаашид илүү хэцүү зорилго тавьж, улам ихийг хийж болно гэж найдаж байна.

Элдон М., 13 настай, АНУ, Огайо

ГЭРЭЛ ЗУРГИЙГ РАНДИ КОЛИЭ

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

ЭНЭ ХЭСЭГТ



явж мөн биелүүл

52 **Хүүхэд ба өсвөр үеийнхэн: Өдөр тутмын амьдралдаа төвлөрөх**
Хэдэр Бөргэсон ба Аманда Данн

56 **Явж мөн биелүүл**
Залуу эмэгтэйчүүд, Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлүүд

59 **Мормоны Номын хүчийг нээх нь**
Симмони Анн Парк

60 **2020 оны Өсвөр үеийнхний уриа дуу: Би явж мөн биелүүлнэ**
Ник Дэй

64 **Сүүлчийн үг: Явж, мөн Бурханд итгэх итгэлээр үйлд**
Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг

ХҮҮХДҮҮД ба ӨСВӨР ҮЕИЙНХЭН:

Өдөр тутмын амьдралдаа төвлөрөх

Хэдэр Бөргэсон ба Аманда Данн
Сүмийн сэтгүүлүүд

Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн хөтөлбөрт тавьсан зорилгодоо хүрэхийн тулд өдөр бүр хийх зүйлсийн жагсаалт байхгүй байгаад та гайхаж байж магадгүй. Та аль хэдийн олон гайхалтай зүйлийг хийж байгаа! Тиймээс энэхүү хувь хүнд чиглэгдсэн арга зам нь хувийн хэрэгцээ, сонирхол дээр чинь суурилсан арга замаар Аврагчид илүү ойртоход туслах зорилгоор бүтээгдсэн.

Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн хөтөлбөрийн гол зорилго нь Есүс Христэд итгэх итгэлээ хүчирхэгжүүлэхэд туслах явдал юм. Лук 2:52 нь өсвөр насандаа Есүс Христийн "мэргэн ухаан, бие хаа өссөөр байсан агаад Бурханы хийгээд хүмүүсийн таалал Түүнд байлаа" гэж заадаг. Түүний амьдрал тэнцвэртэй байсан бөгөөд таныг ч бас тэнцвэртэй байлгах боломжтой. Та амьдралынхаа сүнслэг байдал, нийгэм, бие махбод, оюун ухаан гэсэн талууд дээр анхаарлаа төвлөрүүлснээр Аврагчтай илүү адил болж чадна.

ХЭРХЭН ЯВАГДАХ ВЭ

Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн хөтөлбөр нь таныг сайн мэдээнээс суралцах, үйлчлэл ба үйл ажиллагаанууд, хувийн өсөлт хөгжил гэсэн үйл ажиллагаанд оролцсоор сүнслэг байдал, нийгэм, бие махбод, оюун санааны тал дээр өсөж хөгжихөд урамшуулан дэмжинэ.

ГЭРЭЛ ЗУРГИЙГ РАНДИ КОЛИЭ



САЙН МЭДЭЭНЭЭС СУРАЛЦАХ

Аврагчийн “мэргэн ухаан өс[сөнтэй]” (Лук 2:52) адил та сайн мэдээний талаарх мэдлэг, ойлголтоо өсгөн нэмэгдүүлж чадна. Суралцах сайн мэдээний зарчим бүр тань амьдралын бүхий л хүрээнд Аврагч таныг хэрхэн хүчирхэгжүүлж, адислахыг олж мэдэхэд тусална.

Сайн мэдээний зарчмуудын талаар илүү ихийг ойлгож мэдэн, Аврагчтай илүү адил болохын тулд ашиглаж болох маш олон эх сурвалж бидэнд бий. Жишээлбэл: залбирал, судраас суралцах явдал, Сүнс зэрэг нь суурийг нь тавьж өгөх юм. Гэр бүл, Сүмийн удирдагчид тань Аврагчийн талаар илүү ихийг олж мэдэхэд тусална. Ирээд, Намайг дага сургалтын материал болон семинар ангиуд хичээлийг тань удирдан чиглүүлэхэд тусална. Есүс Христийн тухай болон Түүний сайн мэдээний талаар суралцахын тулд өөрийн эх сурвалжуудыг ашигласнаар Түүнтэй харилцах харилцаа тань сайжрах болно.

ҮЙЛЧЛЭЛ БА ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бусдад үйлчлэх нь Аврагчийн энэ дэлхий дээр байхдаа хийсэн хамгийн чухал зүйлсийн нэг байсан. Та гэр бүлийнхэндээ болон орон нутгийнхандаа туслах энгийн бөгөөд хялбар арга замуудыг олсноор Түүний жишээг дагаж, Түүнтэй илүү адилхан болоход бэлэн байгаагаа харуулж байгаа.

Бүлгийн утга учир бүхий үйл ажиллагаанууд танд болон бусад өсвөр үеийнхэнд бусдад үйлчлэхийн зэрэгцээ сүнслэг байдлын хувьд хамтдаа өсөж хөгжих арга замыг олоход тусална. Зугаатай, урамшуулан зоригжуулдаг үйл ажиллагаанууд нь эрүүл бөгөөд ашиг тустай. Та нар залуу, итгэлтэй хохмын үеийн гэгээнтнүүдийн бүлэгт цугларснаар ганцаараа, өөрийн хийж чадахаас ч илүү ихийг сурч, хийж чадна.

ХУВИЙН ӨСӨЛТ ХӨГЖИЛ

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр танд болон таны болж буй тэр хүнд маш их анхаарал халамж тавьдаг. Тэнгэрлэг Эцэгийн болоосой гэж хүсдэг хүн нь болж өсөж хөгжих зорилго тавьснаар та Түүнд болон Түүний Хүүд илүү ойртох юм.

Хүн бүр онцгой учраас таны өсөж хөгжих зорилго хэрэгцээнд чинь таарсан байх ёстой. Жишээлбэл, та төгөлдөр хуур дээр сүмийн дуулал тоглож сурахыг хүсэж байгаа бол өдөр бүр давтах зорилго тавьж болно. Хэрвээ та судраас илүү сайн суралцдаг болохыг хүсэж байвал өдөр бүр уншихад зориулан, тодорхой цаг гаргаж болох юм. Сүнсний удирдамжийг эрэлхийлж, өөртөө хамгийн сайн тохирох төлөвлөгөөг гарга.



ХҮҮХДҮҮД БА ӨСВӨР ҮЕИЙНХЭН ХӨТӨЛБӨР ***ТАНД*** ЗОРИУЛАГДСАН

Эндээс хамгийн ихийг сурч мэдэх хүн бол та! Та сайн мэдээг судалж, үүний дагуу амьдарч, үйлчлэл ба үйл ажиллагаануудад оролцох, хувиараа өсөж хөгжих зорилго тавьснаар өөрийнхөө талаар мөн яг хэн болохоо илүү сайн мэдэж авна. Есүс Христийн шавь болох ажил хэцүү байж болох ч энэ нь бидний тавьж болох хамгийн үр өгөөжтэй зорилго юм.

САЙМОН ДЮВИГИЙН *УСНЫ ХАЖУУХАНД* ЗУРГИЙН ХЭСГЭЭС

ИХЭР ЭГЧ ДҮҮС ХҮҮХДҮҮД БА ӨСВӨР ҮЕИЙНХЭН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН НЬ

Чиний нэгэн адил, өсвөр үеийнхэн өдөр тутмын амьдралдаа Есүс Христтэй илүү адилхан болохыг хичээснээр хүртэх адислалыг аль хэдийн харж эхэлжээ. АНУ-ын Огайо мужийн 15 настай Даника, Наташа Р. хоёр хөтөлбөр дээр ажиллахаар шийдсэн ихэр эгч дүүс юм. Аав нь Тайландаас ирсэн бөгөөд тэнд байдаг гэрийнхэн дээрээ заримдаа очдог тул Даника, Наташа хоёр тай хоол болон хэлний талаар илүү ихийг сурч мэдэхийг хүсжээ.

Даника зарим тай шөлний жороор хоол хийж сурах зорилго тавив. Тэр орцуудаа худалдан авч, хоол хийх шинэ аргыг аавтайгаа хамт сурчээ. Харин Наташа Тайландад байдаг гэр бүлийнхэнтэйгээ ярьж сурахыг хүссэн тул өдөр бүр нэг шинэ тай үг сурах зорилго тавив. Тэр хэл судлахдаа вэбсайт ашигласан бөгөөд үгсийн дуудлагыг аавтайгаа хамт давтах болсон байна.

Даника, Наташа хоёр зорилго дээрээ ажиллах явцдаа сурсан мэдсэн зүйлээ тойргийнхоо бусад залуу эмэгтэйтэй хуваалцахыг хүсжээ. Тайландын тухай илүү ихийг сурч мэдэх үйл ажиллагааг зохион байгуулахад удирдагчид нь туслав. Үйл ажиллагаан дээр Даника хүн бүрд зориулан шөл хийсэн бол Наташа тэдэнд хэдэн тай үг заажээ.

Эгч, дүү хоёр үйл ажиллагаандаа өөрийн найз Грэйсийг оролцуулсан юм. Грэйс сайн илтгэл тавьдаг болох хувийн зорилго тавьсан тул савх ашиглан, шөлөө хэрхэн идэх тухай толилуулга хийжээ.

Зорилго дээрээ ажиллан, удирдагчидтай болон бусад залуу эмэгтэйтэй хамтран ажилласнаар Даника, Наташа хоёр төлөвлөгөө гарган, найз нөхөдтэйгөө нэгэн үдшийг зугаатай сайхан өнгөрүүлж чадсан.

ХҮҮХДҮҮД БА ӨСВӨР ҮЕИЙНХЭН ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦСОНООР ИРЭХ АДИСЛАЛУУД

Даника, Наташа хоёр өв уламжлалынхаа талаар илүү ихийг сурч мэдэн, түүнийгээ гэр бүлийнхэнтэйгээ болон бусад залуу эмэгтэйтэй хуваалцахыг хичээснээр олон адислал хүлээн авсныг хуваалцсан юм. Тэд энэ туршлагаа амархан олж аваагүй. "Би хичээлдээ явж байхдаа тай хэл сурч байсан тул заримдаа сурах цаг гарахгүй хэцүү байсан" гэж Наташа тайлбарлав. Даника "Үйл ажиллагааны үеэр аав хамт байгаагүй тул бие даан шөл хийхэд бага зэрэг хэцүү байсан" гэж нэмж хэлэв. Тийм байсан ч эгч, дүү хоёр үйл ажиллагаа хийсэндээ харамсахгүй байгаагаа дуу нэгтэй хэлсэн юм.

Даника: "Би аавтайгаа хамт цагийг өнгөрүүлсэндээ баяртай байгаа. Энэ нь надад гэр бүлтэйгээ илүү ойр дотно болоход тусалсан" гэж хэлээд, "Хувийн зорилго тавьж, сахих нь надад өөртөө болон бусдад туслах тодорхой арга замыг өгснөөр Есүс Христэд илүү ойртоход тусалсан. Зарим үдэш утга учиргүй зүгээр суухынхаа оронд дагаж, сахих жишиг надад байсан ба энэ нь надад Христийн тухай бодох илүү их цагийг гаргаж өгсөн" гэж тайлбарлалаа.

Зорилго тавьж, сахих нь "Христэд улам ойртож болохын тулд юу хийх хэрэгтэй мөн юу хийхийг хүсэж байгаагаа гүн гүнзгий бодоход надад тусалсан" гэж Наташа ярив. Мөн тэр шинэ зорилго тавьсан ч тай хэлээ үргэлжлүүлэн сурах сүнсний өдөөлт авснаа дурдаад, "Миний эхний зорилго бол тай хэл сурч, Тайландад байдаг гэрийнхэнтэйгээ ярих явдал байсан тул би тэдэнтэй харьцдаг болохын тулд тай хэлийг үргэлжлүүлэн сурмаар байна" хэмээн онцлон хэлэв.

Даника, Наташа хоёр хувийн өсөлт хөгжилдөө тэнцвэртэй хандсан явдал тэдэнд аавынхаа соёл, уламжлалын талаар ихийг сурч мэдэн, найзуудтайгаа цагийг хөгжилтэй сайхан өнгөрүүлж, гэр бүлтэйгээ болон Аврагчтай илүү ойртоход тусалсан. Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн хөтөлбөр ийм л зорилготой юм.

Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн хөтөлбөрт оролцох нь таныг өөрийнхөө хүрч болох хамгийн сайн түвшинд хүрэхэд анхаарлаа төвлөрүүлэх явцдаа гэр бүлийнхэн, бусад өсвөр үеийнхэнтэй болон тойргийн гишүүдтэй, ялангуяа Аврагчтай харилцаагаа бэхжүүлэхэд тусална. ■

Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн хөтөлбөрт оролцоход зориулсан зөвлөгөө

Өсөж хөгжих хамгийн шилдэг арга зам бол зорилгоо залбиран байж, өөртөө тохируулан тавих явдал бөгөөд ингэснээр зорилгууд тань танд болон таны гэр бүлд, түүнчлэн нөхцөл байдалд тань тохирсон байх болно. Хэдэн зөвлөгөө өгье.

1. **Хувийн илчлэлт эрэлхийл**
   Сүнслэг удирдамжийг эрэлхийлж, дагах үед Тэнгэрлэг Эцэг таныг хөтлөн чиглүүлнэ.
2. **Энэ нь зөвхөн Сүмд зориулагдаагүй**
   Та сүмийн цуглаан, үйл ажиллагаанаас гадна амьдралаа бүхий л талаар сайжруулах төлөвлөгөө гаргах юм бол Хүүхдүүд ба өсвөр үеийнхэн хөтөлбөрөөс аль болох ихийг сурч мэдэх болно.
3. **Гэр бүлээ оролцуул**
   Зорилгодоо хүрч, өсөлт хөгжлөө тэмдэглэхэд танай гэр бүлийн гишүүд тусалж болох юм.
4. **Сурсан зүйлээ ашиглаж, бусадтай хуваалц**
   Та сурч мэдсэн зүйлээ гэр бүлийнхэн, найз нөхөд болон бусадтай хуваалцсанаар сайн мэдээг түгээж, тараагдсан Израилыг цуглуулах Их Эзэний зарлигийг биелүүлэхэд гар бие оролцож байдаг.

ЯВЖ МӨН биелүүл

Итгэлээр үйлд

Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөл

Энэ жилийн уриа нь 1 Нифай 3:7 дээрх Мормоны Номын итгэлтэй бошиглогч Нифайн зоригтой тунхагласан "явж мөн биелүүл" хэмээх үгэн дээр төвлөрсөн. Гэвч Их Эзэн Өөрийн ажлыг гүйцэлдүүлэхийн тулд "замыг бэлтгэдэг" хэмээн Нифайг заах үед энэ шүлгийн хамгийн тайтгаруулсан хэсэг гардаг.

Бурхан өмнө тань замыг бэлтгэнэ гэдэг нь гүн гүнзгий итгэл үнэмшлээс төрнө. Бурхан өөрөөс нь ямар нэгэн зүйл хийхийг хүсвэл уг даалгавраа биелүүлэхэд нь тусална гэдгийг Нифай мэдэж байв. Бид ч гэсэн Их Эзэнд итгэснийхээ ачаар Нифайг гуулин ялтаснуудыг амжилттай авч чадсаныг мэднэ.

Бид Нифай шиг "явж мөн биелүүл" итгэлтэй байж чадна. Та Сүмийн удирдагчийн болон эцэг эхийн зааврын, бүр Ариун Сүнсний өдөөлтийн цаана байх "яагаад" гэсэн шалтгааныг үргэлж ойлгохгүй байж болно. Энэ нь ойлгомжгүй эсвэл бүр хийх боломжгүй мэт санагдаж ч болох юм. Гэвч "Бурханд боломжгүй юм гэж нэг ч байхгүй" (Лук 1:37). Та итгэлтэйгээр урагшилснаар Бурханд үргэлж зорилго, төлөвлөгөө байдгийг олж мэдэх болно.

Бурхан хэзээ ч танаар хийж чадахгүй байх зүйлийг тань хийлгүүлэхгүй. Тэр танаар хэзээ ч бүтэхгүй зүйлийг хийлгүүлэхгүй. Гэвч Тэр танаар хүчтэй итгэлийг болон Сүнснээс удирдамж авахыг шаардсан зүйлийг хийлгүүлэхийг хүсэж магадгүй.

Итгэлээ хөгжүүлэх нь "явж мөн биелүүл" итгэлийг олж авах түлхүүр юм. Та Их Эзэнд итгэлтэй байх юм бол Тэрээр таныг бүх даалгаврыг хийж гүйцэтгэх чадалтай болгоно гэдэгт итгэдэг болно. Та яг одоо, энд Их Эзэний ажлыг хийхээр бэлтгэгдсэн мөн хийх чадвартай тул таныг энэ цаг үед дэлхий дээр илгээсэн гэж бод. Их Эзэн танд итгэдэг тул таныг энэ цаг үед амьдруулахаар сонгосон.

Итгэлийнхээ дагуу, өөртөө итгэлтэй үйлдсэнээр хүлээн авах адислалууд тань гайхалтай. Та өөрийнхөө хэн болохыг мэдэж авахаас гадна зорилгоо илүү тод томруун харж, Есүс Христэд болон Түүний Цагаатгалд итгэх итгэлээ өсгөн, Их Эзэний тусламж байсан цагт юу ч байсан хийж чадна гэдгээ мэдэх болно. ■

Нифай шиг бай

Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөл

Нифай эцэгтээ хандан, “би явж бас Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг биелүүлэх болно” (1 Нифай 3:7) хэмээн хэлснээр бидэнд итгэлийн болон хичээнгүй дуулгавартай байдлын сэтгэл хөдөлгөм жишээг үзүүлсэн юм. Нифай явж мөн биелүүлэхэд бэлэн байсан явдал бид бүгдийн хөгжүүлж чадах хоёр чухал зан чанарт үндэслэгдсэн. Энэ хоёр зан чанар нь Их Эзэний болон Түүний бошиглогчдын талаарх хувийн гэрчлэл болоод сүнслэг байдлын хувьд гуйвшгүй байх явдал юм.

Гэрчлэлийг хөгжүүлэх

Нифай Их Эзэний эцэгт нь өгсөн зарлигуудын талаар гэрчлэлтэй болохыг эрэлхийлж мөн хүлээн авсан тул дуулгавартай байсан (1 Нифай 2:16–20-ийг үзнэ үү). Тэрээр гуулин ялтаснуудыг авах даалгавар хэцүү байна гэдгийг мэдэж байсан. Гэвч ах нарыгаа бодвол тэр Их Эзэн өөртэй нь хамт байж мөн тэдэнд авсан даалгавраа гүйцэлдүүлэх арга замыг гаргаж өгнө гэдгийг мэдэж байв.

Нифайн Бурханд болон Түүний бошиглогчдод итгэх итгэл амьдралынх нь туршид түүнийг адислан, дэмжиж, гайхамшигт зүйлсийг гүйцэлдүүлэхэд тусалсан. Бид амьд бошиглогчдыг болон Ариун Сүнсний шивнээг мөн судруудаас хүлээн авсан зөвлөгөөг дуулгавартай дагахыг хичээснээр амьдралдаа Нифайн адил агуу зүйлсийг хийж чадна. Жишээлбэл, өнөө үеийн Их Эзэний бошиглогч, ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон Израилыг цуглуулж, Аврагчийн ирэхэд бэлтгэхэд туслахыг биднээс хүссэн.[1]

Бурханы үгийг судалж, дуулгавартай дагаснаар бидний итгэл өсөн нэмэгдэж, хэцүү гэж мэдсэн ч дуулгавартай байх шийдэмгий байдлыг зүрх сэтгэлдээ мэдрэх болно.

Сүнслэг байдлын хувьд гуйвшгүй байх хүчээ хөгжүүлэх нь

Нифайн үлгэр жишээ бидэнд Христийнхтэй адил гуйвшгүй зан чанарын талаар амар хялбар арга замыг хайхын оронд сорилт бэрхшээлийг даван туулах тухай заадаг. Амьдралд биднээс хүнд, хэцүү зүйлийг хийхийг шаардах үе байдаг. Ийм үед хэрэв бид Христэд итгэх итгэлдээ найдаж, “амархан буруу зүйлийг хийхийн оронд хэцүү ч гэсэн зөв зүйлсийг хийхээр сонго” [2]-вол адислагдах болно.

Хэцүү шийдвэр, даалгавартай тулгарвал “явж, хий” гэсэн хандлагаар хандах нь тууштай байхад тань тусална. Хүлээн авсан удирдамжийнхаа дагуу итгэлээр үйлдэх нь танд найдаж болно гэдгийг Их Эзэнд харуулахын зэрэгцээ Их Эзэнд итгэх итгэлийг тань нэмэгдүүлэх болно.

Та өөрийн гэрчлэл, сүнслэг байдлын хувьд гуйвшгүй байх чадвар, “явж, хийх” хандлагаа хөгжүүлэхээр итгэлтэй ажиллах юм бол Их Эзэн таныг энэ жилийн туршид мөн амьдралын тань турш адисалж, хүчирхэгжүүлж, дэмжих болно. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Рассэлл М.Нэлсон, “Израилын итгэл найдвар” (Өсвөр үеийнхний дэлхий даяарх онцгой цугларалт, 2018 оны 6-р сарын 3), HopeofIsrael.ChurchofJesusChrist.org-ийг үзнэ үү.
2. Томас С.Монсон, “Сонголтууд,” 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган.

МОРМОНЫ НОМЫН
хүчийг нээх нь

Симмони Анн Парк

Филиппинд номлолд үйлчилж байхдаа хамтрагч бид хоёр Мормоны Номыг өдөр бүр судлахын ач холбогдлын талаар нэгэн онцгой бөгөөд хүчирхэг хичээлийг заасан юм. Хичээлийн төгсгөлд хамтрагч маань судар судлахтай холбоотой миний сонсож байсан хамгийн хүчтэй гэрчлэлүүдийн нэгийг хуваалцаж билээ. Мормоны Ном уншсан нь түүний амьдралд үгээр илэрхийлэхийн аргагүй шинэ хүч өгснийг тэр гэрчлэв.

Мормоны Номтой холбоотой туршлага нь түүний амьдралыг өөрчилсөн нь илт байсан ба би бас ийм туршлагатай болохыг хүссэн юм.

Тэр орой би Мормоны Номыг эхнээс нь дахин уншихаар шийдэв.

Би Бурханд Ариун Сүнснээс ирэх хөрвөлт, хүчийг мэдрэхийг хүсэж байгаагаа тайлбарлан, олон цагийг өвдөг сөгдөн өнгөрүүлсэн.

Миний хүлээн авсан хариулт бол унших байв. Зөвхөн унш.

Тиймээс ч би үүнийг нь дагав. Би шинэ эрч хүчээр уншиж эхэллээ. Би шүлэг, бүлэг, хуудас бүрийг онцгой анхаарав. Уншиж байхдаа би асуултуудад маань хариулж, сэтгэлийн зовнилыг минь арилгаж, зааж буй хүмүүсийнхээ ачааг хөнгөлөхөд туслах шүлгүүдийг олж байлаа.

Сарын дараа миний дотор ямар нэгэн зүйл өөрчлөгдөж байгааг би анзаарч эхлэв. Миний бусдыг хайрлах чадвар өсөн нэмэгдэж, ирээдүйдээ илүү итгэлтэй, өдөр бүр илүү олон цагаар шаргуу ажиллаж чаддаг, ажилдаа илүү их анхаарлаа хандуулдаг, илүү их баяр хөөр мэдэрдэг болсон байлаа.

Би нэг өдөр судар судалж байгаад, ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсоны (1899–1994) “Энэ номонд хүч агуулагддаг бөгөөд нухацтай судалж эхлэх тэр мөчөөс тань эхлэн уг хүч таны амьдралд урсан орж ирэх болно. . . . Та нар эдгээр үгийн араас өлсөж цангаж эхлэх үедээ өөрсдийн амьдралыг илүү элбэг хангалуун болохыг мэдрэх болно”[1] гэсэн үгийг олж уншсан юм.

Би үргэлжлүүлэн судалж байхдаа түүний яг юу гэж хэлснийг илүү сайн ойлгож эхэлсэн. Миний амьдрал илүү элбэг хангалуун байгааг би олж харах *болсон*.

Эргээд бодоход, би тэр орой яг тэр хамтрагчийнхаа гэрчлэлийг сонсохын тулд түүний хамтрагч болсон гэдэгт огтхон ч эргэлздэггүй. Үүний ачаар хайр, найдвар, итгэл, шаргуу хөдөлмөр, шийдэмгий байдал, баяр баясгалан гэх мэт амьдралын бүхий л сайхан зүйлс өсөн нэмэгдсэн гэж би боддог.

Миний амьдралд шинэ гэрэл гарч ирсэн ба бодитой гэдгийг нь би мэддэг болсон. ■

Зохиогч нь АНУ-ын Аризонад амьдардаг.

Та Мормоны Номын хүчийг амьдралдаа хэрхэн нээж чадах вэ?

1. **Өдөр бүр унш.**
2. **Сэдэв сэдвээр судал.**
3. **Судлах гарын авлага ашигла.**
4. **Бусадтай ярилц.**

“Та нар *өдөр бүр* Мормоны Номыг залбирч судалбал *өдөр бүр* илүү сайн шийдвэр гаргадаг болно гэдгийг би амлаж байна.”[2]

ЭШЛЭЛҮҮД

1. Ezra Taft Benson, “The Book of Mormon—Keystone of Our Religion,” *Ensign,* Nov. 1986, 7.
2. Рассэлл М.Нэлсон, “Мормоны Ном: Үүнгүйгээр таны амьдрал ямар байх байсан бэ?” *2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган*, 55 .

© GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

Би явж мөн биелүүлнэ

2020 оны Өсвөр үеийнхний уриа дуу

Бодлогошронгүй ♩ = 78

Үг, аяыг Ник Дэй



© 2019 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.
Энэхүү дууг арилжааны бус зорилгоор сүмд болон гэр бүлийн хэрэгцээнд зориулан олшруулж болно.
Энэ мэдэгдлийг олшруулсан хуудас бүрд оруулна уу.


13
минь хүнд - дэх үед на - майг Тэр и - вээ - нэ. Тий - мээс зар - лиг бүх - нийг
дөг, хэ - рэг - тэй бүх хүч чад - лыг өг - дөг. Тий - мээс зар - лиг бүх - нийг
Bm7 A E Bm7
16
би
би
Явж мөн бие - лүүл - нэ. Үнэ - нийг хам - гаал - на. Дэл - хий шант - ран
D A C♯m
19
у - хар - сан ч Би у - раг - шил - на. Түү - нийг би да - гах а - ваас, ит - гэ - лээр дага-
F♯m D A
22
To Coda
ваас Тэр а - чааг минь хөн - гөлж, за - мыг минь бэлдэ - нэ. Тэр за - мыг бэлдэ-
C♯m F♯m D


25
1.
2.
нэ. нэ. Эл-сэн цө-лийг туу-лан Эн-гүй да-лайг гат-лах За-мыг Тэр
A E F♯m
28
бэлдэ - нэ. Тий - шээ на - майг ил - гээ - вэл Тө - лөв - лө - гөөг нь дага -
E7 A
30
на. Түү-ний бү-хий л зарли-гийг дага - на, би. Тэр-бээр На майг ам-лагд-сан
D E
32
ну - таг руу хө - төл - нө. Явж мөн бие - лүүл - нэ. Үнэ-нийг хам-гаал-
Bm7 D E A


36
D.S. al Coda
на. Дэл-хий Түү-нээс тат-гал-завч Түүнд би зүр - хээ нээнэ. Түү-нийг би дага -
C♯m
F♯m
D
CODA
39
гэнэ. Тэр за-мыг бэлдэ-нэ.
A
C♯m
F♯m
42
Орч - лонд би хаа ч яв - сан,
D
A
44
орь ган - цаа-раа биш ээ. Ав-рагч дэр-гэд бай-гааг мэ - дэр - дэг.
C♯m
F♯m
D

Явж, мөн Бурханд итгэх итгэлээр үйлд

Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг
Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх

Мормоны Ном дээр гардаг залуу Нифайн үлгэр жишээ бидэнд хүнд хэцүү ч гэсэн Их Эзэнд итгэх итгэлээ хөгжүүлж, зарлигуудыг нь дуулгавартай сахих хүсэл эрмэлзлийг төрүүлдэг. Нифай аюултай нүүр тулгарч, үхэж болох байсан ч дараах итгэлийн тухай үгийг хэлснийг бид зүрх сэтгэлдээ мэдрэх ёстой. "Их Эзэн өөрийн зарлигийг гүйцэлдүүлэх замыг тэдэнд зэхэлгүйгээр хүмүүний үрст зарлиг эс буулгана гэдгийг би мэдэх учраас би явж бас Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг биелүүлэх болно" (1 Нифай 3:7).

Ийм итгэл Бурханыг таньж, мэдсэнээр ирдэг. Дэлхий дээрх өөр бусад хүнээс адилгүй нь, сайн мэдээ сэргээгдэж, гайхамшигт үйл явдлууд тохиосны ачаар Их Эзэн Өөрт нь итгэх итгэлийг бидэнд өгөхийн тулд Өөрийнхөө талаар илчилсэнд бид талархдаг.

Миний хувьд үүнийг 1820 онд Нью-Йорк мужийн нэгэн ойн цоорхой дахь фермчин хөвгүүнээс эхэлсэн гэж үздэг. Иосеф Смит нэртэй хөвгүүн ойн нэгэн бөглүүхэн газарт очиж, Бурханд бүрэн дүүрэн итгэлтэйгээр өвдөг сөгдөн залбирсан юм. Энэ үйл явдлын тухай унших бүрд Бурханд болон Түүний үйлчлэгчдэд итгэх итгэл минь нэмэгддэг билээ.

"Өөрийнхөө чанх орой дээр нарнаас илүү хурц гэрэлтэй гэрлэн багана над уруу алгуурхан доош бууж ирэхийг би харлаа.

. . . Мөнөөх гэрэл над дээр тогтоход гялалзсан өнгө хийгээд алдар сууг нь дүрслэхийн аргагүй хоёр Хүн миний дээр агаарт зогсож байхыг би харав. Тэдний нэг нь надтай ярьж, намайг нэрээр минь дуудан мөн нөгөөх уруугаа зааж хэлэв—*Энэ бол Миний Хайртай Хүү. Түүнийг сонс!"* хэмээн хэлжээ. (Иосеф Смит—Түүх 1:16–17).

Эцэг амьд гэдгээ болон Есүс Христ бол Түүний хайртай Хүү гэдгийг мөн Тэрбээр бидэнд хайртай учраас биднийг аврахын тулд Хүүгээ илгээсэн тухайгаа бидэнд илчилсэн. Тэрээр уг хүүг бошиглогчоор дуудсан гэдэг гэрчлэл надад байдаг учраас би Түүний төлөөлөгч, бошиглогчдод болон Бурханд үйлчлэхээр дуудагдсан хүмүүст итгэдэг.

Та нар сурч мэдэх, наманчлах зорилготойгоор сонсоод, явж, Түүний хүссэн бүхнийг биелүүлснээр Түүнд итгэх итгэлээ харуулдаг. Хэрэв та нар Түүнд найдаж мөн Түүний урмын захиас, залруулгыг болон үйлчлэгчдийнх нь удирдамж зааврыг сонсвол тэдгээрийг олох болно. Дараа нь явж, Түүний хий гэснийг хийж чадвал та нарын Түүнд итгэх итгэл өсөж, Түүний та нарт итгэж найддаг талаар өөрсдөө олж мэдэн талархах болно. ■

2010 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгээс авав.

Явж мөн биелүүл

“Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, эцэгтээ хандаж хэлрүүн: Их Эзэн өөрийн зарлигийг гүйцэлдүүлэх замыг тэдэнд зэхэлгүйгээр хүмүүний үрст зарлиг эс буулгана гэдгийг би мэдэх учраас би явж бас Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг биелүүлэх болно.”

1 НИФАЙ 3:7

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

ШИНЭ ЭХЛЭЛД БЭЛЭН ҮҮ?

Залуучууд өөрсдийн наманчлалын талаар болон Аврагчид хандсан түүхүүдээсээ хуваалцав.

42

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

2020 ОНЫ ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ УРИА

56, 60, 64

ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛАВ

ЭНЭ МОРМОНЫ НОМЫН ХҮСНЭГТИЙГ ЭНЭ ЖИЛИЙН ТУРШ УНШИХДАА АШИГЛААРАЙ.

Н12

MONGOLIAN
4 02167 16363 3

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

Найз

2020 оны 1-р сар

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэн гаргадаг *Лиахона* сэтгүүлийн хүүхдэд зориулсан хэсэг

Мормоны Номыг унш!

Н12-р хуудсыг үзнэ үү.

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон

Эрхэм нандин Мормоны Ном

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ СТИВ ЖЭЙМС

Мормоны Ном та нарт хэр үнэ цэнтэй вэ? Хэрэв та нарт алмаз, бадмаараг эсвэл Мормоны Ном өгвөл та нар алийг нь сонгох вэ? Мормоны Ном бол Бурханы үг. Энэ нь Есүс Христийн тухай заадаг.

Мормоны Номыг өдөр бүр уншихад би та нарыг урьж байна. Сурч буй зүйлийнхээ талаар залбирч мөн тунгаан бод.

Үүнийг биелүүлбэл би та нарт дараах зүйлсийг амлаж байна.

- **Та Аврагчтай илүү ойртож байгаагаа мэдэрнэ.**
- **Та өдөр бүр илүү сайн шийдвэр гаргадаг болно.**
- **Тэнгэрлэг Эцэг танд тусалж, сүнслэг удирдамж өгнө.**
- **Сорилт бэрхшээлүүдийг даван туулах боломжтой болно.**
- **Энэ нь таныг тайтгаруулж, хүчирхэгжүүлж мөн баяр хөөрийг мэдрүүлнэ.**
- **Өөрчлөлтүүд, бүр гайхамшиг ч тохиолдож эхлэх болно.**

"Израилыг цуглуулах ажил дахь эгч нарын оролцоо," 2018 оны 10-р сарын Ерөнхий чуулган, *141–144 ба "Мормоны Ном: Үүнгүйгээр таны амьдрал ямар байх байсан бэ?"* 2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган, *55–59-өөс сэдэвлэн авав.*

Мормоны Ном та нарт хэр үнэ цэнтэй вэ?

Энэ жил бид эрхэм нандин Мормоны Номын тухай түүх, гэрэл зураг болон зургуудыг цуглуулж байна. Бид тэдгээрийг дэлгэцэн дээр тавьж мөн заримыг нь сэтгүүл дээр нийтэлнэ.



Ари К., 9 настай, Мексик, Нуэво Леон

Намайг уншиж сурахад ээж надад Мормоны Ном өгөөд, баптисмдаа бэлтгэн, энэ номыг уншихыг надаас хүссэн юм. Түүнээс хойш би энэ номыг өдөр бүр уншдаг болсон. Лихайн Лиахонаг олсон түүхэнд би дуртай.

Кэйла С., 7 настай, Мексик, Мехико

"Амьдралын мод," Рассэлл К., 8 настай, АНУ, Хойд Каролина

Би сургууль дээрээ ангийнхаа нэг хүүхдэд Мормоны Ном өгсөн.

Фэлипэ М., 9 настай, Бразил, Сан-Пауло

БИДЭНД ӨӨРСДИЙН УРАН БҮТЭЭЛИЙГ ЭСВЭЛ ТУРШЛАГЫГ ИЛГЭЭГЭЭРЭЙ!

1. Мормоны Номын тухай зураг зурж, гэрэл зураг авч, ямар нэгэн зүйл бич.
2. Дараа нь бидэнд илгээгээрэй! Зааврыг арын хавтаснаас үзнэ үү.
3. Хүүхдүүд Мормоны Номыг унших ерөнхийлөгч Нэлсоны урилгыг хэрхэн дагаж байгаар үзэхийг хүсвэл сар тутмын *Найз* сэтгүүлийг үзээрэй.

Батбаяр ба зураг

Ричард М.Ромни
Сүмийн сэтгүүлүүд
(Бодит түүхээс сэдэвлэв)

Монголд салхитай өдөр болж байв. Есөн настай Батбаяр хүү хичээлээ тараад, автобусны буудлаас гэртээ харьж явна. Тэр хувцсандаа улам бүр шигдэнэ. Аз болоход түүний гэр өвөө, эмээ хоёрынх нь гэрээс хол-гүй байдаг байв.

Батбаяр гэрт нь орж ирээд, "Сайн уу?" гэж мэндлэв.

"Ашгүй, хүү минь ирлээ. Би *хуушуур* хийсэн" гэж эмээ нь хэлэв.

Батбаяр "Баярлалаа!" гээд, бүлээнээрээ байгаа халуун ногоотой хуушуур луу гараа явуулав.

"Түр хүлээгээрэй! Номлогчдыг иртэл битгий ид. Тэд тун удахгүй ирнэ" гэж өвөө нь хэллээ.

Батбаяр өвөө, эмээ хоёрынх нь гэрт Сүмийн номлогчдыг ирэхэд дуртай байдаг байв. Тэр тэднээс үргэлж их зүйл сурдаг байв. Гэвч нэг асуудал байлаа.

"Тэд надаас дахиад л Мормоны Номоос уншсан уу гэж асуух болов уу?" гэж Батбаяр асуув. "Уншина гэдэг миний хувьд амаргүй зүйл шүү дээ.

Тиймээс тэд өнөөдөр өөр ном авчирч байгаа" гэж эмээ нь хэллээ.

"Ямар ном?" гэж Батбаярыг лавлан асуухад

"Чи удахгүй харна аа" гэж өвөө нь хэлэв.

Тун удалгүй номлогчид ирлээ. Тэд хамтдаа эмээгийн хийсэн сайхан амттай махтай хуу-шуурыг идэв. Дараа нь Батбаяр "Эмээ та хоё-рыг надад ном авчирсан гэж хэлсэн" гэхэд

Хэйц эгч "Чамд энэ ном таалагдана гэж би бодож байна. Энэ ном олон зурагтай" гэж хэллээ.

Батбаяр хавтсыг нь харав. *Мормоны Номын түүхүүд* гэж тэр уншлаа. Хавтсан дээр усан онгоц барьж байгаа хүмүүсийн зураг байв.

"Би энэ түүхийг санаж байна" гэж Батбаяр хэлэв. "Тэр хүн усан онгоцыг яаж барихаа мэдэхгүй байсан ч залбирсан. Харин Бурхан түүнд тусалсан" гэлээ.

"Яг зөв" гэж Энхтуяа эгч хэлээд, "Чи энэ номыг уншиж үзэх үү? Дараа нь чи заасан зүйл нь үнэн эсэхийг мэдэхээр залбирч бол-но шүү дээ" гэлээ.

Батбаяр "Тэгье" гэж амлав.

Орой нь тэр зурагтай номоосоо уншлаа. Тэр усан онгоцны түүхийг уншаад залбирав. Тэр усан онгоц барьсан хүний тухай болон

тай ном



Бурхан түүнд хэрхэн тусалсан тухай бодож байгаад унтчихсан аж.

Түүнээс хойш Батбаяр орой болгон нэг түүх уншаад, залбирдаг болов. Бас орой бүр уншсан зүйлээ бодож байгаад унтдаг боллоо.

Эмэгтэй номлогчид дараа нь ирэхдээ Батбаярт Есүс Христийн тухай илүү ихийг зааж өгчээ. Батбаяр бошиглогчдын тухай, мөн Бурханы зарлигуудын талаар суралцлаа. Тэр өвөө, эмээтэйгээ хамт сүмд явж, номоо уншиж мөн залбирсаар байв.

Нэг өдөр Батбаяр өвөө, эмээ хоёртоо нэг чухал зүйл хэлэхийг хүслээ. “Зурагтай номон дээрх түүхүүдийг унших үед надад сайхан мэдрэмж төрдөг. Би залбираад тэдгээрийг үнэн гэдгийг мэдэрсэн. Би баптисм хүртэх хэрэгтэй гэж бодож байна” гэж хэлэв.

Өнөөдөр Батбаяр Сүмийн гишүүн болсон. Тэр улам бүр сайн уншдаг болсон. Тэр Мормоны Номыг орой болгон уншдаг хэвээрээ! ●

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КЭВИН КИЙЛ

Номлогчид Батбаярт хэрхэн тусалсан бэ? Хэн танд тусалсан бэ?

Сайн байна уу? Монголоос мэндчилж байна!

Монгол улс гурван сая гаруй хүн амтай. Үүнээс 12000 орчим нь Сүмийн гишүүн. Энэ зурган дээрээс танай гэр бүлтэй адил төстэй юуг та олж харсан бэ? Юу нь өөр байна вэ?

Монгол бол Ази тивд, Хятад, Орос хоёрын дунд оршдог улс юм.

Монголд хүнээсээ илүү олон морь бий! Монгол наадмаар морь уралдаж, сур харваж, бөх барилдаж, бүжиглэж, амттай хоолоор дайлдаг.

Энэ бол The Book of Mormon буюу *Мормоны Ном юм.*

Монголын олон гэр бүл нийслэл Улаанбаатар хотод амьдардаг.



Харин бусад нь хөдөө амьдардаг. Тэд *гэр* хэмээх урцанд амьдардаг ба сарлаг, морь, тэмээ зэрэг мал малладаг.

Сарлаг нь үхрийн төрөлд багтдаг үсэрхэг амьтан юм!

Зарим монгол найзтай минь танилцана уу!

Есүс Христ бол Бурханы Хүү бөгөөд Тэр надад болон бүх хүүхдэдээ хайртайг би мэднэ. Би Сүмд очоод, Есүсийн тухай суролцдаг болохоор Сүмдээ болон Хүүхдийн хэсэгтээ явах дуртай.

Билэгт, 7 настай

Бидэнд амьд бошиглогч, ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон байгааг би мэднэ. Тэр үнэн зүйлсийг заадаг.

Гэрэлчимэг, 4 настай

Та Монголд амьдардаг уу? Бидэнд захидал бичээрэй! Бид таныг сонсохыг хүсэж байна!

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КЭТИ МАКДИЙ

Жой Д.Жонс
Хүүхдийн хэсгийн ерөнхий ерөнхийлөгч

Өдөр бүр өмнөхөөсөө арай илүү бай

Би багадаа хийл тоглодог байв. Би хийлээ гоё дуугарган, эцэг эхдээ тоглож үзүүлэн, тэднээр “Жой, гайхалтай байна” гэж хэлүүлэхийг хүсдэг байв. Гэвч хийл маань тийм ч сайхан сонсогддоггүй, чахран дуугардаг байлаа.

Заримдаа намайг давтаагүй үед багш маань “Жой, чи энэ долоо хоногт давтаагүй юм уу?” гэж асуудаг байв. Энэ нь намайг дараагийн долоо хоногт илүү сайн тоглохын тулд давтах хүслийг төрүүлдэг байв.

Эргээд харахад хийл тоглох нь хэцүү байсан тул надад сайн туршлага болсон. Хэдийгээр би давтахыг заримдаа хүсдэггүй байсан ч өдөр бүр бага багаар давтах зорилго тавьснаар маш их зүйлийг сурсан юм.

Та нарыг ч бас үүний адил хийж үзээсэй гэж би хүсэж байна. Өдөр бүр өмнөхөөсөө илүү дээр байхыг хичээ. Тэнгэрлэг Эцэг чамайг бүх зүйлийг нэгмөсөн хийгээсэй гэж хүсдэггүй. Амьдрал бол бага багаар суралцаж, өсөж хөгжих явдал юм. Тэр чамайг бууж өгөлгүй хичээгээсэй гэж хүсдэг. Тэр бас чамайг өсөж хөгжиж байгаадаа баярлаасай гэж хүсдэг.

Заримдаа бид өөртөө хатуу ханддаг. Бид “Би чадсангүй. Би үүнийг хийж чадахгүй нь” гэж бодон, бууж өгдөг. Гэвч Аврагч “Үргэлжлүүл, Би чамд тусална! гэдэг. Есүс Христийн ачаар бид аливаа зүйлийг ганцаараа хийх шаардлагагүй. Бид босоод, Түүний тусламжтайгаар дахин оролдож үзэж болно. Би үүний л төлөө амьдардаг.

Тэнгэрлэг Эцэг чамд хайртай гэдгийг зүрх сэтгэлдээ мэдрээсэй гэж би хүсэж байна. Чамд хүнд хэцүү зүйл тулгарч болох ч чи энэ цаг үед дэлхийд ирэхээр бэлтгэгдсэн гэдгээ санаарай. Зүгээр л үргэлжлүүлэн, гэрлээсээ хуваалцаарай. Тэнгэрлэг Эцэг тань гэрээний замаа дагах үед чамайг адислан, чиглүүлэх болно. ●



Сүм 7 ба түүнээс дээш насны хүүхдүүдэд зориулан шинэ *Хүүхдийн гарын авлага* гаргасан. Энэ нь чамд тусалж, өсөж хөгжихөд тань туслах болно.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ЖЭННИФЭР БРИКИНГ

Есүс шиг өсөж том болох нь

Есүсийн чиний насан дээр байхдаа өсөж хөгжсөн арга замаар өсөж том болоход тань туслах шинэ *Хувийн хөгжил: Хүүхдийн гарын авлага*-ыг ашиглаарай. Энэ нь бас шинэ зүйлсэд суралцах хөгжилтэй арга юм!

Сүнслэг

Есүс Бурханы таалалыг олсон.

Нийгмийн

Есүс хүмүүсийн таалалыг олсон.

Бие махбодын

Есүсийн бие өсөж том болж байв.

Оюун санааны

Есүс мэргэн ухаанаар өсөж байв.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БРАД КЛАРК

"Есүсийн мэргэн ухаан, бие хаа өссөөр байсан агаад Бурханы хийгээд хүмүүсийн таалал Түүнд байлаа" (Лук 2:52).

Уучлалт



Минчан К., 11 настай,
Кёнги-До, Өмнөд Солонгос

Нэг өдөр сургууль дээр манай ангийн хэдэн хүүхэд нэг сурагчийг муухайгаар дуудан, шоолж байв. Надад хөгжилтэй санагдсан тул би тэдэнтэй нийлсэн. Хэдэн долоо хоног би найзуудтайгаа хамт түүнийг шоолов.

Хэд хэдэн долоо хоног өнгөрсний дараа тэр хүү надад өөрт нь ямар байгааг хэлж билээ. Тэр бидний шоолохыг сонсоогүй юм шиг өнгөрч байсан ч бидний хэлсэн үгэнд гомдсон байв. Түүнийг орой бүр уйлдаг байснаа ярихад би уйлах шахаж билээ. Би түүнд туслахыг хүссэн ба хэлсэн үгэндээ уучлал гуйхаар шийдэв.

Тэгээд маргааш нь түүн рүү явж очин, мөрөн дээр нь гараа тавиад, “Чамайг шоолж байсанд намайг үнэхээр их уучлаарай” гэлээ. Намайг ийн хэлэхэд тэр толгой дохин, нүдэнд нь нулимс цийлэгнэв. Гэвч бусад хүүхэд түүнийг шоолсоор л байв. Дараа нь би Хүүхдийн хэсгээс “Зөвийг сонго”-х талаар сурснаа санасан юм.

Би ангийнхандаа зоригтойгоор “Түүнийг шоолохоо боль! Та нар түүнд ямар хэцүү байгааг мэдэх үү? Хийсэн болгоныхоо төлөө уучлал гуйж, түүнтэй найзал” гэв.

Гэвч тэд миний хэлснээр амархан өөрчлөгдсөнгүй. Харин ч тэд надад уурлаж, “Чи гэнэт юу болов? Чи ч гэсэн түүнийг шоолдог байсан биз дээ?” гэв.

Би өмнө нь хийсэн зүйлдээ харамсаж байлаа. Тиймээс би “Би түүнээс уучлал гуйсан. Би та нарыг түүнд ямар байгааг ойлгож, түүнийг шоолохоо болиосой гэж хүсэж байна” гэлээ.

Тэдний нэг нь уучлал гуйж, бид гурав сайн найзууд болсон юм. Зарим нь түүнийг одоо ч гэсэн шоолдог ч түүнд бид хоёр байгаа тул хамаагүй дээр байх болсон. Би найздаа хэрэгтэй үед нь тусалснаар зөвийг сонгох болно. ●



САЙХАН СЭТГЭЛИЙН УРИЛГА

Хэрэв чи сургууль эсвэл Хүүхдийн хэсэг дээр шинэ хүүхэд ирвэл түүнтэй инээмсэглэн мэндлээрэй.

Мормоны Номыг хэрхэн унших тухай найман санаа

1. **Унших найзаа олоод, хамтдаа унш.**
2. **Есүс Христийн тухай мөрүүдийг тэмдэглэ.**
3. **Дуртай түүхээ зур. (Тэгээд зургаа бидэнд илгээгээрэй! Н3 хуудсыг үзнэ үү.)**
4. ***Мормоны Номын түүхүүд* гэсэн зурагтай номоос унш.**
5. **Н12 хуудсан дээрх будах хуснэгтийг ашигла.**
6. **Судраа Gospel Library аппликэйшнээс сонс.**
7. **Дуртай түүхээ жүжигчлэн тогло.**
8. **Мормоны Номын видео бичлэгүүдийг онлайнаар үз.**



ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ СТИЙВ КЭЙМС

Чи энэ жил H14 хуудсан дээр байгаа долоо хоног тутмын шүлгүүдийг уншин, *Ирээд, Намайг дага* хичээлүүдийг дагах боломжтой. Дараа нь эдгээр хуудсан дээрх ижил хэлбэртэй зайнуудыг будаарай. Мормоны Номыг уншихад Есүс Христийн талаарх гэрчлэл чинь улам бүр нэмэгдэх болно!



Би Мормоны Ном

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ НАСАН ХАРДКАСТЛ

мыг уншиж чадна

Мормоны Ном унших хүснэгт

Дараах судрын шүлгүүд 2020 оны долоо хоног тутмын *Ирээд, Намайг дага* сэдвийн хичээлүүдтэй уялдана.

1. Мормоны Номын удиртгал, 1 ба 8–9-р догол мөрүүд
2. 1 Нифай 3:7; 4:1, 4–8, 17, 38
3. 1 Нифай 8:10–12, 19–22
4. 1 Нифай 11:1–6, 24–27
5. 1 Нифай 16:18–20, 23–24, 28–31
6. 2 Нифай 2:25–28
7. 2 Нифай 9:49–52
8. 2 Нифай 25:23, 26, 29
9. 2 Нифай 27:23–26
10. 2 Нифай 31:4–12, 20
11. Иаков 4:6–8, 12–13
12. Иаков 5:71–75
13. Инос 1:3–12
14. 2 Нифай 9:6–8, 11
15. Алма 7:11–13
16. Мозая 2:5–7, 17–19
17. Мозая 4:9–12
18. Мозая 8:16–18
19. Мозая 13:1–5
20. Мозая 18:1, 8–16
21. Мозая 27:23–26
22. Алма 2:27–31
23. Алма 5:14–16
24. Алма 8:14–22
25. Алма 14:26–28
26. Алма 19:16–17, 28–30
27. Алма 26:12–16
28. Алма 31:31–38
29. Алма 32:26–31
30. Алма 37:6–7, 33–37
31. Алма 40: 9, 23–25
32. Алма 46:12–15
33. Алма 56:44–48, 56
34. Хиламан 5:12–14
35. Хиламан 10:2–7
36. Хиламан 13:2–3; 14:2–8
37. 3 Нифай 1:8–15
38. 3 Нифай 11:8–17
39. 3 Нифай 12:13–16
40. 3 Нифай 17:6–10, 20–24
41. 3 Нифай 19:25–28
42. 3 Нифай 20:3–9
43. 3 Нифай 27:3–10
44. Мормон 1:2–5
45. Мормон 9:21–25
46. Ифер 3:4–14
47. Ифер 6:3–9, 12
48. Ифер 12:27–29
49. Моронай 4:1–3; 5:1–2
50. Моронай 7:45–48
51. Моронай 10:3–6, 32
52. 1 Нифай 11:16–23

Мормоны Ном Христийг гэрчилдэг

Баяр хөөртэй ♩ = 72

Үг, аяыг Нэйтан Хау



© 2020 Nathan Howe. Бүх эрх хамгаалагдсан.
Энэхүү дууг арилжааны бус зорилгоор сүмд болон гэр бүлийн хэрэгцээнд зориулан олшруулж болно.
Мэдэгдлийг олшруулсан хуудас бүрд оруулна уу.

Мормоны Номын хайчлах зургууд

Лихай, Сариа нарын гэр бүлийн түүхийг жүжигчлэн тоглохын тулд эдгээр зургийг хайчилж ав. Та Нифайн эгч, дүүсийг болон эд зүйлсийг нь зурж, нэмж болно!

Нифай гуулин ялтаснуудыг авав.
1 Нифай 4

Лихай Лиахонаг хүлээн авав.
1 Нифай 16:9–11, 16

Нифай нумаа хугалав.
1 Нифай 16:17–24, 30–31

Нифай усан онгоц барив.
1 Нифай 17:7–11, 16–18, 52–55

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ СИМИНИ БЛОКЭР

Би сүм дээр судраас суралцах дуртай. Гэхдээ гэрийнхэн маань судраас уншдаггүй бол би хэрхэн гэртээ судлах вэ?
—Зальцбург дахь эрэлхийлэгч

Хүндэт Эрэлхийлэгч ээ,

Танай гэр бүлийнхэн судраас суралцдаггүй ч чи суралцаж чадна гэдгээ санаарай. Өдөр бүр бага багаар, бие даан уншихыг хичээ. Чи H12 – H14 хуудсан дээрх унших хүснэгтийг ашиглаарай. Өөр санаа авахыг хүсвэл H11-р хуудсыг уншина уу.

Чи судрыг ганцаараа ч бай, бусадтай хамт уншсан ч бай Ариун Сүнс чамтай хамт байх болно.

Чи ганцаараа биш!

Найз

Жич: Энэ бол чамд зориулсан судрын хавчуурга юм! Үүнийг хайчилж аваад, наа.

"Бурханы хүүхдийг Түүний талаар болон Хайрт Хүүгийнх нь талаар илүү ихийг мэдэхийг эрэлхийлэх үед **ГАЙХАМШИГТАЙ** зүйл тохиолддог. **МОРМОНЫ НОМООС** өөр хаана ч эдгээр үнэнийг илүү тодорхой, илүү хүчтэй заадаггүй.

Рассэлл М.Нэлсон, "Мормоны Ном: Үүнгүйгээр таны амьдрал ямар байх байсан бэ?" 2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ С.Б.КАНГА

Хамгийн сайхан тэврэлт!

Лори Фут
(Бодит түүхээс сэдэвлэв)

Элли аавдаа болон эмээ өвөөдөө, бас ээждээ тэврүүлэх дуртай. Тэврүүлэх нь түүнд дулаахан, аюулгүй, аз жаргалтай мэдрэмж төрүүлдэг.

Иймээс Элли сүм дээр ээжийгээ тэврсээр байв. Тэр ээжийнхээ өвөр дээр суух дуртай. Ээж нь түүнийг үргэлж энгэртээ тэврнэ.

Тэгээд ариун ёслол дуусаж, Хүүхдийн хэсэгт орох цаг боллоо. Эллид Хүүхдийн хэсэг их таалагддаг. Тэр одоо

3 настай том охин болсон! Тэр бүр өөрийн гэсэн судартай болсон гээч!

Гэвч Элли өнөөдөр ээжийгээ тэврээд л баймаар байв.

Ээж нь Эллиг ангид нь хүргэж өгөөд, Хүүхдийн хэсгийн ангид оруулан, сандал дээр нь суулгалаа.

"Би тантай явж болох уу?" гэж Элли асуув.

"Үгүй ээ" гэж ээж нь хариуллаа. Ээж нь эелдгээр "Чи ангидаа, би ч бас ангидаа байх хэрэгтэй" гэв.

Ээж нь Эллигийн хацар дээр үнсээд, хаалга руу явлаа.

Эллигийн хацрыг даган нулимс бөмбөрөв.

Тэр ээждээ тэврүүлж байна гэж бодлоо. Ээж нь Мормоны Номоос уншихдаа түүнийг байнга тэвэрдэг байв. Тэд бараг дандаа гэр бүлээрээ хамт уншдаг ч, заримдаа Элли ээжтэйгээ хоёулхнаа уншдаг.

Элли Мормоны Номоо авав. Дотор нь Есүсийн зураг байлаа.

Элли номоо хаагаад, энгэртээ наав. Түүнд яг л Есүсийг тэвэрч байгаа мэт санагджээ. Тэр дулаан, аюулгүй, аз жаргалтай мэдрэмж мэдрэв. Энэ хамгийн сайхан тэврэлт байлаа! ●

Эллиг гуниглахад юу түүнд сайхан мэдрэмж төрүүлсэн бэ?

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ЭЛИЗ БЛАК

Нифай гуулин ялтаснуудыг авсан нь

Лихай, Сариа хоёрын гэр бүл амлагдсан нутаг руу явж байв. Бурхан Лихайд хөвгүүдээ Иерусалим руу илгээж, судруудыг авчруул хэмээн хэлжээ. Тэдгээр нь төмөр ялтсан дээр бичигдсэн байв.

Лемен, Лемүел хоёр үүнийг дэндүү хэцүү байна гэцгээлээ. Харин Нифай би явж, Бурханы зарлигласан зүйлсийг хийх болно гэв. Сам Нифайн үлгэр жишээг дагалаа.

Сүнс Нифайд Лебен гэгч ёс бус эрээс гуулин ялтаснуудыг хэрхэн авахыг хэлж өгөв.

Нифай болон түүний ах нар гуулин ялтаснуудыг гэр бүлдээ эргүүлэн авчирчээ. Лихай, Сариа хоёр баяр хөөрөөр дүүрэв! Тэд ялтаснууд дээрх судруудыг судлан, Бурханы зарлигуудын талаар суралцав.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АПРИЛ СТОТТ

Би найз нөхдөдөө судруудаас суралцахад нь тусалж чадна. Би Нифай шиг зоригтой байж, “явж мөн Бурханы зарлигласныг хийх” болно. ●

Энэ түүхийн талаар 1 Нифай 3–5-аас уншина уу.

Лихайн гэр бүл судруудыг судалдаг байжээ

Судалт гардаг түүхүүдээс чи алинд нь дуртай вэ?

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АПРИЛ СТОТТ

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

Эрхэм хүндэт эцэг эхчүүд ээ,

Бид шинэ оныг та нартай хамт эхлүүлж байгаадаа баяртай байна! Бид Мормоны Номын талаар хамтдаа суралцах болно. Танай гэр бүлд Мормоны Номын аль түүх таалагддаг вэ? Хүүхдүүдээ зураг зурж, бидэн рүү илгээхэд нь туслаарай (Н3 хуудсыг үзнэ үү). Бид тэдгээр зургийн заримыг нь энэ жил сэтгүүлдээ тавих болно. Энэ дугаарын Мормоны Номын тухай зарим хуудсыг оруулав.

- Бошиглогчийн захиас (Н2 хуудас)
- Уншлагын хүснэгт (Н12–Н14 хуудас)
- Судрын түүхийн үйл ажиллагаа (Н16 хуудас)
- (Н20–Н23 хуудас)
- Мормоны Номыг унших шинэ арга зам олсон хүүгийн тухай түүх (Н4–Н5 хуудас)

Шинэ оны мэнд хүргэе!
Найз

ХҮҮХДИЙНХЭЭ БҮТЭЭЛ ЭСВЭЛ ТУРШЛАГЫГ ЛИАХОНА СЭТГҮҮЛ РҮҮ ХЭРХЭН ИЛГЭЭХ ВЭ?

Та liahona.ChurchofJesusChrist.org вэбсайт руу ороод, "Submit an Article or Feedback" дээр дарна уу. Эсвэл үүнийгээ хүүхдийнхээ нэр, нас, оршин суугаа хот болон "Би, [нэрээ бич], Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд хүүхдийнхээ илгээж буй зүйлийг Сүмийн сэтгүүл, вэбсайтуудад болон хэвлэл мэдээллийн бусад тавцан мөн Сүмийн тайлан, хэвлэх материал, дүрс бичлэг, хэвлэл, сургалтын материалууд дээр ашиглахыг зөвшөөрч байна" гэсэн зөвшөөрлийн маягтын хамт liahona@ChurchofJesusChrist.org хаягаар илгээнэ үү. Бид тантай холбогдохыг тэсэн ядан хүлээж байна.



Дотор нь нуусан Лиахонаг олоорой!

ГАРЧИГ

Н2 Тэргүүн Зөвлөлөөс: Эрхэм нандин Мормоны Ном
Н4 Батбаяр ба зурагтай ном
Н6 Сайн байна уу? Монголоос мэндчилж байна!
Н8 Өдөр бүр өмнөхөөсөө арай илүү бай
Н9 Есүс шиг өсөж том болох нь . . .
Н10 Сайхан сэтгэл чухал: Уучлалт
Н11 Мормоны Номыг хэрхэн унших тухай найман санаа
Н12 Би Мормоны Номыг уншиж чадна
Н15 Дуу хөгжим: Мормоны Ном Христийг гэрчилдэг
Н16 Зугаатай ажил: Мормоны Номын хайчлах зургууд
Н17 Та юу гэж бодож байна вэ?
Н18 Хамгийн сайхан тэврэлт!
Н20 Судрын түүхүүд: Нифай гуулин ялтаснуудыг авсан нь
Н23 Будах хуудас: Лихайн гэр бүл судруудыг судалдаг байжээ

***НАЙЗ* СЭТГҮҮЛИЙН ХАВТСАН ДЭЭР**
Зураг чимэглэлийг Эндрью Босли

© 2020 BY INTELLECTUAL RESERVE, INC. БҮХ ЭРХ ХАМГААЛАГДСАН

MONGOLIAN
4 02167 16363 3